

Эмнести Интернэшнл

Эмнести Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичигт заасан хүний эрхийг дэлхийн хүн бүрт эдлүүлэх чиглэлээр ажилладаг дэлхий даяарх хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Хүний бүхий л эрхийг хмагаалахын төлөөх өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд бие махбод, сэтгэл санаагаар бүрэн бүтэн байлгах буюу чөлөөтэй сэтгэн бодох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрх, эрх чөлөөг ноцтой зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор судалгаа хийх ба үйл ажиллагаа явуулж бодитой арга хэмжээ авдаг.

Ингэхдээ дараах үндсэн чиглэлд тулгуурлаж кампанит ажил явуулдаг. Үүнд

- Хүний эрхийн зөрчил үйлдэгсэдтэй хариуцлага тооцохыг уриалах
- Хүний эрхийг үр дүнтэйгээр хамгаалахыг засгийн газруудаас шаардах
- Хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэхийг уриалах
- Хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа явуулах зэргийг дурьдаж болно

Эмнести Интернэшнл нь дэлхийн 150 гаруй улс оронд 2.2 сая гаруй гишүүд дэмжигчидтэй бөгөөд тэднийхээ хандив, тусламж, татвараар санхүүждэг.



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчдэд

Дэлхийн олон нийтийн дэмжлэг хүлээсэн Эмнести Интернэшнл хүний эрхийн олон улсын байгууллагын үйл ажиллагааг бид Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж эхэлснээс хойш 10 гаруй жилийн нүүр үзэж байна.

Дэлхий даяар явуулж байгаа олон улсын кампанит ажил болон дотоод хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн тухай боловсрол мэдлэгийг дээшлүүлэх үйлсэд хамтран ажилласан та бүхэндээ гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагын хувьд 2007 он ажил үйлсээр арвин баялаг, нэр хүндээ өсгөж чадсан, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэн тэлсэн амжилт бүтээлээр дүүрэн жил байлаа. 2008 он үүнээс дутахааргүй байна гэдэгт итгэл дүүрэн байна.

Хүний эрхийн төлөө ариун үйлсэд нэгдэж, хамтран зүтгэж байгаа та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Академич С. Нарангэрэл
Удирдах зөвлөлийн дарга



С. Эрдэнэ, олон улсын эрх зүйч мэргэжилтэй, Монголын Эмнести Интернэшнлийн дэд дарга



Ц.Оюунбаатар, Улсын их хурлын гишүүн асан. Консенсус төвийн тэргүүн. Монголын Эмнести Интернэшнлийн Парламентын бүлгийн ахлагч, Кампанит ажил хариуцсан зөвлөх



С.Ганчимэг, Монгол Энэтхэгийн хамтарсан сургуулийн сургалтын менежер, Монголын Эмнести Интернэшнлийн Багш нарын бүлгийн ахлагч, Санхүү хариуцсан зөвлөх



П.Жаргал, Ийгл телевизийн орчуулагч, редактор. Хэвлэл мэдээлэл хариуцсан зөвлөх



Р. Оюунбадам, гавьяат хуульч, Шихихутаг дээд сургуулийн багш, Сан арвижуулалт хариуцсан зөвлөх, Сан арвижуулах хорооны гишүүн



Ц.Монгол, "ХААН" банкны хуулийн зөвлөх, Монголын Эмнести Интернэшнлийг үүсгэн байгуулагчдын нэг. Бүлэг, гишүүнчлэлийн асуудал хариуцсан зөвлөх



Ш. Анхмаа, "Authentic tour" компаний захирал. Монголын Эмнести Интернэшнлийн Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч, Хүний эрхийн боловсрол хариуцсан зөвлөх



Г.Гангамөрөн, Сэтгүүлч мэргэжилтэй, Сувдан сор сэтгүүлийн эрхлэгч, Залуучуудын асуудал эрхэлсэн зөвлөх

2007 онд Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөл ээлжит хурал 6 удаа, ээлжит бус хурлыг 4 удаа нийтдээ 10 удаа хуралдаж, байгууллагын үйл ажиллагаа, сан арвижуулах болон бүлэг, гишүүд дэмжигчдийн идэвхи санаачилга хүрээг нэмэгдүүлэх стратеги төлөвлөгөө, төсөв, тайлан илтгэл, байгууллагын эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдах зөвлөлийн гишүүний үүрэг, үнэлгээний шалгуур, зарим холбогдох дүрэм журмуудыг боловсруулж, батлах олон улсын хурлын төлөөлөгчдийг сонгох зэрэг олон асуудлаар оновчтой шийдвэр гаргаж ажилласан байна.



Д.Энхбаяр, өмгөөлөгч, нотариатч,
Монголын Эмнести Интернэшнлийн
Хяналтын зөвлөлийн дарга



Б.Мөнхжавхлан,
МУИС-ийн философийн багш,
Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүн



Г.Амаржаргал,
Сэтгүүлч, Сэтгүүлчдийн бүлгийн
гишүүн



Б.Алтантуяа, Гүйцэтгэх захирал



А.Отгончимэг, Өсөлт хөгжил
хариуцсан зохицуулагч



Т.Баярмаа, Санхүүгийн ажилтан,
Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн
асуудал хариуцсан зохицуулагч



Г.Амарзаяа, Кампанит ажлын
зохицуулагч



Э.Отгончулуун, Кампанит ажлын
зохицуулагч



Карл Уэтам, Сан арвижуулах
зохицуулагч ба хөгжлийн асуудал
хариуцсан зөвлөх

ЦАГ БОЛОН МЭДЛЭГЭЭ ХАНДИВЛАГЧ САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

Монголын Эмнести Интернэшнлийн Сайн дурынхан нь ЭИ-ийн хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн боловсрол олгох их үйлсэд сургалт сурталчилгаа, кампанит ажил зохион байгуулах, холбогдох мэдээллийг орчуулах, түүнийг түгээх, тараах материал бэлдэх, гишүүд дэмжигчидтэй харилцах зэргээр өөрийн үнэт цагаа харамгүй зарцуулж, дундаршгүй мэдлэг чадвараа үнэ хөлсгүйгээр зориулдаг гишүүд, дэмжигчид хүний эрхийн идэвхтнүүд юм.

2007 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад гадаадын 3, Монголын 40 гаруй сайн дурын ажилтан ажиллалаа.

Александр Харти



Швейцарийн иргэн, сайн дурын ажилтан Александр Харти Эмнести Интернэшнлийн залуучуудын бүлгийнхэнд 2007 оны 5 дугаар сард Хүний эрхийн боловсролын талаархи англи хэлний цуврал хичээлийг заалаа. Мөн 6 дугаар сарын 30-нд зохиогдсон “Эрхийнхээ төлөө шуугицгаая” кампанит ажилд оролцож хамгийн сайн сан арвижуулагчаар шалгарлаа. Тэрээр Нарс зусланд болсон “Хүний эрхийн боловсрол” зуны сургалтад оролцож хүүхдүүдийн дунд хэлэлцүүлэг зохион явуулж тэдэнтэй санал солилцон нэгтгэн дүгнэж, хүний эрхийн талаархи ном товхимол гаргахад орчуулагч редактороор ажилласан юм.

Сан Ким



АНУ-ын иргэн, санхүүгийн менежментээр мэргэшсэн одоогоор Бээжин хотноо хэлний чиглэлээр суралцаж байгаа Сан Ким нь Монголын Эмнести Интернэшнл байгууллагад 7 хоногийн хугацаанд сайн дурын ажилтнаар үр бүтээлтэйгээр ажиллалаа. Энэ хугацаанд Хятад оронд эрх нь зөрчигдсөн хүмүүсийн төлөө зурагт хуудас бэлтгэж, Хятадын засгийн газрын эрх баригчдад хандан гарын үсэг зуруулах үйл ажиллагааг Залуучуудын бүлгийн гишүүдтэй хамтран Оюутны талбайд зохион байгууллаа. Мөн Эмнести Интернэшнлийн зохион явуулсан. Бирмийн лам нарын төлөөх кампанит ажилд идэвхтэй оролцлоо.

Роберт Слинн



эрхийн өдрөөр эрх нь зөрчигдсөн хүмүүсийн эрхийг хамгаалахын төлөө гарын үсэг зуруулах үйл ажиллагаанд оролцов.

Английн VSO сайн дурын байгууллагын ажилтан бөгөөд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад сайн дурын ажилтнаар ажиллаж байна. Тэрээр залуучуудын бүлэгтэй хамтран Эрдэнэт, Дархан хотод Идэвхтэн залуучуудын бүлэг байгуулах ажилд сургагч багшаар оролцлоо. Мөн Олон улсын Хүний

Г.Гангамөрөн



Сэтгүүлчдийн бүлгийн ахлагч. 2005 оны шилдэг сайн дурын ажилтнаар шалгарч байсан. 2007 онд “Эрхийнхээ төлөө шуугицгаая” кампанит ажлын бэлтгэл хийгээд зохион байгуулах үйл ажиллагааг явуулж хамтлаг дуучдыг тус үйл ажиллагаанд уриалан татаж оролцуулах ажилд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллалаа. Тэрээр Эмнести Интернэшнлийн үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, зохион байгуулах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай ажилладаг сайн дурын ажилтан юм.

Д.Оюунномин



Эмнести Интернэшнл байгууллагын чөлөөт бүлгийн ахлагч. Сэтгэл зүйч мэргэжилтэй. ШУТИС-ийн докторант. Эмнести Интернэшнлд гишүүнээр элссэн цагаас эхлэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа сайн дурын ажилтан бөгөөд 2004 онд шилдэг сайн дурын ажилтнаар шалгарч байсан. 2007 онд цаазаар авах ялын эсрэг, эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажилд оролцож Хорих байгууллагын боловсрол төслийн зохицуулагчаар сайн дураар үнэ хөлсгүйгээр үр бүтээлтэй ажилласан юм. Энэ төслийн хүрээнд “Кино хэлэлцүүлгээр амьдрах чадвар олгож, хандлагыг өөрчлөх нь” сургагч багшийн гарын авлагыг бичиж хэвлүүлсэн юм. Эмнести Интернэшнлийн эрхлэн гаргаж буй ном товхимолд

редактороор ажиллаж өөрийн үнэт цаг, мэдлэгээ хандивладаг.

Б.Мөнхжавхлан



Философич, нийгмийн ухааны багш мэргэжилтэй. МУИС-ийн НШУС-ийн философийн тэнхим, МИУ их сургуульд цагийн багшаар ажиллаж байна. Эмнести Интернэшнлийн сайн дурын ажилтан тэрээр Хорих байгууллагуудын боловсрол төслийн сургалтад оролцжээ.

Сар бүрийн Эмнести Интернэшнлийн Wire сонин бичиг болон шаардлагатай кампанит ажлын талаархи мэдээллүүдийг орчуулах, хянаж редакторлох болон тус байгууллагаас эрхлэн гаргадаг ном товхимолуудын техник редакторын ажлуудыг хийж гүйцэтгэх зэргээр өөрийн мэдлэг, цагийг Эмнести Интернэшнлд хандивладаг.


Г. Ганжаргал



МИУ дээд сургуулийн оюутан. Монголын Эмнести Интернэшнлийн Залуучуудын бүлгийн идэвхтэй гишүүдийн нэг. Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд залуучуудын сонирхолыг татах, чадавхийг сайжруулахад санаачилгатай ажиллаж, Нацагдоржийн номын санд байрлах Америкийн Соёлын төв дээр

Цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн өдөр, Хүүхдийн эрхийн өдрөөр англи хэлээр илтгэл тавьж, кино хэлэлцүүлэг өрнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө”, “Зэвсэглэлийг хяная”, захидал уриалга илгээх зэрэг Эмнести Интернэшнлээс зохион явуулсан кампанит ажлуудад идэвхтэй оролцжээ. Бие дааж үйл ажиллагаа зохион байгуулах чадвар сайтай.

М.Буянхишиг



ШУТИС-ийн Цахилгаан Электроникийн ангийн 2 дугаар курсын оюутан. Монголын Эмнести Интернэшнл байгууллагын сайн дурын ажилтан бөгөөд “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлуудад оролцсон. Багануур дүүрэгт

16 гишүүнийг удирдаж “Хятадын Олимп-2008”, Бирм, Азербайжан зэрэг улсуудын засгийн газарт хандаж хүний эрхийн төлөө гарын үсэг цуглуулсан.

Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр зохиогдсон үйл ажиллагаануудад идэвхтэй сайн оролцсон. Мөн интернэт кафед тараах материал, загварыг бэлтгэжээ. М.Буянхишиг нь Монголын Эмнести Интернэшнлд 7 хоногт 5 орчим цагийг зориулж мэдлэг оюунаа хандивладаг.

Э.Солонго



МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн 2 дугаар курсийн оюутан. 2006 оны 11 дүгээр сард гишүүнээр элссэнээс хойш байгууллага дээр 7 хоногт 3 цагаар ажиллаж энэ хугацаанд кампанит ажлуудын орчуулга хийж, Эмнести Интернэшнлийн номын сангийн каталоги бүртгэх, шинэчлэх ажлыг хариуцан ажиллаж байна.

Сая сая дүр төрх аяны хүрээнд зураг авах, “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” зэрэг ажлуудад бэлтгэл үйл ажиллагааг хийж биечлэн оролцжээ. Мөн “Зэвсэглэлийг хяная” кампанит ажлын үеэр хүний эрхийн төлөө гарын үсэг цуглуулсан байна.

Б.Мөнхтуяа



МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн төгсөх курсийн оюутан. 2006 оны 3 дугаар сард Монголын Эмнести Интернэшнлийн залуучуудын бүлэгт элссэн бөгөөд 7 хоногт 2-оос доошгүй цагийг зориулж сонин хэвлэл, албан бичиг түгээх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Тэрээр

2007 онд Зэр зэвсгийг хяная кампанит ажлын хүрээнд Сая Сая дүр төрх аяны зураг авах, бүртгэл хөтлөх, Бүх гишүүдийн уулзалт, Удирдах зөвлөлийн хурлуудын бэлтгэл ажлыг хангах, Бизнес ба хүний эрх сэдэвт оюутан залуучуудын дунд явуулсан үйл ажиллагаанд оролцсон байна.

Ч.Золжаргал



МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн 2 дугаар курсийн оюутан. 2006 оны 11 дүгээр сард гишүүнээр элссэнээс хойш байгууллага дээр 7 хоногт 3 цагаар ажиллаж энэ хугацаанд кампанит ажлуудын баримтжуулалтыг хийж, Эмнести Интернэшнлийн номын сангийн каталоги бүртгэх,

шинэчлэх ажлыг хариуцан ажилласан. Тэрчлэн Цаазаар авах ялын эсрэг кампанит ажлын сургалтын бэлтгэл ажил, “Сая сая дүр төрх” аяны хүрээнд зураг авах, “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” ажлуудад бэлтгэл үйл ажиллагааг хийж биечлэн оролцжээ. Мөн “Зэвсэглэлийг хяная” кампанит ажлын үеэр хүний эрхийн төлөө гарын үсэг цуглуулжээ.

Л.Галбаатар



МУИС-ийн Хууль Зүйн сургуулийн 2 дугаар курсийн оюутан. 2007 оны 11 дүгээр сард элссэнээс хойш Эмнести Интернэшнлийн зохион явуулсан Оюутны эрхийн өдрөөр МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” кампанит ажил, “Сая Сая дүр төрх” аяны хүрээнд зураг авах Олон улсын Хүний эрхийн өдөрт зориулсан үйл ажиллагаанд тус тус оролцоод байна. Л.Галбаатар Эмнести Интернэшнлийн шинэ гишүүний бүртгэлийг хариуцан компьютерт мэдээллийг оруулах, захидал уриалгад гарын үсэг зуруулах зэрэг үйл ажиллагааг хариуцан явуулж 7 хоногт 4 цагийг зарцуулан мэдлэг чадвараа хандивлаж байна.

З.Балдорж



ШУТИС-ийн Компьютер Дизайны ангийн төгсөх курсын оюутан. Монголын Эмнести Интернэшнлийн үйл ажиллагаануудад олон жил оролцож байгаа идэвхтэй гишүүдийн нэг. Тэрээр тус байгууллагад сургалт кампанит ажлуудад хэрэглэгдэх зар сурталчилгаа, тараах материалын загвар гаргах, хэвлүүлэх, залуучуудын үйл ажиллагааг зохион байгуулж идэвхижүүлэх ажлуудыг гүйцэтгэн өөрийн үнэт цагаа хандивладаг. Мөн “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” зэрэг ажлуудад зохион байгуулагчаар оролцжээ.

Н.Лхагвасүх



МУИС-ийн Газар зүйн сургуулийн Шатах ашигт малтмалын 2 дугаар курсын оюутан. Тэрээр “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр “МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” зэрэг ажлуудад зохион байгуулагчаар оролцжээ. Тэрээр Эмнести Интернэшнлд зохион байгуулагддаг кампанит ажлуудын бэлтгэл ажлууд болон кампанит ажлуудыг зохион байгуулах олон ажлыг хийж гүйцэтгэхэд 7 хоногт 2 –оос дээш цагийг зарцуулж өөрийн мэдлэг оюунаа хандивладаг.

М.Гэрэлмаа



Монголын Эмнести Интернэшнлийн Залуучуудын бүлгийн ахлагч. МУИС-Хууль зүйн сургуулийн 3 дугаар курсын оюутан. Эмнести Интернэшнл байгууллагын идэвхитэй гишүүн бөгөөд долоо хоногт 20 гаруй цагийг зориулдаг. Хийж гүйцэтгэсэн ажлаас дурдвал:

- Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд залуучуудын сонирхолыг татах, чадавхийг сайжруулах зорилгоор Хүний эрхийн англи хэл дээрх сургалтыг долоо хоног бүр, Илтгэх урлаг, Мэтгэлцээн, Сан арвижуулалт зэрэг сургалт, хүний эрхийн зуны хөтөлбөрт Эмнести Интернэшнлийн залуучуудын бүлгийн гишүүдийг оролцуулах,
- “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө”, “Зэвсэглэлийг хяная” зэрэг Эмнести Интернэшнлээс зохион явуулсан кампанит ажлуудад тухайлбал Олон улсын Хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдөр, Цаазаар авах ялын эсрэг өдрөөр оюутан залуучуудыг кампанит ажилд татан оролцуулах, кампанит ажлын захидал уриалга, хэвлэлийн мэдээ бэлтгэх,
- Залууст хүний эрхийг таниулах зорилгоор Цаазаар авах ял, Бизнес ба хүний эрх зэрэг хэлэлцүүлгийг зохион байгуулж, илтгэл тавих, Эрдэнэт Дархан хотод Идэвхитэн залуучуудын бүлэг байгуулахад оролцсон байна.

С.Тодгэрэл



МУИС-ийн ЭЗДС-ийн Эдийн засаг-хүн ам зүйн ангийн оюутан. Тэрээр “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” үйл ажиллагаанд оролцох зэргээр олон ажилд өөрийн цаг заваа хандивлалаа. Тэрээр Эмнести

Интернэшнлийн бүх гишүүдийн уулзалтын бэлтгэл ажил, залуучуудын бүлгийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажилд идэвхийлэн оролцож 7 хоног 2 цагийг Эмнести Интернэшнлд зарцуулж байна.

Д.Одончимэг



ШУТИС-ийн Нийгмийн халамж зүйн ангийн оюутан. Эмнести Интернэшнлийн номын сангийн каталоги бүртгэх, шинэчлэх ажлыг хариуцан ажиллаж, кампанит ажлуудын орчуулга хийж тусладаг. Сая сая дүр төрх аяны хүрээнд зураг авах, “Эрхийнхээ төлөө шуугицгаая”, “Дарфурын

төлөө” кампанит ажлууд, Олон улсын хүний эрхийн өдөр, Оюутны эрхийн өдрөөр МУИС, ШУТИС, МУБИС, ЭМШУИС, ХААИС зэрэг сургуулиуд дээр зохион байгуулсан “Эрхээ эдлэж чадвал шоколад шиг амтагдана” зэрэг ажлуудад бэлтгэл үйл ажиллагааг хийж биечлэн оролцжээ. Мөн “Зэвсэглэлийг хяная” кампанит ажлын үеэр хүний эрхийн төлөө гарын үсэг цуглуулжээ.

Б.Мөнгөнзаяа



“Best” сургалтын төвийн багш. Монголын Эмнести Интернэшнл байгууллагад сайн дурын ажилтнаар ажиллаж зохион байгуулж буй ажлуудад идэвхитэй оролцож байна. Эрхийнхээ төлөө шуугицгаая кампанит ажил, Дарфурын төлөө, Бирмийн кампанит ажлуудад оролцож бэлтгэл



ажлыг хангах болон гарын үсэг цуглуулах ажлуудад оролцсон байна. Б.Мөнгөнзаяа Эмнести Интернэшнлд шаардлагатай кампанит ажлуудын материал орчуулах зэрэг олон чухал ажлуудыг хийж гүйцэтгэдэг юм.

Дадлагын оюутнууд



Монголын Эмнести Интернэшнл байгууллагад Монгол улсын их дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнууд мэргэжлийн дадлага ажлыг хийдэг. Үүнд байгууллагын зорилго үйл ажиллагаатай танилцах, зохион байгуулж буй үйл ажиллагаануудад хамтран

оролцох мөн кампанит ажлуудыг зохион явуулахад идэвхтэй оролцдог. 2007 онд МУИС-ийн ОУХДС-ийн оюутан Батчулуун, Нямгэрэл нар дадлагын оюутнаар ажиллалаа.



ҮЙЛ АЖИЛЛАГАА

КАМПАНИТ АЖИЛ

1. Цаазаар авах ялын эсрэг

“Цаазын тавцан дээр” гэрэл зургийн үзэсгэлэн
Цаазаар авах ял ба нууцлал сэдэвт хэлэлцүүлэг
Нөлөөлөл ба хамтын ажиллагаа
Цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн өдөр
Хэвлэл мэдээллийн чиглэлээр

2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох

Ойлголт, мэдлэг өгөх, гэгээрүүлэх ажил
Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр
Охидын аюулгүй байдал
Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид
Боолын орчин үеийн хэлбэр болох хүний наймааны эсрэг
Нөлөөлөл хамтын ажиллагаа

3. Эрүүдэн шүүхийн эсрэг

Шударга бус явдлын илэрхийлэл
Эрүүдэн шүүхийн хохирогсдод туслах олон улсын өдөр
Хэвлэл мэдээлэл
Нөлөөллийн үйл ажиллагаа
Хорих газарт тавих иргэний нийгмийн мониторинг

4. Зэвсгийг хянах

Тоглоомон буу солих хөтөлбөр
Сая сая дүр төрх
Кавейрао үйл ажиллагаа

5. Хямралд хариу өгөх ажиллагаа

Дарфур
Бирм

6. Эдийн засаг нийгэм соёлын эрх

Бизнес ба хүний эрх
Хүний эрхийн хамгаалагчдыг чадавхижуулах
Нөлөөлөл, хамтын ажиллагаа

7. Эрхээ хамгаалж захидал бичигцгээе

8. Эрхийнхээ төлөө шуугицгаая

9. Олон улсын эрүүгийн шүүх

10. Улс орнуудын төлөө

Хятад
ОХУ

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Өсөлт
Залуучууд
Төлөвлөлт, шийдвэр гаргах түвшний оролцоо ба тайлагналт
Хүний эрхийн боловсролын номын сан
Сан арвижуулах ажиллагаа
Олон улсын хурал уулзалтууд

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

Хүний эрхийн боловсрол-чанартай боловсрол
Хорих байгууллагуудын боловсрол
ХЭТТ-ын 60 жил-Бидний амьдралд
Хүүхэд залуучуудад зориулсан зуны сургалт
Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь гарын авлага ба сургалт

ХЭВЛЭСЭН МАТЕРИАЛ

- Цахим хуудас
- “Хүнийг хүндэтгэе” танилцуулга
- Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалах эрхийг баталгаажуулах нь мэргэжлийн цуврал гарын авлага
- Хүний эрхийн боловсрол сонин бичгийн тусгай дугаар
- Хүний эрхийн боловсрол залуучуудын идэвхит санаачлага
- Эрүүдэн шүүж зүй бус харьцахын эсрэг танилцуулга
- Кино хэлэлцүүлгээр амьдрах чадвар олгож, хандлагыг өөрчлөх нь
- Хорих байгууллагын боловсрол /Багшийн дэвтэр/
- Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь 2 дахь хэвлэлт
- Иргэн тантай яаж харьцах ёстой вэ гарын авлага
- Олимпын өмнөх үе : Хүний эрхийн амлалтаа биелүүлээгүй байна /тайлан/
- Бүтээлч кампанит ажлын гарын авлага
- Хүний эрхийг Иргэний боловсролоор сурах нь /багшийн гарын авлага/
- The Wire сонин бичиг
- Цаазаар авах ял ба хүний эрх судалгааны тайлан
- Боолчлолын орчин үеийн хэлбэр ба хүний наймаа

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА АУДИТЫН ДҮГНЭЛТ

Цаазаар авах ялын эсрэг кампанит ажил

2007 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас цаазаар авах ялыг халахыг дэмжигч хүмүүсийн хүрээг тэлэх, олон нийтийг гэгээрүүлэх, Монгол улсын Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял оноох зүйл заалтыг цөөрүүлэхэд нөлөөлөх, гүйцэтгэлийг тойрсон нууцлалтай холбоотой асуудлыг хөндөн гаргаж ирэх, хэтдээ халуулах зорилго тавин ажиллаж дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн чиг хандлага

Цаазаар авах ял нь хүний амьд явах эрхийг туйлын байдлаар үгүйсгэсэн харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон ял шийтгэл мөн хэмээн олон улсын хүний эрхийн судлаач шинжээчид үздэг. Үүний зэрэгцээ цаазаар авах ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж чаддаггүй болох нь НҮБ-ын судалгаагаар тогтоогдсон бөгөөд мөн энэ ялыг шударга бусаар оноох эрсдэл их гардаг байна. Тухайлбал АНУ нь 1977 онд цаазаар авах ялыг дахин хэрэглэж эхэлснээс хойш 122 хоригдлыг цагаатгажээ. Мөн Хятад улсад цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн нэг нь ч нэн даруй өмгөөлөгчөөр хангагдах, гэм буруугүйд тооцогдох, эрүүдэн шүүж авсан нотлох баримтыг үнэлэхгүй байх, шүүгчид улс төрийн хөндлөнгийн оролцооноос ангид байх гэх мэт олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд нийцсэн шударга шүүхээр шүүлгээгүй байна.

Өнөөдөр дэлхийн улс орны гуравны хоёр нь буюу 133 орон цаазаар авах ялыг хуулиндаа болон практикт халаад байна. Үүнээс 90 орон цаазаар авах ялыг бүрэн халж, 11 орон зөвхөн онцгой тохиолдолд хэрэглэхээр зааж, 32 орон практикт халж, сүүлийн 10 гаруй жил ялын гүйцэтгэл хэрэгжүүлээгүй байна. Үлдсэн Хятад, Иран, АНУ зэрэг 64 орон цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа боловч тэдгээрийн зарим нэг оронд ял оноох хэргийн тоо буурсаар байна.

Дэлхий нийтээр цаазаар авах ялын гүйцэтгэлийг зогсоох тухай тогтоолыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Гуравдахь хороогоор хэлэлцэж баталлаа. Үүнд 99 орон дэмжиж, 52 орон эсрэг санал өгч, 33 улс түдгэлзсэн бөгөөд харамсалтай нь Монгол улс энэхүү тогтоолын эсрэг санал өгсөн байна.

“Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэн




Хүмүүнлэг ардчилсан нийгэмд цаазаар авах ял нь ямар ч хэрэггүй, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон ял шийтгэл мөн гэдгийг олон нийтэд таниулах үүднээс Нигери улсын Инугу шорон дахь цаазаар авхуулах ялтай хоригдлуудын хоригдож байсан нөхцөл байдлын талаарх бодит байдлыг

дүрсэлсэн зургийн үзэсгэлэнг нэг сарын турш зохион байгууллаа.

Монгол Францын төвтэй хамтран зохион байгуулсан уг үзэсгэлэнг 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр нээж, Монгол дахь Францын Элчин сайдын Яамны Элчин Зөвлөх Дидье Гильберт, Монгол улсын хууль тогтоогчид, хүний эрхийн ТББ-ууд, Монгол Францын хамтарсан ТББ, хууль эрх зүйн багш судлаачид, оюутнуудыг урьж оролцуулан хэлэлцүүлэг өрнүүллээ.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагын тэргүүн Академич С.Нарангэрэл МЭИ-ээс МУИС-ын ХЗС зэрэг бусад байгууллагуудтай хамтран явуулсан “Цаазаар авах ял ба Хүний эрх” судалгааны тайланг танилцуулав. Монгол дахь Францын Элчин сайдын Яамны Элчин Зөвлөх Дидье Гильберт цаазаар авах ялыг халах дэлхий нийтийн чиг хандлага болон Европын Холбооны улсуудын цаазаар авах ялыг халсан байдал тэр дундаа 1981 онд Франц улс нь ялын дээд хэмжээг хэрхэн халсан тухай дэлгэрэнгүй ярилаа. МЭИ байгууллагын УЗ-ийн гишүүн, “Лобби төв”-ийн ерөнхийлөгч Ц.Оюунбаатар 2007 оны 2 дугаар сарын 1-3-ны хооронд Францын Парис хотноо болсон Цаазаар авах ялын эсрэг Дэлхий нийтийн 3-р Конгресст оролцсон тухайгаа илтгэл тавилаа.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид цаазаар авах ялын талаарх өөрсдийн дэмжиж байгаа болон эсрэг байр сууриа илэрхийлсэн юм. Мөн сэтгүүлчид монгол улс дахь шүүх ажиллагааны явц, Франц улс цаазаар авах ялыг





халах хүртлээ хичнээн хугацаа туулсан болон хэрхэн халсан талаар асууж хариулт авлаа. Хэлэлцүүлгийн төгсгөлд “Цаазын тавцан дээр” зургийн үзэсгэлэнгийн талаар товч танилцуулан оролцогчдыг үзэсгэлэнд урьсан юм.

Тус үзэсгэлэнд цаазаар авахуулах ялаар шийтгүүлэн Нигерийн Инугу шоронд 9 жил хоригдоод хүний эрхийн идэвхтнүүдийн уриалгын дагуу өршөөлөөр суллагдсан Артур Юдаи Энжелийн өөрийн хамт хоригдож байсан цаазаар авахуулах ялтай хоригдлуудын хоригдож байсан нөхцөл байдлын талаар зурсан зургуудыг дэлгэн үзүүлээ.

Ял эдлэх хугацаандаа Артур нь үй олноор нь буудан хороох болон дүүлжэх ялын гүйцэтгэл, эрүүдэн шүүхийн гэрч болж байжээ. Энэ бүхний тухай 2x2.5м харьцаатай, цонхгүй камер, цаасан хайрцагаар хийсэн дэвсгэрүүд, ганц ширхэг бие засах хувин бүхий гяндангийн өрөөнд 13—лаа хоригдож байсан зэргийг өөрийн зурсан зургаар дүрслэн үзүүлсэн юм. Артур Юдаи Энжел нь 2000 онд суллагдсаныхаа дараагаар цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн тэмцэлд нэгдсэн юм. Түүний “Цаазын тавцан дээр” нэртэй энэ үзэсгэлэн нь 2004 онд Лагос дахь Нигерийн Үндэсний Музейд тавигджээ. Артур нь Нигерийн Бүтээлч Зургийн Хөдөлгөөн ТББ-ын гишүүн бөгөөд өөрийн “Би үхмээргүй байна” хэмээх гар бичмэлээ нийтлүүлэхээр бэлтгэж байгаа аж. Артур бол цаазаар авах ялаар шийтгүүлж байсан мянга мянган Нигеричүүдийн нэг юм. Тэрээр үй олноор нь хороож байсан он жилүүдэд, ялангуяа тэр үеийн цэргийн дэглэмийн үеэр өршөөгдөж чадсанаараа хувьтай хүн билээ.



Монголын Эмнести Интернэшнл байгууллагын сайн дурын ажилтан Английн иргэн Карл Уэтам нь Артур Юдаи Энжелтэй холбоо тогтоон түүний зурсан зургуудын фото хувилбараар үзэсгэлэнг гаргах эрхийг авах, мөн үзэсгэлэнг зохион байгуулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Артур Юдаи Энжел нь үзэсгэлэнг үзэж байгаа хүмүүст хандан захидал ирүүлсэн байна. Үүнд:

“Урьд нь цаазаар авахуулах ялаар шийтгэгдэн хоригдож байсны хувьд би цаазын ял сонсохоос эхлээд цаазын тавцан хүртэлх ичгүүргүйгээр хүний эрхийг зөрчиж байсан алхам бүрийг, хүний үнэргүй үйл ажиллагааны талаар бүхнийг ярьж чадна.

Цаазаар авах ял нь хүнлэг бус, хүний ёсноос гажууд, нэр төрийг доромжилсон зүйл бөгөөд гэм зэмгүй хүмүүс ч өртөж болно.

Төр засаг бусдын амийг хөнөөх замаар иргэдэд бусдыг хөнөөхгүй байхыг сэрэмжлүүлэх нь утгагүй бөгөөд санаатайгаар хэрэг хийсэн хэрэгтэнд ч гэсэн ийм ял оноох нь хүртэл нэг ёсны аллага юм. Нэгийн амийг нөгөөгөөр төлнө гэдэг шударга хэрэг биш бйгд энэ нь зөвхөн өшөө авалт л болно. Цаазаар авах нь шийтгэл бус хүний ёсноос гажууд зүйл юм.

Би Монголын ард түмэнд болон засгийн газарт хандан цаазаар авах ялыг халахыг уриалж байна.

Артур Юда Энжел

Цаазаар авахуулах ялаар шийтгүүлж байсан Нигери дэх Амьдралын гүүр /LifeBridgel-н Ерөнхийлөгч / Үндэслэн байгуулагч “

Дээрх үзэсгэлэнг зохион байгуулснаар цаазаар авах ялын хор хөнөөлийг олон нийтэд ухуулан таниулах, гэгээрүүлэх зорилгодоо хүрч чадлаа.

Үзэсгэлэнд оролцсон хэвлэл мэдээллийн байгууллагууд TV-5, С-1 телевизүүд үзэсгэлэнгийн талаар олон нийтэд мэдээлж, Өнөөдөр, Үг, Зиндаа, Өдрийн сонин, The Mongol Messenger, Өнөөдрийн Монгол сонины газрууд цаазаар авах ялын талаарх сэдвийг хөндөж “Цаазын тавцан дээр”, “The death penalty-to abolish or to keep?” “Цаазаар авах ялыг эсэргүүцлээ”, “ Цаазаар авах ялыг халахыг уриалав” гарчигтайгаар нийтлэлүүд гаргасан байна.

“Цаазаар авах ял ба Нууцлал” сэдэвт хэлэлцүүлэг

• Хэлэлцүүлэг зохион байгуулах сургалт

Цаазаар авах ялын талаарх дэлхий нийтийн статистик тоо баримт болон бусад холбоотой баримт бичгүүдийг орчуулан гаргаж, “Цаазаар авах ял ба нууцлал” сэдвээр хүний эрхийн болон хуулийн байгууллагын ажилтнуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх тухай сургалтыг хуульчдын болон сэтгүүлчдийн бүлгийн гишүүдэд явууллаа. Сургалтанд оролцсон гишүүд дараах хэлэлцүүлгүүдийг амжилттай удирдан явуулж чадсанаар цаазаар авах ялыг халахад нөлөөлөл үзүүлэх хүрээний хуулийн байгууллагын ажилтнуудад дэлхий нийтийн чиг хандлагыг таниулах зорилгодоо хүрч чадлаа.



• Хэлэлцүүлэг

“Цаазаар авах ял ба Нууцлал” сэдвийн хүрээнд Улаанбаатар хот, Орхон, Дархан-уул аймгуудад цуврал семинар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Энэхүү семинар хэлэлцүүлгүүдээр хуулийн байгууллагын ажилтнуудын дунд цаазаар авах ялын талаарх ойлголт, цаазаар авах ялыг халах эсэх асуудал, дэлхийн нийтийн чиг хандлага, Монгол дахь цаазаар авах ялыг хэрэгжүүлж буй нөхцөл байдал, үүнтэй холбоотой хүний эрхийн зөрчил, гүйцэтгэл тойрсон нууцлал зэрэг олон асуудлыг хөндөн гаргаж ирсний зэрэгцээ цаазаар авах ялыг хэрэгжүүлэх, ногдуулах хүрээнд хамгийн ойр ажилладаг субъект болох цагдаа, прокурор, шүүх, өмгөөллийн байгууллагын нэгээхэн хэсэг төлөөлөл болон бусад хүний эрхийн ТББ, хувь хүмүүст дээрх чиглэлээр мэдээлэл өгөх, харилцан санал солилцох, хэлэлцүүлэг өрнүүлэх, тэдний тогтсон үзэл хандлагыг өөрчлөх, ухуулан таниулах ажлыг хийхэд энэхүү хэлэлцүүлгийн гол зорилго оршиж байлаа.

Хэлэлцүүлгийн үеэр “Цаазаар авах ял ба дэлхийн нийтийн чиг хандлага”, МЭИ байгууллагаас хийсэн “Цаазаар авах ял ба Хүний эрх” судалгааны тайлан, “Цаазаар авах ял ба Нууцлал” сэдвүүдээр танилцуулга хийж, МЭИ-ийн Урлагийн бүлэгтэй хамтран бүтээсэн цаазаар авах ял ба дэлхийн нийтийн чиг хандлага, Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэх явцад гарсан их хэлмэгдүүлэлт, олон улсын тоо баримт мэдээлэл, холбогдох хүмүүсийн үзэл бодлыг тусгасан богино хэмжээний баримтат кино болон “Үхдэл явж байна” киноны хэсгээс үзүүлээ.

Хэлэлцүүлгийн цагаар Монгол улсын Эрүүгийн хуульд заасан цаазаар авах ял оноож байгаа зүйл заалтыг цөөрүүлэх, хасах, цаашлаад бүхэлд нь халах боломж байгаа эсэх, мөн гүйцэтгэлийг тойрсон нууцлалын асуудлыг хөндөн ярилцлаа.

• Улаанбаатар хот-Хамтарсан хэлэлцүүлэг

2007 оны 5-р сарын 18-ны өдөр хүний эрхийн ТББ-ууд, ХЗДХЯ, ХЭҮК, ХЗҮТ, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, цаазаар авах ялаар шийтгүүлэгчдийн ар гэрийнхэн, шүүх, прокурор, өмгөөлөгч, шашны байгууллагыг урьж оролцуулсан уг хэлэлцүүлгийг гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, МЭИ-ийн

Сэтгүүлчдийн бүлгийн гишүүд Г.Гангамөрөн, Энхбаатар, Эрдэнэханд, Хуульчдын бүлгийн гишүүд Б.Энхтуяа, С.Цэмбэлмаа нар зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт дээрх байгууллагуудын төлөөлөл болсон 35 хүн оролцож өмгөөлөгчид голдуу цаазаар авах ялыг халахыг дэмжиж байсан бөгөөд шүүх байгууллагын төлөөлөл Монголын өнөөгийн нийгэмд цаазаар авах ялыг халах цаг нь болоогүй хэмээсэн байр сууриа илэрхийлж байлаа.

• Дархан-Уул аймаг

2007 оны 10-р сарын 27-ны өдөр МЭИ-ийн Хуульчдын бүлгийн гишүүд Б.Энхтуяа, С.Цэмбэлмаа, А.Түвшинтулга нар Дархан-Уул аймгийн Цагдаагийн хэлтсийн хурлын танхимд зохион явуулсан уг хэлэлцүүлэгт шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаагийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нийлсэн 31 хүн оролцлоо. Дархан-Уул аймгийн Лха болон орон нутгийн телевиз энэ семинар хэлэлцүүлгийн нутгийн олон нийтэд хүргэлээ.



• Улаанбаатар хот – Хууль Зүйн Сургуулийн багш нарын дундах хэлэлцүүлэг

2007 оны 11-р сарын 30-ны өдөр Лобби төвийн хурлын танхимд зохион явуулсан хэлэлцүүлэгт 10 гаруй хууль зүйн сургуулийн эрүүгийн эрх зүйн багш нарыг урьж оролцууллаа. УЗ-ийн гишүүн, Лобби төвийн захирал Ц.Оюунбаатар хэлэлцүүлгийг нээж, хуульчдын бүлгийн гишүүд өмгөөлөгч С.Цэмбэлмаа, А.Түвшинтулга, Эрүү шүүлт, Цаазаар авах ялын эсрэг кампанит ажлын зохицуулагч Г.Амарзаяа нар хөтлөн явууллаа.

• Орхон аймаг

2007 оны 12-р сарын 08-ны өдөр Орхон аймгийн Цагдаагийн хэлтсийн хурлын танхимд шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаагийн ажилтнууд нийт 44 хүн оролцсон хэлэлцүүлгийг хуульчдын бүлгийн гишүүд өмгөөлөгч С.Цэмбэлмаа, А.Түвшинтулга, УЗ-ын гишүүн өмгөөлөгч Р.Оюунбадам, Эрүү шүүлт, Цаазаар авах ялын эсрэг кампанит ажлын зохицуулагч Г.Амарзаяа нар хөтлөн явууллаа.

Дүгнэлт

Оролцогчдыг бүлэг болгон ажиллуулснаар Монгол улсын эрүүгийн хуульд заасан цаазаар авах ял оногдуулж байгаа 6 төрлийн гэмт хэргээс тоог цөөрүүлэх, хэртээ халах боломж байгаа эсэхэд хуулийн байгууллагын ажилтнуудын төлөөллийн санаа бодлыг сонсож нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

- Эрүүгийн хуулийн заалтын хүний амь бусниулах үйлдлийг хийгээгүй байж болох талтай гэмт хэрэг болон “Зандалчлах”, “Төрлөөр устгах” энэ төрлийн хоёр хэргийн хувьд манай улсын хувьд гараагүй учир заавал цаазаар авах ялыг ногдуулах боломжтой хэргийн тоог нэмэгдүүлэн дээрх зүйл ангийг байлгах нь зохимжгүй байж болох талтай. Тиймээс эдгээр зүйлүүдийг Эрүүгийн Хуулиас хасч болох юм гэсэн саналыг бүлгүүд дэвшүүлж байлаа.

- ЭХ-ийн 91.2 /бусдыг санаатай алах/; 126.3 /хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүчиндэх/ гэсэн гэмт хэрэг зонхилон гарч, үүнд цаазаар авах ялыг ногдуулж байна гэж бүх бүлгүүд дүгнэсэн байна.

- Цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлэх асуудал дээр бүлгүүд мөн харилцан адилгүй байр сууринаас хандаж байсан бөгөөд нэг хэсэг нь гүйцэтгэлийг түдгэлзүүлэх нь хэрэгтэн өршөөл үзэх буюу гэм буруугүй нь тогтоогдвол цагаатгагдах боломжтойг дурдаж, түдгэлзүүлэх асуудал дээр ялтны санал хүсэлтийг сонсох хангах зорилгоор хүлээлгэж болох тухай заалт эрүүгийн хуульд байж болно гэсэн санал дэвшүүлж байлаа.

- Өмгөөлөгчид голдуу цаазаар авах ялыг халах хэрэгтэй гэсэн саналыг дэвшүүлж байсан бол шүүгч прокурор нар голдуу хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзэж байлаа.

- Цаазаар авах ялын гүйцэтгэл, уучлал үзүүлэх журмын нууцлалтай холбоотойгоор илтгэгчийн зүгээс дэвшүүлсэн асуудлуудад цаазаар авах ял ногдуулсан этгээдэд уучлал үзүүлэх журам, бусад тоо баримтыг нууцлах нь оновчтой биш гэсэн саналыг оролцогчид дэмжиж байв.

- Дээрх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах явцад оролцогчдын нэлээд их хувь нь Монгол улсад цаазаар авах ялыг халах цаг нь болоогүй, нийгмийн сэтгэл зүй бүрдээгүй гэсэн үзэл баримтлалтай байсан нь боловч өмгөөлөгчид, шашны тэргүүнүүд, голдуу цаазаар авах ялыг халах нь зүйтэй гэсэн байр суурьтай байлаа. Дээрх хэлэлцүүлгүүд нь дэлхий нийтийн чиг хандлага, Монгол улс дахь цаазаар авах ялын талаар хийсэн судалгааны тайлан, нууцлалын асуудлаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх зорилгодоо хүрч чадсан бөгөөд нийт хуулийн байгууллагын ажилтнууд, төрийн болон хүний эрхийн ТББ-ууд, шашны тэргүүнүүд, ХЗС-ын багш нар, хэвлэл мэдээллийнхэн зэрэг 120 гаруй оролцогчдыг хамрууллаа.

Цаазаар авах ялыг гүйцэтгэх, уучлалт хүсэх журам зэргийг нууцлах нь төдийлөн оновчтой бус түүнчлэн цаазаар авах ялыг юуны өмнө халах эсэх асуудлаас гадна өөр боломжууд тухайлбал оногдуулж буй хэргийн тоог цөөрүүлэх, тухайлсан зарим хэргийн зүйлчлэлийн асуудлыг эргэн харах, хасах зэрэг

боломж байж болохыг хуульчид хэлэлцүүлгийн үеэр хөндөж байсан нь энэхүү хэлэлцүүлгийн үр дүн юм.

Энэчлэн цаазаар авах ялын талаарх ойлголт мэдлэг, мэдээлэл, дэлхийн нийтийн чиг хандлага хуульчдын дунд дутмаг байгаа нь ажиглагдсан бөгөөд энэхүү семинар, хэлэлцүүлэг нь тодорхой мэдээллийг багцаар нь хүргэж, тухайн оролцогчдын санал бодлыг тандах, тэдгээрт зөв ойлголт төрүүлэх зэрэгт зохих үр дүнгээ өгсөн билээ.

Нөлөөлөл ба хамтын ажиллагаа

Олон улсын хэмжээнд Ираны эрх баригч нарт хандан Иран улс нь Иргэний болон Улс төрийн Эрхийн олон улсын Пакт, Хүүхдийн эрхийн Конвенцид нэгдэн орсныхоо хувьд олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэн насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд цаазын ял оноох, гүйцэтгэхээ зогсоохыг шаардан нийт 40 гаруй гарын үсэг бүхий захидлыг илгээлээ.

Дотооддоо Монгол улсын ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд, УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх нарт хандан 2007 оны 11 дүгээр сард хуралдах НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 62 дахь Чуулганаар хэлэлцэгдэх Дэлхий нийтээр цаазаар авах ялын гүйцэтгэлийг зогсоох /моратори тогтоох/ тухай тогтоолыг дэмжсэн санал өгөх нь тус улс хүний амьд явах эрхийг баталгаатай хангаж чадах хүмүүнлэг ардчилсан улс болохоо дэлхий нийтэд харуулах томоохон алхам болохыг дурдсан албан захидлыг Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас гаргасан Зөвлөмжийн хамт хүргүүлэв.

Ерөнхийлөгчийн Хуулийн Бодлогын Зөвлөхөөс бидний саналыг цаашид судлан үзэх болно гэсэн хариултыг ирүүлсэн байна.

Нийслэл хотын захирагчид хандан Ромын Сандиего нийгэмлэгээс Эмнести Интернэшнл болон Цаазаар авах ялын эсрэг Дэлхий нийтийн эвсэлтэй хамтран жил бүрийн 11 дүгээр сарын 30-нд зохион байгуулдаг “Амьдралын төлөөх хотууд” үйл ажиллагаанд нийслэл Улаанбаатар хотыг оролцуулахыг уриалсан захидал уриалгыг илгээлээ.

Энэ өдөр Киргизстаны нийслэл Бишкек хотоос эхлэн Мадагаскарын Атананариво хүртэл 31 орны 537 хотууд цаазаар авах ялыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлэн олон нийтэд онцгой харагдах барилга байшинг сонгон авч гэрэлтүүлэх, жагсах зэргээр тэмдэглэн өнгөрүүлдэг билээ.

Хамтын ажиллагаа

Монгол Францын соёлын төвтэй хамтын ажиллагаа тогтоож, цаазаар авах ялын эсрэг Дэлхийн 3-р Конгресст оролцох төлөөлөгчөөр МЭИ байгууллагын кампанит ажил хариуцсан УЗ-ын гишүүн Ц. Оюунбаатарыг сонгон оролцуулсан юм.

Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхэт элчин төлөөлөгчидтэй цаазаар авах ялыг халах асуудлаар уулзалт зохион байгуулж хамтран ажиллаа.

Франц, Их Британи улсын элчин сайдууд цаазаар авах ялыг халахыг дэмжиж байгаагаа илэрхийлэн Олон улсын Хүний эрхийн өдрөөр хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Цаазаар авах ялын эсрэг Дэлхий нийтийн өдөр-“Дэлхий нийт цаазын ялаас татгалзаж байна”

Жил бүрийн 10-р сарын 10-ны өдрийг дэлхий нийтээр Цаазаар авах ялын эсрэг Өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлсээр ирсэн билээ.

2007 оны “Дэлхий нийт цаазын ялаас татгалзаж байна” уриа бүхий энэ өдрөөр Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь цаазын ял нь амьд явах эрхийг туйлын байдлаар үгүйсгэсэн харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон ял шийтгэл мөн гэдгийг хүлээн зөвшөөрч хуулиндаа болон практикт халаад байгааг олон нийтэд хүргэх, мөн гэм зэмгүй хүмүүсийг шийтгэсэн тохиолдолд засаж залруулж чадахааргүй хохирол учруулдаг гэдгийг олон нийтэд таниулах зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

Нацагдоржийн номын санд байрлах Америкийн соёл мэдээллийн төв дээр уншигчдын дунд “Цаазын ял хэрэгтэй юу” сэдвээр лекц уншиж, Оскарын шагналт “Үхдэл явж байна” уран сайхны кино үзүүлж англи хэлээр мэтгэлцээн өрнүүллээ. Залуучуудын бүлгийн гишүүд Г.Ганжаргал, Ч.Золжаргал, Н.Лхагвасүх, Э.Өлзийбат, Э.Батчулуун нар мэтгэлцээнийг хөтлөн, удирдан зохион байгууллаа.



Хэвлэл ба мэдээллийн чиглэлээр

“Цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн тэмцэл”, “Морокко улс цаазаар авах ялтай хэргүүдэд өршөөл үзүүллээ”, “Цаазаар авах ялыг хэрэглэхгүй байхыг дэмжиж Далай лам илгээлт ирүүлжээ”, “Цаазаар авах ялыг хойшлуулах тогтоол баталжээ”, “Цаазаар авах ял өршөөл биш”, “Цаазаар авах ялыг хойшлуулахыг уриаллаа”, “Монголчууд цаазаар авах ялын эсрэг гэдгээ дэлхийд зарлалаа”, “Цаазаар авахуулах ялтны хоёр гар нь гавтай учраас хоолоо нохой шиг иддэг”, “Амьд явах эрхийг үгүйсгэсэн цаазаар авах ял”, “Цаазаар авахуулсан хүнийг ар гэр нь хөдөөлүүлж чаддаггүй”, “Цаазаар авах ялын гүйцэтгэлийг хойшлуулдаг больё”, “Хүүхдэд цаазаар авах ял оноосон хэмээн буруутгав”, “Цаазын ялтай хоригдлууд амиа хорлохыг хүсдэг”, “Далай лам цаазаар авах ялыг хойшлуулахыг уриаллаа”, “Өршөөл, хамгийн хатуу шийтгэл”, “Цаазаар авах ялыг халахыг уриалав”, “Донор эрхтнүүдийн 99 хувь нь цаазаар авах ял сонссон хоригдлуудынх байдаг”, “The death penalty to abolish or to keep?”, “Цаазын тавцан дээр”, “Цаазаар авах ялыг эсэргүүцлээ”, “Монголын шүүх цаазаар авах ял оноохдоо алдаа гаргах магадлал 30 хувьтай”, “Цаазаар авах ялыг халах нь сэдэвт хэлэлцүүлэг” зэрэг хэвлэлийн мэдээ мэдээллүүдийг орчуулан өдөр тутмын болон бусад сонины газруудад илгээснээр Ардын эрх, Өнөөдрийн Монгол, Өнөөдөр, Өдрийн сонин, Зиндаа, Үг, Mongol messenger, Ардчилал, Зууны мэдээ, MoNGO онлайн сонин, Хүмүүс зэрэг сонинууд нийтлэл, өгүүлэл, мэдээ мэдээлэл болгон нийтэлж олон нийтэд хүргэлээ. Мөн “Бид анхаарна” сэдвээр бичсэн Ардчилал сонины нийтлэлийг www.oloo.mn вэб хуудсан дээр байрлуулснаар онлайн хэлэлцүүлэг өрнүүлээ.

“Амьд явах эрхийг үгүйсгэсэн цаазын ял” танилцуулга



Монгол улс дахь цаазаар авах ялыг хэрэглэж ирсэн байдал, гүйцэтгэлийг тойрсон нууцлалын асуудал, олон улсын хүний эрхийн судлаач шинжээч, бие бүрэлдэхүүнүүдийн цаазаар авах ялын эсрэг байр суурь, дэлхий нийтийн тоо баримт, цаазаар авах ялыг хориглосон олон улсын баримт бичгүүд болон цаазаар авах ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлж чаддаггүй болох нь судалгаагаар нотлогдсоны зэрэгцээ гэмт хэргийн өсөлтөнд нөлөөлдөггүй болох нь тогтоогдсон бөгөөд гэм буруугүй хүмүүст оноох эрсдэл гарсаар байгаа нь энэ ялыг халах нь зайлшгүй

хэрэгтэй байгааг харуулсан “Амьд явах эрхийг үгүйсгэсэн цаазын ял” танилцуулгыг бэлтгэн 1500 хувь хэвлүүлэн олон нийтэд тарааж эхлээд байна.

Уг танилцуулгад Дээрхийн Гэгээн Арвандөрөвдүгээр Далай Лам Данзанжамцын дэлхий даяар цаазаар авах ялыг гүйцэтгэхээ зогсоох санаачилгыг дэмжсэн илгээлт. Үүнд:

“Бидний хэн нь ч үхлийг тэр тусмаа үхэх тухай бодохыг ч хүсдэггүй. Хэрэв энэ нь жам ёсоороо ирвэл бидний хэн нь ч зогсоож чадахгүй, харин зориуд санаатайгаар хүний амийг авах нь маш харамсалтай хэрэг болох юм. Цаазаар авах ял нь гэмт хэрэгтнийг алдаагаа давтахаас урьдчилан сэргийлэх, бусдыг хамгаалах үүднээс хэрэглэж байгаа шийтгэл мэт боловч хэрэв нөхцөл байдлыг маш хянамгай авч үзвэл энэ нь үнэхээр зөв шийдэл бус юм гэдгийг бид мэдэх болно. Цаазаар авах ялыг хэрэглэж байгаа орнуудад энэ ялыг хэрэглэхээ зогсоохыг уриалсан уриалгыг би чин сэтгэлээсээ дэмжиж байна...” хэмээсэн илгээлтийг оруулж өгсөн.

Цаазаар авах ялын эсрэг баримтат кино

Урлагийн бүлгийн гишүүд “Армоне студи”-тэй хамтран Монгол улсад хүний амьд явах эрхийг хангуулах үүднээс өрнүүлж байгаа Цаазаар авах ялын эсрэг кампанит ажлын хүрээнд баримтат кино хийж 2007 оны 10 дугаар сарын 10 –ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацаж хүргэлээ. Энэ баримтат кино нь Эмнести Интернэшнл байгууллагын цаазаар авах ялын эсрэг байр суурийг тодотгон харуулахын зэрэгцээ цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн чиг хандлага, статистик тоо баримт, төр засгийн зүтгэлтнүүд Монголын ард түмэнд хандан ХЭТТ-д заасан эрх, эрх чөлөөг эдлүүлэхийн төлөө бүхий л чадлаараа хичээн чармайх болно хэмээн тангараг өргөн НҮБ-ын “Том ном”-д гарын үсэг зурж байгааг, шашны тэргүүнүүдийн үзэл бодол, Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас хийсэн судалгааны талаар, Монгол улс дахь 30-аад оны их хэлмэгдүүлэлт зэргийг багтаасан байна.

Цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн өдрөөр зохион байгуулсан үйл ажиллагаа нь олон нийтийг гэгээрүүлэх, нууцлалын асуудлыг хөндөн гаргаж ирэхийг зорьсон бөгөөд Буддын шашны тэргүүнүүдийн цаазаар авах ялын эсрэг байр суурь, үзэл бодлыг харуулсан нь хүн амын нэлээд хэсэг нь буддын шашинтай манай орны хувьд цаазаар авах ялыг халахыг дэмжигчдийн хүрээг тэлэхэд ихээхэн нөлөөлөл болсон гэж үзэж байна.

Үйл ажиллагааны талаарх тайлан мэдээг Цаазаар авах ялын эсрэг Азийн сүлжээ болон Олон улсын төв, бусад холбогдох байгууллагуудад мэдээлснээр Цаазаар авах ялын эсрэг Дэлхий нийтийн Эвслийн цахим хуудсанд орсон байна.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ КАМПАНИТ АЖИЛ

Эмнести Интернэшнл байгууллага нь 2004 оноос эхлэн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох кампанит ажил явуулж байгаа билээ. 2010 гэхэд дараах зорилгуудад хүрэх зорилт тавин ажиллаж байна.

Хүний эрхийн талаархи зорилгууд

Бэлгийн хүчирхийллийн хохирогчдын эрхийг хамгаалсан хуулийг бий болгож хэрэгжүүлэх
Бэлгийн хүчирхийллийн хохирогчдод тохиромжтой үйлчилгээ авах бололцоог хангах
Охидын төлөө аюулгүй сургууль
Эмэгтэйчүүдийн төлөө аюулгүй ажлын орчин бий болгох
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд төр засгийн анхаарлыг хандуулах
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөг нийгмийн хандлагыг халах

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ажиллах үйл ажиллагааны өсөлт-зорилт
1. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ажиллах үйл ажиллагааны өсөлтийг дэлхий даяар өргөжүүлэх
2. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ажиллах залуучуудын үйл ажиллагааг дэлхий даяар өргөжүүлэх
3. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар ажиллах үйл ажиллагааны өсөлтийг Африк болон Ойрхи Дорнодын орнуудад нэмэгдүүлэх

Монголын Эмнести Интернэшнл 2007 онд дараах зорилгын дагуу ажиллаад байна.

- Охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх
- Нийгмийн бүх түвшин салбарт хүйсийн тэгш оролцоог хангах
- Охид эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалах талаархи ойлголтыг Монгол болон Ази номхон далайн бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх
- Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжих мэргэжлийн бүлгүүдийг нэмэгдүүлэх
- Монголын Эмнести Интернэшнлд эмэгтэйчүүд гишүүнээр элсэн орохыг болон эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих
- Олон улсад эмэгтэйчүүдийн эрхийн байдал ямар байгаа талаархи ойлголтыг нэмэгдүүлэх, эв нэгдлээ илэрхийлэх

Дээрхи зорилгодоо хүрэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд

Ойлголт, мэдлэг өгөх, гэгээрүүлэх кампанит ажил



Сар бүр хүйсийн тэгш эрхийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.

Эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүнчлэл, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор хэд хэдэн удаагийн уулзалт зохион байгуулсан бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл, хүйсийн тэгш эрхийн тухай, бусад эмэгтэйчүүдийн ТББ-тай хамтран олон улсын эмэгтэйчүүдийн өдрийн үйл ажиллагаанд оролцох талаар хэлэлцсэн юм. Тус бүлэгт нийт 20 гаруй шинэ гишүүн элсчээ.

3 дугаар сарын 8 Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр



Хамгийн аюулгүй байх ёстой гэр орон, сургууль, ажлын байран дээрээ хүчирхийлэлд өртөж хохирсон эмэгтэйчүүдийг төлөөлүүлж Оюутны бүлгийн гишүүд цаасаар 108 лаа хийв. Эдгээр лааг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр буюу 2007 оны 3 дугаар сарын 8-нд Эмэгтэйчүүдийн үндэсний хуралд оролцогчид болон Засгийн газарт хандан Эмнести Интернэшнл байгууллагаас гаргасан Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи 14 зүйлт хөтөлбөрийг хэрэгжүүлж ард нийтэд мэдээлэхийг уриалж томоохон Лаан Самбар бүтээхийг уриалж тавив. Энэ ажиллагааны үеэр уг уриалгыг дэмжсэн 701 хүний гарын үсгийг цуглуулан Монгол Ерөнхий сайд, Хууль зүй дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамны сайд нарт илгээлээ. Энэ илгээлтээрээ өнгөрөгч жил тус яамдуудад танилцуулсан тус 14 зүйлт хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж, ямар бодитой арга хэмжээ авч буй талаараа иргэдэд хэвлэл мэдээллээр дамжуулан мэдээлэхийг шаардсан юм.

Охидын аюулгүй байдал

Монголын Эмнести Интернэшнлийн Оюутан, Залуучуудын бүлгийн гишүүд Монголын Эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээтэй хамтран Аюулгүй байдлын талаар 1 цагийн дотор 100 хүнээс санал асуулга

авсан бөгөөд санал асуулгад оролцогчид өглөө гэрээс гарахдаа ямар нэг айдастай тухайлбал хулгайд юмаа алдчих вий, машинд шүргүүлчих вий, бага насны хүүхдүүд нь хүнд хүчирхийлүүлчих вий гэсэн айдастай явдаг гэж бүгд хариулсан байна. Судалгаанд оролцогчдын хамгийн бага нь хүчиндүүлчих вий гэсэн айдастай явдаг хэмээсэн юм. Тиймээс Монголын Эмнести Интернэшнл бусад сүлжээний байгууллагын төлөөлөгчидтэй хамтран Цагдаагийн ерөнхий газрын дарга М.Ганболдод асуулга хүргүүлж хариуг авсан юм.

Түүнээс гадна Охидыг хүчирхийлэхийг зогсоох 6 алхам хөтөлбөрийг “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх 16 өдрийн аян”-ны хүрээнд олон нийтэд танилцуулж, зурагт хуудсуудыг тараав. Зурагт хуудсаар Тэнгис Кино Театрт үзэсгэлэн гаргав.

Охидыг сургуулийн орчинд хүчирхийлэхийг зогсох 6 алхам

Эмнести Интернэшнл дэлхий дээрх бүх охидын боловсролыг нэмэгдүүлэхэд анхаарч сургуулийг аюулгүй байлгах болон сургуулиудыг олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардаж байна.

Эмнести Интернэшнл засгийн газар, сургуулиудыг эцэг эх, олон нийтийн байгууллагуудын тэргүүнүүдийн тусламжтайгаар дараах 6 шатыг хэрэгжүүлэхийг уриалж байна.

Алхам 1: Бэлгийн хүчирхийлэл, хэл амаар доромжлох, айлган сүрдүүлэх зэрэг охидын эсрэг хүчирхийллийг хориглох, тохиромжтой хууль, бодлого, дүрэм журмыг боловсруулах

Алхам 2: Охидыг хүчирхийлэхийн эсрэг сургуулийн аюулгүй орчин бий болгох үндэсний төлөвлөгөөтэй ажиллах, сургуулиуд, багш нар болон сурагчдад албан ёсоор сургалт явуулах, Сургууль дээр тусгаарласан бие засах газар болон дотуур байр барих, спортын талбай байгуулах

Алхам 3: Охидын эсрэг хүчирхийллийн тохиолдлуудад бие даасан механизм бүхий мөрдөн шалгалт явуулах, хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлэх, Охидын эсрэг хүчирхийллийн

талаар мэдээллийг тэмдэглэх, хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг тодруулах

Алхам 4: Хүчирхийллээс болж зовж буй охидод ДОХ-ын талаар болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах, бэлгийн болон нөхөн үржихүйн талаар эрхийг нь ойлгуулах, жирэмсэн, гэрлэсэн болон ДОХ-ын нян тээсэн хүүхдүүдийг дахин сурч боловсрох бололцоог хангах

Алхам 5: Охидыг анхан болон дунд шатны боловсрол авах, Үнэ төлбөргүйгээр боловсрол эзэмших хөгжлийн хөтөлбөр боловсруулах

Алхам 6: Охидыг сургуулийн албан хаагч болон сурагчдын зүгээс ирэх доромжлолоос хамгаалах, сургуульд охидын эсрэг хүчирхийлэл байгаа эсэхийг эртнээс судлан шалгаж байх талаар сургуулийн албан хаагчдад сургалт явуулах

Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчид

Хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгмийг цогцлуулан хөгжүүлэх нөр их үйлст хүний эрхийн төлөө тэмцэгч эмэгтэйчүүд нэн чухал хувь нэмэр оруулж ирсэн билээ. Монголын иргэний нийгмийн идэвхтэй гишүүд болох эмэгтэйчүүд жендэрийн шударга ёсыг төлөвшүүлэх, хүн болон хүүхэд бүрийн бүх эрхийг хангах, ардчилсан засаглалыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх, хүчирхийллийг таслан зогсоох, үндэсний тусгаар тогтнолыг бэхжүүлэх, нийгмийн шударга ёсыг тогтоох, ядуурлыг бууруулах болон гэр бүлийн сайн сайхан байдлыг хангахын төлөө сэтгэл зүрх, авьяас билгээ зориулан ажиллаж ирсэн ч тэдэнд сэтгэлзүйн дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх, төрөөс дэмжлэг үзүүлэхгүй, саад учруулах, санхүүгийн дэмжлэг дутах гээд олон бэрхшээл учирч байна. Тиймээс хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах төрийн үүргийг сануулах, эмэгтэй тэмцэгчдэд тулгарч буй бэрхшээлийг таниулах, Монгол улсад ажиллаж буй эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын хийж буй ажлын талаар танилцуулж, Хүний эрхийн хамгаалагч хэн бэ гэдэг ойлголтыг иргэдэд өгөх зорилгоор МОНФЕМНЭТ байгууллагатай хамтарч хэвлэлийн бага хуралд оролцож, яриа хийлээ.

Хүйсийн тэгш байдал:

Хүйсийн тэгш байдлын талаархи Эмнести Интернэшнлийн бодлогын талаар Эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч, удирдах зөвлөлийн гишүүн Ш.Анхмаа, Эрэгтэйчүүдийн бүлгийн ахлагч Д.Бадамцэцэг нар 11 дүгээр сарын Wire сонинд нийтлэл хэвлүүлэв.

Монгол дахь хүн худалдаалах хэргийг таслан зогсоохын төлөөх сүлжээ



Сүлжээний байгуулах гол зорилго нь үндэсний хэмжээнд хүн худалдаалах хэргийн талаар тоо баримттай байх, тус хэргийн тухайд төрийн

болон төрийн бус байгууллагуудтай нэгдэн ажиллаж, харилцан мэдээллээ солилцож, ажиллах явдал юм.

Монголын Эмнести Интернэшнлд 12 дугаар сарын 7-нд Үндэсний сүлжээ байгуулах зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Үүнд Эмнести Интернэшнл байгууллагын гишүүн Р.Янжмаа, Э.Отгончулуун, С.Цэмбэлмаа, Ц.Цэнд-Аюуш, Хууль зүй дотоод хэргийн яамны ажилтан Ж.Хунан, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамны ажилтан Н.Энхнасан, Хүйсийн тэгш эрхийн төвийн тэргүүн Г.Ганбаясгах, Хүний эрх хөгжил төвийн ажилтан С.Дондов, Азийн сангийн ажилтан А.Ургамал, Эрүүгийн цагдаагийн ажилтан Б.Дэлгэрсайхан, Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн П.Цэвээн нар оролцлоо.

Эдгээр оролцогчид нь хүн худалдаалах хэргийн эсрэг сүлжээ байгуулж ажиллахыг дэмжицгээв. Хэдийгээр Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яамны үндэсний зөвлөлд түшиглэн сүлжээ байгуулах бололцоо бий боловч бид хууль зүй дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам, ХЭҮК, цагдаагийн алба болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог байлгахыг эрмэлзсэн юм. Түүний зэрэгцээ Ази номхон далайн бүсийн орнууд дахь Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эсрэг кампанит ажлийн талаархи гарын авлага, Охидын төлөө аюулгүй сургууль 16 өдрийн аяны талаарх мэдээллийг түгээлээ.

Нөлөөлөл, хамтын ажиллагаа

- Монголын Нөхөрлөлийн Алтан гарц болон бусадтай мэдээлэл солилцсон
- Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудтай цахим сүлжээ тогтоосон
- Иргэдэд зориулан хүн худалдаалах гэмт хэргийн талаар гарын авлага хэвлүүлсэн бөгөөд эмэгтэйчүүд хүүхдийн ТББ, Хууль Зүй дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам, сургуулийн нийгмийн ажилтнуудад түгээх болно.

Олон улсын хамтын ажиллагаа

2007 оны 8 дугаар сард Мехико хотноо болсон Олон улсын зөвлөлийн уулзалтад тус кампанит ажлын талаар удирдах зөвлөлийн гишүүн



Р. Оюунбадам, Э.Өлзийбат нар Монголын Эмнести интернэшнл байгууллагын явуулж буй Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг

таслан зогсоох кампанит ажилын тактик, явуулсан үйл ажиллагаа, ололт амжилт сэдвээр илтгэл тавилаа. Тус илтгэлд Монголын Эмнести Интернэшнлээс эрчүүдийн үүрэг оролцоог анхааран авч үзэж байгаа болон залуучуудыг уг үйл ажиллагаанд татан оролцуулахын ач холбогдолбг дурдсан болно.

Бид дараагийн 2 жилд дараагийн зорилгуудыг тавин ажиллах болно

- Нийгмийн бүх түвшин салбарт хүйсийн тэгш оролцоог хангах
- Охид эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалах талаархи ойлголтыг Монгол болон Ази номхон далайн бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх
- Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжих мэргэжлийн бүлгүүдийг нэмэгдүүлэх
- Монголын Эмнести Интернэшнлд эмэгтэйчүүд гишүүнээр элсэн орохыг болон эмэгтэй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих
- Олон улсад эмэгтэйчүүдийн эрхийн байдал ямар байгаа талаархи ойлголтыг нэмэгдүүлэх, эв нэгдлээ илэрхийлэх
- Бүлгүүдийн ахлагч нарын чадавхид тулгуурлан эмэгтэйчүүдийн бүлгийг өргөжүүлэх шаардлагатай байна.



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ

Монгол улсад Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөл үзүүлэх, түүний Нэмэлт Протоколд нэгдэн орохыг Монгол улсын Засгийн газарт уриалах, бусад улс орнуудын Засгийн газрыг Эрүү шүүлтийн эсрэг Конвенцид нэгдэн орж, соёрхон батлахыг уриалах, Монгол улс дахь эрүүгийн болон, эрүүгийн байцаан шийтгэх хуулинд оруулах өөрчлөлтийн талаар санал боловсруулан хүргүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус хөндлөнгийн үндэсний механизмыг бий болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх зорилго тавин ажиллаа.

Эрүүдэн шүүх болон харгис хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах нь бусармаг, ёс суртахуунгүй, хууль бус явдал мөн. Эрүү шүүлт, зүй бус харьцаа нь зөвхөн хохирогчдод хор хохирол учруулаад зогсохгүй, байх л ёстой зүйл мэт ойлголт төрүүлэх зэргээр нийгэмд харгислалыг төрүүлж байна. Тиймээс ч эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааг олон улсын хууль, дайны хуулиар хориглосон байдаг. Эрүү шүүлт бол хамгийн ноцтой хүний эрхийн зөрчил бөгөөд сая сая хүмүүс мөн тэдний гэр бүлд асар их гарз хохирлыг авчирдаг юм. Бие махбодийн гэмтэл бэртэл аймшигтай зовоон тарчлаадагийн адил сэтгэлзүйн болоод сэтгэлийн шарх хамгийн их уй гашуу авчирдаг бөгөөд нөхөн сэргээхэд хамгийн хэцүү байдаг.

Гуантаномо Бэй: Шударга бус явдлын илэрхийлэл



“Терроризмийн эсрэг дайн” нэрийн дор баривчлагдсан олон үндэстний зуу зуун хүмүүс Кубын Гуантаномо Бэй дэхь АНУ-ын хорих лагерьт хүргэгдэж байна. Анх 2002 оны 1 сард Афганистанаас хүмүүсийг баривчилан нүүр амыг нь бүтээж, гар хөлийг нь дөнгөлж Гуантаномо руу авч явсан байна. Тэдгээр хүмүүс нь 45 үндэстнээс

бүрдсэн 750 гаруй хүмүүс байсан бөгөөд тэдний дунд 13-хан настай хүүхдүүд хүртэл байжээ.

Таван жил болоход олон зуун хүн хоригдсоор байгаа бөгөөд тэдний олонхийг байцаалтын үеэр болон дамжуулан шилжүүлэх явцад номхон зогсоох, газарт хэвтүүлэх, унтуулахгүй байх, байнга чихэнд чийртэй дуу чимээ гаргах, урт хугацаагаар ганцаарчлан хорих, толгойд нь битүү юүдэн углах, нохойгоор айлгах зэргээр айлган сүрдүүлж эрүүдэн шүүж байна. Хоригдогсад Афганистан, Босни Герцеговин, Египет, Гамби, Индонез, Мавритан, Пакистан, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират улс, Замби зэрэг наад зах нь 10 орчим орны баривчлах байраар дамждаг байна.

40 орчим хоригдогсад амиа хорлохыг завдсан бөгөөд тэдний 3 нь 2006 оны 6 сард амиа хорлон нас барсан байна. 200 орчим хоригдогсад тэднийг хорьж байгаа нөхцөл байдлын эсрэг эсэргүүцэл үзүүлэн өлсгөлөн зарлаж байжээ.

“Гуантаномо Бэйд хоригдож байгаа хүн бүр гэр бүлийнхэнтэйгээ болон гадаад орчинтой ямар ч харилцаа холбоогүй, хууль эрх зүйн тодорхойгүй орчинд байгаа болохоор гэм буруугүйгээ батлах боломжгүй байдаг” хэмээн Афганистан, Пакистан болон Гуантаномо дахь АНУ-ын хорих газруудад хоригдож байсан Их Британи үндэстэн Моаззам Бег өгүүлсэн байна.

“Манай засгийн газарт хамгийн түрүүнд тавигдах ёстой шаардлага нь Гуантаномог хаах юм” хэмээн АНУ-ын ерөнхийлөгч асан Жимми Картер мөн хэлсэн байна.

Эмнести Интернэшнл нь тэдгээр бүх хоригдогсад хаа ч байсан эрүү шүүлтээс ангид байх эрхтэй бөгөөд бүх засгийн газрууд үүнийг нь баталгаажуулах үүрэгтэй хэмээн үзэж хууль бус ажиллагаа явуулж байгаа Гуантаномо Бэй хорих лагерийг хаахыг шаардан дэлхий нийтээр үйл ажиллагаа өрнүүлээд байна.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагын Эрэгтэйчүүдийн бүлгийн гишүүд Бүх гишүүдийн уулзалтын үеэр Гуантаномогийн хоригдлуудыг суллуулах тухай жүжигчилсэн тоглолтыг үзүүлж, тэнд хоригдогсоодыг суллуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангуулах шаардлага бүхий захидал уриалгыг илгээхэд хандив цуглууллаа.

Монгол улсад суугаа АНУ-ын онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайдад хандан Гуантаномог хаахыг уриалсан захидал уриалгыг Монголын Эмнести Интернэшнл байгууллагын гишүүд дэмжигчдээс хүргүүллээ.

Гуантаномог хаахыг уриалсан “Close Guantanamo” интернэт үйл ажиллагаанд гишүүд дэмжигчид мөн нэгдэн орлоо.

Эрүүдэн шүүхийн хохирогсод туслах Олон улсын өдөр



2007 оны 6-р сарын 26-ны Эрүүдэн шүүхийн хохирогсод туслах Олон улсын өдрөөр иргэдэд зориулан эрүүдэн шүүх асуудлаар хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх нэг өдрийн аяныг Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албатай хамтран зохион байгууллаа. Хуульчдын бүлгийн гишүүд Д.Мөнхдэлгэр, Н.Мичидмаа, Х.Энхзаяа, А.Түвшинтулга, Д.Цэндсүрэн, С.Цэмбэлмаа, Д. Энхбаяр нар хууль зүйн зөвлөгөө, Чөлөөт бүлгийн гишүүн сэтгэл зүйч Д.Оюунномин сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгууллаа. Хууль зүйн зөвлөгөө хүссэн иргэдийн олонх нь эрүү шүүлт зүй бус харьцаатай холбоотой гомдол ихээр гаргаж байсан юм. Мөн Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоотой хамтран эрүүдэн шүүхийн талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сонгож авсан орныхоо засгийн газрын эрх баригч нарт хандан эрүү шүүлт, зүй бус харьцааг таслан зогсоох, Монгол улсын засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн сайдад хандан хорих газруудын үйл ажиллагаанд бие даасан хөндлөнгийн хяналт тавьдаг механизмийг бүрдүүлэгч “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол”-д нэгдэн орохыг уриалсан утга бүхий захидалд гарын үсэг цуглуулах аянд Залуучууд, сурагчдын бүлгийн гишүүд идэвх санаачилгатай оролцлоо. Аянаар



Монгол улсын ерөнхийлөгчид бичсэн захидалд-120, ерөнхий сайдад – 124, Хууль Зүй дотоод хэргийн сайдад- 123, Хууль Зүй Дотоод хэргийн Яамны Төрийн Нарийн бичгийн даргад – 119, Азербайжаны ерөнхийлөгчид – 191 гарын үсэг цуглуулж илгээлээ.

Энэ өдөр зохион байгуулагдсан Бүх гишүүдийн уулзалтаар Эрүүдэн шүүгдсэний улмаас нас барсан хүмүүсийн дурсгалыг хүндэтгэж лаа асаах үйл ажиллагааг гишүүдийн хүрээнд зохион байгуулав.

“Эрүүдэн шүүж, зүй бус харьцахын эсрэг” танилцуулга

Эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажлын хүрээнд гаргасан энэхүү гарын авлага нь эрүүдэн шүүж, зүй бус харьцах гэж юуг хэлдэг, энэ зөрчлийг ихэвчлэн хэн үйлддэг болон үүнийг эцэс төгсгөл болгохын тулд хараат бус олон улсын болон үндэсний бие бүрэлдэхүүнүүд хорих, цагдан хорих газруудад хяналт шалгалт хийх нь ямар их чухал болохыг, энэхүү хяналт шалгалт хийх эрх нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн нэмэлт Протоколд нэгдэн орсноор хэрэгжих боломжтой зэргийг тодорхой гаргаж өгсөн. Үүний зэрэгцээ баримт, нотолгоог дэлгэн, эрүү шүүлтээс амьд үлдэгсдийн хэлсэн үгээс оруулсан. Мөн эрүүдэн шүүхийг таслан зогсоохын төлөө Эмнести Интернэшнл байгууллага хэрхэн ажиллаж байгааг илэрхийлсэн энэхүү танилцуулгыг 500 хувь хэвлэн Эрүүдэн шүүхийн хохирогсод туслах олон улсын өдрөөр олон нийт болон зохих байгууллагуудад тараалаа.

Хэвлэл мэдээлэл

Эрүүдэн шүүхийн эсрэг тэмцэлд олон нийтийг оролцохыг уриалах, идэвхжүүлэх зорилгоор энэ өдөр болох үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан “Эрүү шүүлтэд хохирсон хүмүүст туслахаар гарын үсэг цуглуулна” хэвлэлийн мэдээг бэлтгэн Өдрийн сонингоор олон нийтэд хүргэсний зэрэгцээ Монголын радиогоор Эмнести Интернэшнл байгууллагаас эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын төлөө авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллаганы талаар товч ярилцлага өглөө. Мөн “Европын Холбоо: Шинэ дүрэм нь эрүү шүүлтийн зэвсгийн худалдааг таслан зогсооход хангалтгүй байна” хэвлэлийн мэдээг орчуулан бэлтгэж Өнөөдрийн Монгол сонинд нийтлүүлж, Гуантанамогийн хоригдлуудын тухай Зууны мэдээ, Ардын эрх сонинууд “К.Пауэлл Гуантанамог хаахыг уриалжээ”, “Өргөст торны цаанаас бичсэн шүлгүүд” нэртэйгээр мэдээ мэдээллүүдийг гаргажээ.

Нөлөөллийн ажиллагаа

Монгол улсад Хүний эрхийг хангах Үндэсний Хөтөлбөрийн Хороотой хэд хэдэн удаагийн уулзалт зохион байгуулж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр

хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн заалтыг практикт нэвтрүүлж хэвшүүлэх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт сургалт явуулж, тэдний хариуцлагыг тодорхой болгох, мөн тэрчлэн цагдан хорих, албадан саатуулах баривчлах байр, хорих ангиудад хөндлөнгийн мониторингийг



хэрэгжүүлж, хуулийн шаардлага хангахгүй, хүний эрх хохироож буй байруудын нөхцлийг өөрчлөн сайжруулах арга хэмжээ авч, бүх хэлбэрийн хорих

байр, газруудын үйл ажиллагаанд тавих иргэний нийгмийн хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэх тал дээр хамтран ажиллахаар тохиролцов.

“Хорих газарт тавих Иргэний нийгмийн мониторинг” сургалт

Монголын Эмнести Интернэшнл нь “Хорих цагдан хорих газарт хийх мониторинг” ТББ-дад зориулсан гарын авлага удирдамжаар хүний эрхийн ТББ-ын төлөөлөгчдөд сургалт явуулж, хорих, цагдан хорих газруудад хөндлөнгийн хараат бус мониторингийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, мэдвэл зохих олон улсын болон дотоодын дүрэм журам, харилцах тактик, хоригдогсдын онцлогийн талаарх мэдээллийг хүргэлээ

2007 оны 11 сарын 30-нд зохион явуулсан энэ сургалтыг УЗ-ын дарга Академич С.Нарангэрэл нээн, “Хүний эрх ба хорих байгууллага” сэдвээр мэдээлэл хийж, УЗ-ийн гишүүн, өмгөөлөгч Р.Оюунбадам Мониторингийг хэрэгжүүлэхтэй холбоотой дотоодын хууль тогтоомж болон Хорих газрын удирдлагууд, хоригдогчдын онцлогийн талаар дэлгэрэнгүй ярилаа. Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа Мониторинг хийх зорилго, үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон улсын хууль тогтоомж, Сэтгэл зүйч Д.Оюунномин Хорих газрын удирдлагууд болон хоригдогчидтой

харилцах тактикийн сонголт сэдвээр сургалт явууллаа. Сургагч багш нар оролцогчид хоорондоо санал бодлоо чөлөөтэй солилцож, туршлага мэдлэгээ хуваалцан тайлбар өгч байсан нь сургалтыг илүү сонирхолтой үр өгөөжтэй болгосон. Түүнчлэн манай сургалтанд оролцогчид сургалтыг өндрөөр үнэлж, цаашид хамтран ажиллах, мониторинг хийхэд нэгдэн орох боломжтой гэдгээ илэрхийлсэн юм.

Цаашид сургалтаар олж авсан мэдлэг туршлага дээрээ үндэслэн хорих газарт тавих мониторингийг хэрэгжүүлэхийн тулд Швед улсын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Холбоотой хамтран ажиллахаар болов.



ЗЭВСГИЙГ ХЯНАХ КАМПАНИТ АЖИЛ

ЗЭВСГИЙГ ХЯНАХ

Зэвсгийг хяная кампанит ажлын гол зорилго бол хууль бус зэвсгийн зөөвөрлөлт зэргээс сэргийлэх олон улсын холбогдох хууль журмуудад үндэслэн зэвсгийн худалдааны гэрээг батлуулах явдал юм.



2007 онд тус кампанит ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тоглоомон бууг солих хөтөлбөр



О ю у т а н залуучуудын бүлгийнхэн Эрхийнхээ төлөө ш у у г и ц г а а задгай тоглолтын үеэр санал асуулга явуулж 64 хүний санал асуулга авч, сэтгэгдлийг сонссон байна. Санал асуулгад янз бүрийн ажил мэргэжлийн 50 хүн оролцсоноос 40 хүн уг гэрээг дэмжин 8 хүн хариулаагүй 1 хүн эсрэг санал өгсөн байна.

Зэр зэвсгийг хяная кампанит ажлын үеэр сая сая дүр төрх интернэт уриалгыг дэмжсэн 85 хүний зургийг авч, зэвсгийн худалдааны тухай олон улсын гэрээг дэмжигчдийн сайтад байрлуулсан юм.

Зэвсгийн хяналтгүй худалдаа, зүй бус хэрэглээ, хувь хүний гар дээр байгаа бага оврын галт зэвсгийн улмаас минут тутамд нэг хүн амиа алдаж байгаа билээ. Мэдээж энэ тоо зэвсэгт мөргөлдөөнтэй, дайн байлдаантай байгаа улс орнуудад амиа алдсан хүмүүсийг оруулаагүй юм.

Буу тоглоом мөн үү?

Таны хүүхэд буугаар сайн хүмүүжил олж чадах уу?

Бид хүүхдүүдийн хүчирхийллийг д э м ж с э н тоглоомон бууг эрхийг нь таниулах,

оюун ухааныг нь хөгжүүлэх чиглэлийн тоглоом бусад зүйлсээр солих ажлыг 2 удаа зохион байгуулсан юм.

Эцэг эх, ах эгч найзуудын хамт ирсэн хүүхдүүд 73 ширхэг буу авчирч өөр төрлийн тоглоомтой болж буцлаа.



Кавейрао үйл ажиллагаа

Рио Де Жанейро дахь гудамжинд цагдаагийнхан хягт танкаар гэмгүй иргэд рүү дайрсаныг эсэргүүцэн оюутны бүлэг кавейро ашиглахын эсрэг 562 гарын үсэг цуглуулж илгээлээ.

Бид ирэх жилд дараахь зорилгуудыг тавин ажиллах болно

Зэвсгийн худалдааны талаарх олон улсын хэм хэмжээг сурталчлах

Зэр зэвсгийг хяная кампанит ажлын хүрээнд гишүүнчлэлийг өргөжүүлэх



ХЯМРАЛД ХАРИУ ӨГӨХ АЖИЛЛАГАА

Дарфурын өдөрт

НҮБ Суданы засгийн газарт хандаж нийт 326 гарын үсэг цуглуулсан. Энэ мэдээ 2007 оны 4 дүгээр сарын 27-нд хэвлэгдэж UBS сувгаар мэдээлэгдсэн юм. Цаасан тагтаануудыг Азийн олон хэлнээ бичиж Суданы гадаад хэргийн сайдад илгээлээ.

Мөн Оюутны бүлгийн гишүүн Буянхишиг Багануур дүүрэгт очин нөхдийн хамт 50 гаруй хүмүүсийг Дарфурын үйл ажиллагаанд оролцуулаа. 2007 оны 9 дүгээр сарын 14-нд Оюутны талбайд 400 гаруй гарын үсэг цуглуулсан юм.



Бирмийн үйл ажиллагаа

2007 оны 9 дүгээр сарын 29-нд Сүхбаатарын талбайд Бирмийн лам нарын төлөө 380 орчим гарын үсгийг оюутны бүлгийнхэн цуглуулав. 300 Бирм лам нарыг суллах 300 Монгол лам нарын зургийг мөн авсан юм. Гандан тэгчилэн, Дашчойлин, Бэтүб хийдийн 50 лам, Бахайн нийгэмлэг, Муслимчуудын төлөөлөл тус үйл ажиллагаанд оролцлоо.



ЭДИЙН ЗАСАГ НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Хүн бүр эрхээ эдлэх эрх чөлөөтэй байх ёстой.

Иргэний болон улс төрийн эрх, тэгээд эдийн засаг, нийгэм соёлын эрх хэмээн хүний эрхийг зэрэглэх ёсгүй билээ. Тэгвэл өнөөдөр ихэнх улс орнуудад хүмүүс үзэл санаанаасаа илүүтэйгээр ядуурал, өвчин, өлсгөлөнгийн “хоригдол” болж байна. Ядуурал хүмүүсийг “эрхээ эдлэх чадваргүй” “хоригдол” болгож байна. Тиймээс хүний эрхийн зөрчилд хүмүүсийг түлхэж буй ядуурал, өвчин зовлонгийн эсрэг Эмнести Интернэшнл “Хүнийг Хүндэлье” кампанит ажлаа 2008 оноос эхлэн өрнүүлэх гэж байна. Энэ кампанит ажилд бэлтгэж 2007 онд Монголын Эмнести Интернэшнл дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Бизнес ба хүний эрх



Аливаа засгийн газар хүний эрхийг хүндэтгэн хамгаалахад эн тэргүүнд хариуцлага хүлээх нь зайлшгүй. Гэхдээ компаниуд ч олон улсын хуулийн дагуу хүний эрхийг хамгаалах хүлээх ёстой. Өнөөдөр бизнесийнхний хүч, хүрээ өргөжиж, үндэстэн дамнасан корпорациудын нөлөө олон улсын түвшинд болоод үндэсний түвшинд ихээхэн өсч байна. Хэрэв компани ямарваа нэгэн хүний эрхийн зөрчилд холбогдвол өөрсдийн үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг алдаад зогсохгүй, үйлчлүүлэгч ард иргэдийн зүгээс зарга маргаан үүсгэх асуудал ихээр тохиолдож болно.

Нөгөөтэйгүүр тэдний эрх мэдэл, үйл ажиллагаа нь байгаль орчин, иргэдийн аюулгүй байдалд заналхийлж хохирол учруулж болохгүй билээ.

Эмнести Интернэшнл компаниудтай хүний эрхийн талаар үзэл бодлоо солилцож, аливаа эерэг өөрчлөлтийг авчрахаар лобби хийж байна. Бид Бизнес ба хүний эрх үйл ажиллагаагаараа компаниудын ёс зүйн дүрмийг өөрчлөх, даяаршлын тунхагийг дагаж мөрдөхийг уриалж байгаа юм.

Тиймээс 2007 онд дараах ажлуудыг хийлээ.

2007 оны 11 дүгээр сард Бизнес ба хүний эрхийн сургалтыг Айвенхоу Майнз, Монгол газар, Эрхэс майнин, Жи Мобайль, Эрэл зэрэг 20 орчим бизнесийн байгууллагуудад хийв. Гол зорилго нь бизнесийн үйл ажиллагаан дахь хүний эрхийн хэм хэмжээ, Даяаршлын тунхагийн талаар ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм. Сургалтыг Монголын Эмнести Интернэшнлийн үйлдвэрчний эвлэлийн бүлэг Монгол ажил олгогч эздийн холбоотой хамтран зохион байгуулав. Сургалтын үеэр Даяаршлын тунхаг, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай гарын авлага материалууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гарын авлагуудыг тараасан нь оролцогчдын талархалыг хүртэв.

Хүний эрхийг хамгаалагчид

Хүний эрхийн хамгаалагчдад хүний эрхийн механизмын талаар ойлголтыг нэмэгдүүлэхэд тус ажиллагаа чиглэв.

Бид НҮБ-ын хүний эрхийн хамгаалагчдад зориулсан Мэргэжлийн цувралын 29 дэх дугаарыг орчуулан гаргаж, хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагын ажилтан, сэтгүүлч, оюутан залуучуудад тараагаад байна.

2006 оны Эмнести Интернэшнлийн жилийн тайланд нутаг усаа хамгаалах, байгаль орчны чиглэлээр ажиллаж буй хүний эрхийн хамгаалагч нартай пүүс, компаний хамгаалалтын ажилтан, цагдаагийн байгууллагын ажилтнууд хүч хэтрүүлэн, зүй бус харьцсан талаархи мэдээлэл гарч байсан билээ. Үнэхээр орон нутаг, иргэний хөдөлгөөний идэвхитнүүдэд хүний эрхийн талаархи мэдлэг чадавхийг дээшлүүлэх, хамгаалах механизмыг танилцуулах нь зайлшгүй чухал юм. Тиймээс бид Олон улсын хүний эрхийн механизмыг танилцуулах сургалтанд Миний Монголын газар шороо хөдөлгөөн, Монголын ногоон нам, эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн, Хил хязгааргүй алхам, Монгол



нутаг мину эвсэл, Онги гол зэрэг хөдөлгөөнүүдийг урьж оролцууллаа. Тэд НҮБ-ын гомдол гаргах эрхийн талаар сурч авсан юм. Мөн тэдэнд Wire зэрэг гарын авлагуудыг түгээв.

хөдөлмөрлөх цагаачлах эрхийн талаар ярилцсан юм.

Нөлөөлөл, хамтын ажиллагаа

Их сургуулиуд дээрх хөтөлбөрүүд:

Оюутны бүлгийнхэн Хөдөө аж ахуйн их сургууль, Худалдаа үйлдвэрийн дээд сургууль болон Эдийн засгийн сургуулиудын 120 орчим оюутнуудад ЭЗНСЭ-ийн талаар танилцуулах үйл ажиллагаа явуулж нийтдээ 30 оюутан шинээр Эмнести Интернэшнлд элслээ.

Бизнес ба Хүний эрхийн талаархи сургалт:

Нийслэлийн Хан-Уул дүүргийн нийгмийн ажилтнуудад болон орон нутгийн удирдлагын 20 орчим албан хаагчдад Бизнес ба хүний эрхийн талаархи сургалтыг амжилттай зохион явууллаа.



Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн холбоо, МАОЭНэгдсэн холбоо тус үйл ажиллагаанд хамтран оролцов.

Олон улсын хамтын ажиллагаа

Монголд Өмнөд Солонгосоос Олон улсын цагаачдын байгууллагын төлөөлөгчид зочиллоо.

Үүнд Ионсейн их сургуулийн антропологи судлаач профессор хатагтай Ким Хюн Ми, ноён Ким Чул Хо, цагаач эмэгтэйчүүдийн ТББ-ын нийгмийн ажилтан хатагтай Ким Мин Жон нар байсан бөгөөд Монголын хүний эрхийн байдал болон гэрлэлт,



Бид ирэх 2 жилд дараах зорилгуудыг тавин ажиллах болно

- Эмнести Интернэшнлийн зорилго эрмэлзлэлийн дагуу эдийн засаг, нийгэм соёлын эрхийг дэмжих
- Бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Даяаршлын тунхагийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх
- ЭЗНСЭ-ийн талаар стратеги төлөвлөгөөтэй, ТББ-уудтай хамтран ажиллах
- Монголын Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг бизнесийн хүрээнд танилцуулах
- Бопалын хохирогчдын асуудалд анхаарал хандуулах

ЭРХЭЭ ХАМГААЛЖ ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ



Хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 10 буюу Олон улсын хүний эрхийн өдрөөр хүний эрхийн төлөө захидал уриалга бичих марафоныг дэлхий даяар нэгэн зэрэг явуулдаг билээ. Монголын Эмнести Интернэшнл энэ үйл ажиллагааг 12 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд 12.00-18.00 цагийн хооронд Номин ХХК-ний Улаанбаатар, Дархан, Эрдэнэт дэх салбар дэлгүүрүүд, Скай Их дэлгүүр, Олон нийтийн Радио, телевизийн газар, Тэнгис кино театр дээр “Нэг гарын үсэг, Нэг хүний амь, Нэг зуун төгрөг,” уриан дор Хятад, Энэтхэг, Индонез, Балба, Бирм, Вьетнам, Лаос, Өмнөд Солонгос, АНУ, Орос улсад эрх нь зөрчигдсөн 12 хүний төлөө гарын үсэг зуруулах, иргэдэд хүний эрхийн талаар мэдээлэл өгөх хэлбэрээр зохион явууллаа.

Лаос

Тао Моуа болон Па Фю Хан нар нь уугуул Монг иргэдийн талаар шинэ мэдээ судлан цуглуулж байв.

Өмнөд Солонгос

Ли Си Вү нь сэтгүүлч бөгөөд энх тайвны төлөө тэмцэгч. Өмнөд Солонгосын цэргийн нууц задласан хэргээр баривчлагдсан

Хятад

Тян Ань Миний бослогын талаар 15 жилийн ойн тухай засгийн газраас сэтгүүлчдэд өгсөн зааврын талаар интернэтээр явуулсны улмаас 10 жилийн хорих ял авсан. Юэ Гуожу 2004 оны 12 дугаар сард 2003 онд Бээжингийн Шуанву дүүргийн оршин суугчдыг хүчээр нүүлгэн шилжүүлснийг эсэргүүцсэн учир 4 жил хоригдох ял авсан. Чен Гуаншень нь хараагүй, хүний эрхийн төлөө тэмцэгч бөгөөд Шандунь мужид хүчээр үргүйдэл бий болгох үр хөндөх зэргийг эсэргүүцэн олон нийтийг цуглуулсан болон эд хөрөнгө эвдэн сүйтгэсэн гэгдэж 4 жил хоригдож байна. Тянь Ань Миний ээжүүд хөдөлгөөнд нийт 130 хүний эрхийн хамгаалагчид оролцож уг хэргийг шалгахыг уриалж байгаа боловч зарим нь хоригдоод байгаа юм.

Энэтхэг

Гужаратад болсон хүчирхийлэлт хэргийн эсрэг тэмцэж Мумбайн шүүхэд амжилт олсон

Вьетнам

Тронг Кюк Хьюг Нью Йоркийн ПолТок интернэтийн компанийн “Вьет нам болон гадаадад байгаа иргэдийн дуу хоолой” сэдэвтэй чат хуудсаар санал бодлоо солилцсоных нь төлөө ах, найз охиных нь хамт баривчилжээ.

Индонез

Филеп Карма үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлсний төлөө хоригдсон

Мяньмар

Оюутны холбооны тэргүүн Мио Мин Зоу. Үзл санааны хоригдол. Боловсролын талаар хөдөлгөөн өрнүүлсэн.

Непал

Санжив Кумар Карна 10 найзын хамт 2003 оны 10 дугаар сарын 8-нд баривчлагдсан. Оюутны улс төрийн бодлоготой үйл ажиллагаа явуулсан хэмээн баривчлагдсанаас хойш хаана байгаа нь тодорхойгүй байна

ОХУ

Артур Ахматанов. Хүний эрхийн хамгаалагч. Оюутан, 2003 оны 4 дүгээр сарын 2-нд Оросын аюулгүй хүчнийхэнд баривчлагдсанаас хойш хаана байгаа нь тодорхойгүй байна

АНУ

“Терроризмийн эсрэг дайн” нэрийн доор олон үндэстний зуу зуун хоригдогсод Кубын Гуантанамо Бэй дэхь АНУ-ын хорих лагерьт 45 үндэстнээс бүрдсэн 750 гаруй хүмүүсийг аваачин эрүүдэн шүүж байгааг буруушаан уг шоронг хаахыг уриалсан захидлыг Ерөнхийлөгч Жорж Бушид хандан илгээв.



Монголын Эмнести Интернэшнлийн нийт 50 гаруй хүний эрхийн хамгаалагчид энэ үеэр ажилласан бөгөөд Дархан, Эрдэнэт хотын Эмнести Интернэшнлийн бүлгийн шинэхэн хүний эрхийн хамгаалагчид ч мөн оролцлоо. Тэд нийтдээ 900 гаруй хүний гарын үсэг зуруулж, 63700 гаруй төгрөгний хандив цуглуулсан байна.

Явуулсан үйл ажиллагааныхаа дараа залуу тэмцэгч Ч.Золжаргал өгүүлэхдээ “Биднийг хүмүүс гадаадынхан гэхээсээ илүү Монголынхоо төлөө ажиллаач гэж байсан. Галаа, Даариймаа нартай ажиллахад сайхан байсан. Хүний эрхийн төлөө цаашид ажилласаар байх болно” гэсэн юм.



ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ ШУУГИЦГААЯ



Цахим хуудсаар болон хэвлэл мэдээллээр сурталчилах

“Эрхийнхээ төлөө шуугицгаая” урлагийнхныг хамарсан энэхүү үйл ажиллагааг хоёр дахь жилдээ зохион байгуулаад байгаа билээ. Тус үйл ажиллагааг Улаанбаатар хотын Канион төв дэх “M&O”, Сүхбаатар дүүрэг дэх “За”, Флаш болон 11, 13 дугаар хорооллын нийт 6 интернэт кафений дэлгэц, интернэтийн нүүр хуудсыг тус аяны сурталчилгаагаар өөрчлөхийн зэрэгцээ үйлчлүүлэгчдэд зориулсан плакатыг байрлуулж сурталчилав. Энэ үйл ажиллагааг залуучууд санаачлан зохион байгуулав. Интернэт кафенаас гадна өөрийн байгууллагын цахим хуудас, ШУТИС-ийн цахим сурталчилгааны хуудсуудаар үйл ажиллагаагаа танилцууллаа. Үйл ажиллагааны талаар 1000 наадаг зураг бэлтгэн олон нийтийн газруудаар тараав.

Радио телевизийн хөгжмийн хөтөлбөрүүдээр ч энэ үйл ажиллагааг өргөн сурталчилсан юм. С1 телевизийн шууд ярилцлагын хөтөлбөрүүдээр, ТМ телевизийн M&M хөгжмийн хөтөлбөр, UBS music, NTV, 25 дугаар суваг, МҮТВ-ийн Voice box болон Hit entertainment хөтөлбөрүүдээр, Hi-Fi 98.9, Info Radio 105.5. –аар үйл ажиллагааг сурталчилжээ.

Телевизийн сурталчилгааг ч G Entertainment үнэ төлбөргүй хийж уран бүтээлчид дэмжлээ.

Гэрэл зургийн үзэсгэлэн

Эрхийнхээ төлөө шуугицгаая кампанит ажлыг дэлхийн олон оронд өрнүүлж байгааг харуулах зорилгоор гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулахаар төлөвлөж байсан нь Занаду Арт галлерейн дэмжлэгээр мультимедиа үзэсгэлэн болон өргөжив.

Үзэсгэлэн 6 дугаар сарын 25-30-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнд Занаду Арт галлерейн 10 залуу уран бүтээлчийн уран бүтээл, Дэлхийн болон Монголын “Эрхийнхээ төлөө шуугицгаая” аянд оролцож байгаа урлагийн оддын зураг, энэ үйл ажиллагааны талаархи баримтат кинонууд, цахим хуудсаар аялах булан ажиллалаа.

Тоглолтын үеэрх кампанит ажил

Тоглолтын үеэр Зэвсгийг хяная кампанит ажлын хүрээнд зэвсгийн асуудлаархи судалгаа, тоглоомон буу солих үйл ажиллагаа, Хятад болон ОХУ-ын хүний эрхийг хамгаалагчдын төлөө захидал уриалгад гарын үсэг цуглуулах ажлыг зохион байгуулав. Мөн иргэдийн дунд хүний эрхийн ямар зөрчил их байгааг судалж, энэ тухайгаа дуу хоолойгоо өргөн зурагт хуудас хийх ажлыг явуулав. Үйл ажиллагаанд манай 45 гаруй гишүүд сайн дураар ажиллан сурталчилж зуны халуун өдөр байсан ч 500 гаруй хүнд хүрч ажиллажээ.



Задгай тоглолт

Энэ тоглолтыг Монголын рок попын болон ардын урлагийн олон хамтлаг дуучид дэмжин оролцов. Хөгжмийн зохиолч Г.Пүрэвдорж, Мишээл, Quiza, BX зэрэг дуучид, Fire, Nisvanis, , Max Music Family, Lemons, Pilots, Алтан ураг хамтлагууд болон Нандингуа, Дэвид, Эндрю Америк сургуулийн сурагчид дэмжин оролцлоо. Энэ жилийн үйл ажиллагаанд уран бүтээлчид зөвхөн тоглолтонд ороод зогсохгүй хөгжмийн хөтөлбөр, хэвлэлийн бага хурал болон өөрсдийн тоглолтынхоо үеэр сурталчилж хамтран ажилласан юм.

Тоглолтонд уран бүтээлчид Жонн Ленноны IMAGINE цомгийн дуунаас дуулав. Ялангуяа ардын урлаг рок хамтарсан Алтан ураг хамтлаг IMAGINE дууг үндэсний хөгжим морин хуураар тоглосон нь онцгой байсан юм.

Тоглолт Эрх чөлөөний талбай дээр зохион байгуулагдлаа.

Тоглолтонд оролцсон болон дэмжин ажилласан 25 уран бүтээлч болон хэвлэл мэдээлэл, сурталчилгааны байгууллагуудад Эмнести Интернэшнлийн албан ёсны дэмжигч, Хүний Эрхийг хамгаалагч өргөмжлөл, цомыг Олон Улсын хүний эрхийн өдрөөр Монгол дахьНҮБ-ын байранд гардуулав.



ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ

2007 онд тус кампанит ажлын хүрээнд Монголын Эмнести Интернэшнл үндэсний хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх; Монгол улсад Ромын дүрмийн хэрэгжилтийг хангуулах болон ОУЭШ-ийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр явуулахад туслах; Үндэсний эвсэлийн үйл ажиллагаанд техник хамтын ажиллагааны туслалцаа үзүүлэх зорилго тавин ажиллаа.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улс нь 2002 онд Олон улсын эрүүгийн шүүхийн гишүүн улс болсноос хойш 4 жил гаруй хугацаа өнгөрсөн хэдий ч Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нийцүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байдлаа үндэсний хууль тогтоомжоор зөвтгөхийг олон улсын эрх зүйгээр хориглосон байдаг. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэж үзсэн ч ОУЭШ-ээс шаардсаны дагуу үүргээ гишүүн улс биелүүлэхгүй бол шүүх нь Гишүүн улсуудын Ассамблейд, эсхүл НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлд шийдвэрлүүлэхээр хандах хүртэл арга хэмжээ авна гэдгийг Монгол Улс анхааралдаа авах шаардлагатай байна. Гишүүн улс бүр хамтран ажиллах нөхцлийг хууль тогтоомждоо тусгах үүрэг хамгийн чухал бөгөөд энэ нь ОУЭШ-ийн шаардлагаар хамтран ажиллах ба шүүхийн туслалцааг үзүүлэх явдал юм. Энэхүү хамтын ажиллагааг хангах үүднээс зарим улсад тусгайлан ОУЭШ-тэй хамтран ажиллах хууль тогтоосон байдаг. Тухайлбал, 2006 оны 9 дүгээр сарын байдлаар 18 улс ОУЭШ-тэй хамтран ажиллах кодексыг баталсан байна.



Монгол Улсын Их хурлаас ОУЭШ-ийн Ромын дүрмийг 2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр соёрхон баталснаар олон улсын хамгийн хүнд бөгөөд ноцтой гэмт хэрэг үйлдэгч этгээд болон хамсаатан, оролцогчдын хэргийг шүүн хэлэлцэж ял оноох эрх мэдэл бүхий, бие даасан, байнгын үйл ажиллагаатай

Шүүхийг үүсгэн байгуулагч улс орон болсон билээ.

2006 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) болон Европын холбооны хооронд хамтран ажиллаж, харилцан туслалцах хэлэлцээр зохион байгуулагдав. Энэ хэлэлцээр 2006 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болжээ. Хэлэлцээр ёсоор талууд нөгөө талаас зохиох уулзалт, хуралд оролцох, мэдээлэл харилцан солилцох, шаардлагатай тохиолдолд Европын холбооны албан тушаалтнуудаас гэрчийн мэдүүлэг авч байх, мөн хэлэлцээрт Европын холбоо болон ОУЭШ-ийн Прокурорын хооронд бусад хэлбэрээр хамтарч ажиллах, ОУЭШ-ийн дэргэд Европын Холбооны төлөөлөгчийг суулгах талаар заасан байна.

Хурал уулзалтууд

Монголын Эмнести Интернэшнл нь Мэргэжлийн хуульч, судлаачдын баг байгуулж, Ромын дүрмийн зүйл заалтуудыг үндэсний хууль тогтоомжтой харьцуулан судлах, судалгааны үр дүнгийн талаар санал солилцох уулзалтуудыг хэд хэдэн удаа зохион байгуулав. Уулзалтаар Олон улсын эрүүгийн шүүхийн үндэсний эвсэлтэй хамтран Мэргэжлийн судлаачдын багийг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгож “Олон улсын эрүүгийн шүүх ба үндсэн хуулийн асуудал”, “Ромын дүрэм ба Монгол Улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”, “Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд Монгол Улсын Эрүүгийн хуулийг нийцүүлэх асуудал”, “Дархан эрх, эрх ямбын талаархи олон улсын ба үндэсний эрүүгийн эрх зүйн харьцуулсан судалгаа”, “Хариуцлагаас мултрах хэлэлцээр”-ийг цуцлах буюу түүнийг засварлах асуудал зэрэг сэдвүүдээр судалгаа хийлгэсэн юм.

Судалгааны үр дүнд тулгуурлан УИХ, Засгийн газарт хүргэх бодлогын зөвлөмж боловсруулах, үндэсний хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг томъёолох ажлын хэсгийг дахин байгуулж, тодорхой саналуудыг бэлтгэн гаргаад байна.

Нөлөөллийн ажиллагаа

Монгол улсад өрнөж буй улс төрийн тогтворгүй байдал, УИХ-ын хууль зүйн байнгын хороодын гишүүдийн ажлын ачааллын улмаас парламентын гишүүд болон, хууль зүйн байнгын хороодын гишүүдэд судалгааны тайланг танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулах боломж олдсонгүй.

Гэвч судалгааны үр дүнд гарсан санал цаашид Монгол улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ чиглэлээр ажиллаж байгаа эрдэмтэн судлаачид, практик ажилтнуудад чухал гарын авлага болох болно.

Тухайлбал уг Дархан эрх, эрх ямбын талаархи олон улсын ба үндэсний эрүүгийн эрх зүйн харьцуулсан судалгаагаар Төрийн өндөр албан тушаалтны дархан эрх, эрх ямба нь түүнийг оролцогч улс ОУЭШ-д шилжүүлэн өгөхөд саад болохгүй.

Монгол Улсад олон улсын гэмт хэрэг үйлдэх нь хариуцлага ногдуулахад хэн бүхний албан тушаал огт нөлөөлөхгүй тул манай улсын хууль тогтоомж нь ОУЭШРД-д харшлагагүй байна гэсэн дүгнэлт гарсан байна. Гэтэл “Хариуцлагаас мултрах хэлэлцээр”-ийг цуцлах буюу түүнийг засварлах асуудал судалгаагаар

Монгол Улс нь ОУЭШРД-ийн дагуу өөрөө олон улсын гэмт хэргийг байцаан шийтгэх үйл ажиллагаа явуулах, эсхүл энэ эрх мэдлийг ОУЭШ-д шилжүүлэн өгөх эрхтэй. Үүний хүрээнд: Ромын дүрмийн үзэл баримтлал, зорилго, утга агуулга, зарчмыг зөрчихгүй байх, ОУЭШ-тэй хамтран ажиллах, хамтын ажиллагааны зарчмыг тодорхойлсон байх нь ач холбогдолтой юм.

Гэтэл Монгол Улс нь соёрхон баталсан дээрхи олон улсын хэлэлцээрийн үг үсэг, үзэл санаанд илт харшилсан нууц хэлэлцээрийг 2003 онд АНУ-тай байгуулсан болохыг АНУ-ын Төрийн Департамент тухайн үед дэлхий нийтэд зарлан мэдэгдсэн. АНУ нь НҮБ-аас гадуур цэргийн ажиллагаа явуулахдаа ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор 2002 оны 8 дугаар сард Америкийн цэргийн албан хаагчдыг хамгаалах тухай хуулийг баталсан. АНУ-ын ямар ч иргэнийг хэзээ ч ОУЭШ-д шилжүүлэхгүй байх тухай хоёр талт хэлэлцээрийг Монгол Улстай 2003 оны 6 дугаар сард байгуулсан байна. Энэ нь Монгол Улсын хувьд “*pacta sunt servanda*” зарчмыг зөрчсөн үйлдэл болсон бөгөөд Үндсэн хуулийн 10, 14 дүгээр зүйлүүдийг зөрчсөн үйлдэл болж байгаа юм. Иймээс Монгол Улс, АНУ хоорондын харилцааны нааштай өөрчлөлтөд тулгуурлан, нууц хэлэлцээрийг цуцлах, эс бөгөөс Монгол Улсад арай ашигтай байдлаар өөрчлөх тухай санал гаргах нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.

Монголын Эмнести Интернэшнл байгууллага нь олон улсын байгууллагын нэг салбар болохынхоо хувьд бусад улс орнуудын хүний эрхийн байдлыг сайжруулахад санаа тавин ажилладаг билээ. 2007 онд бид Чех улс, Камерун, Того, Азербайжан зэрэг улсуудыг ОУЭШ-ийн Ромын Дүрмийг батлахыг уриалсан хэдэн арван хүний гарын үсэг бүхий захидал, цахим шууданг явуулсан юм.

Үүнээс гадна Судан, Конго, Нигерт үйлдэгдсэн хүний эрхийн томоохон хүчирхийллийн хэрэг дээр мөрдөн байцаалт явуулахыг уриалсан захидал уриалгыг ч мөн илгээсэн юм.

Олон улсын нарын бичгийн дарга нарын газрын Олон улсын эрүүгийн шүүхийг хариуцсан багтай байнгын харилцаатай байж дэлхий даяар явуулж буй кампанит ажлын талаархи мэдээлэл, өөрсдийн явуулсан үйл ажиллагааны тайланг хүргүүлж, тухай бүр саналаа солилцож байлаа. Мөн ОУЭШ-ийн асуудлаар үндэсний эвсэлтэй хамтран эрх зүйн сэтгүүлд судалгааны материал дээр үндэслэн хэд хэдэн нийтлэл хэвлүүлэв. Олон улсын шинжээч Жонаттан ОЭУШ-ийн Ромын Дүрэм ба МУ-ын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулин дээр харьцуулсан шинжилгээ хийж байна.

УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨХ АЖИЛ

Хятад улс: Амлалтыг нь сануулья

Эмнести Интернэшнл Бээжингийн Олимптой холбогдуулан Хятад улсын хүний эрхийн талаар авсан амлалтыг нь сануулах, авч буй арга хэмжээг нь эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Үүнд:

- Хятад дахь дээд шүүхээс гаргаж буй цаазаар авах ялын тоог багасгах, шүүх үйл ажиллагааны чанарыг сайжруулах

- Хятад дахь цаазаар авах ялыг багасгах

- Хятадад цаазаар авах ял авсан хийгээд цаазаар авахуулсан хүмүүсийн тоог албан ёсоор нээлттэй байлгах

- Хөдөлмөрөөр дахин хүмүүжүүлэх арга хэрэглэхийг хориглох

- Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, тухайлбал Хятад дахь хүний эрхийн төлөө тэмцэгчид олон улсын бие даасан хүний эрхийн шинжээчдээс дэмжлэг авахыг нь дэмжих

- Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн эсрэг хэрэглэгдэж буй үндэсний аюулгүй байдалд халдсан, улсын нууц гадаадад задалсан, төрийн эрх мэдэлд халдсан зэрэг эрүүгийн хуулийн зарим заалтыг хүчингүй болгуулах, өөрчлөх

- Тайван замаар мэдээлэл дамжуулснаас болж хоригдсон сэтгүүлчдийг суллах, гадаад дотоодын сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах, ямар нэг хяналт тавихгүй байх

- 1989 оны ардчиллын хөдөлгөөний хэрэгт албан ёсны мөрдөн шалгалтыг явуулж хохирогчдыг сонсон, дураар хорьж, доромжлох явдлыг эцэс болгох

- Олимпын цогцолбор барих төслийн хүрээнд хүчээр нүүлгэн шилжүүлэх явдлыг тайван замаар эсэргүүцэгсдийг суллах, цаашид ийнхүү дур зоргоор хорих явдлаас хамгаалах

- Өмгөөлөгчдийг цагдаагийн хорих байранд өөрийн үйлчлүүлэгчтэйгээ харилцах зэрэгт саад учруулахгүй байх болон хүний эрхийн зөрчлийн аюулаас ангид байгааг шалгах

- Мэдээллийн урсгалыг чөлөөтэй хүлээн авахыг хориглосон хууль дүрмийг халах

- Интернэтээс мэдээлэл хүлээн авч өөрсдийн үзэл санаагаа тайван замаар илэрхийлсний төлөө хоригдсон хүний эрхийн тэмцэгчид, сэтгүүлчдийг суллуулах



ОХУ

Эрхийнхээ төлөө шуугицгаая кампанит ажлын үеэр оюутны бүлгийн гишүүд Михайл Трепашкиныг суллуулахын төлөө 242 хүний гарын үсэг цуглууллаа.

Бид дараах үйл ажиллагааг зохион явуулаад байна

Олимпын тоглолт ба Хүний ярилцлага, хэлэлцүүлгийг сэтгүүлчид болон тамирчдын дунд зохион байгууллаа. Тус уулзалтад ТВ5, Ийгл, Таван цагариг сонин, МОНЦАМЭ агентлагийн сэтгүүлчид оролцсон бөгөөд Олимпизмын үзэл санааг дэмжиж, тамирчдад хүний эрхийн талаар ойлголт өгөх үйл ажиллагаанд нэгдэхээ Спортын төв ордны дасгалжуулагч илэрхийлсэн юм. Энэ үеэр Эмнести Интернэшнлийн сонин бичиг, ХЭТТ, Олимпын Өмнөх Үе: Хятад амлалтаа биелүүлэхгүй байна тайлан зэрэг гарын авлага материалуудыг тараалаа.

Бид ирэх 2 жилийн төлөвлөгөөндөө дараахь зорилгуудыг тавин ажиллах болно

- Хятадын засгийн газарт нөлөө үзүүлэх

- Бээжингийн Олимпоос өмнө хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр эрчимтэй ажиллах

- Орос Хятадад Хүний эрхийн нөхцөл ямар байгаа талаар бичихийг сэтгүүлчдэд уриалах

- Хятад дахь хэвлэлийн хянан шалгах байдлыг анхааран үзэх хүний эрхийн байдлыг ойлгуулах

- Цагаач ажилчдын тухай конвенцид нэгдэх талаар Өмнөд Солонгосын засгийн газарт лобби нөлөө үзүүлэх

- Стратегийн түншлэлтэй олон төрлийн оролцогчтой нөлөө үзүүлэхүйц кампанит ажлыг дэлхий даяар өрнүүлж хэрэгжүүлэх



БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛТ

Хүний эрхийн энэхүү хөдөлгөөний гол хүч нь дэлхий даяархи 2,2 сая гаруй гишүүд дэмжигчид билээ. Эдгээр гишүүд өөрсдийн сонирхол, ажил мэргэжил, газар зүйн байрлал, нас хүйс, их дээд сургууль, бага дунд сургуулиараа бүлэг болон нэгдэж, хүмүүст эрхийг нь таниулж, хүний эрхийн зөрчлийн эсрэг хамтдаа тэмцдэг юм. Эмнести Интернэшнлийн анхан шатны нэгж нь бүлэг. Монголын Эмнести Интернэшнл өнөөдөр 800 гаруй гишүүд, дэмжигчидтэй, Багш нарын бүлэг, Багануурын бүлэг, Дарханы бүлэг, Эрдэнэтийн бүлэг, Сэтгүүлчдийн бүлэг, Эрэгтэйчүүдийн бүлэг, Эмэгтэйчүүдийн бүлэг, Эмч нарын бүлэг, Хуульчдын бүлэг, Залуучуудын бүлэг, Сурагчдын бүлэг, Оюутнуудын бүлэг, Чөлөөт бүлэг, Урлагийн бүлэг, Үйлдвэрчний эвлэлийн бүлэг, Парламентийн бүлэг гэсэн 16 бүлэгтэй байна.

Хилийн Цэргийн Дээд Сургуулийн багш нарын бүлэг Хуульчдын бүлэгтэй нэгдлээ.

Гишүүнчлэлтэй холбогдох баримт бичгүүд

Гишүүнчлэлтэй холбоотой хоёр баримт бичгийг 2007 онд боловсруулсан байна.

1. “Гишүүдийн үнэлгээний шалгуур”-ыг 4 дүгээр сард зохиосон Бүх гишүүдийн уулзалтаар санаачлан 2007 оны 6 дугаар сард Удирдах зөвлөлийн хурлаар батлав. Энэ шалгуураар гишүүдийн оролцоог гишүүн өргөжүүлэлт болон олон нийтэд таниулах үйл ажиллагаа, кампанит ажил, сан арвижуулалт, сайн дурын үйл ажиллагаа, хүний эрхийн боловсролын хүрээнд бүлгийн ахлагч болон кампанит ажлын зохицуулагч, бусад баримтыг үндэслэн Ерөнхий чуулганаар шалгаруулж байх юм.

2. Гишүүд, дэмжигчид, бүлгийн идэвхи санаачлага, хүрээг өргөжүүлэх стратеги төлөвлөгөөг 2007 оны Ерөнхий чуулганаар хэлэлцүүлэхээр бэлдээд байна.

Энэ төлөвлөгөөгөөр МЭИ-ийн гишүүд, дэмжигч, бүлгийг 9 хүрээнд өргөжүүлэх юм. Эдгээр нь бүлгийн үйл ажиллагаа, идэвхитнүүд, нас, хүйс, мэргэжил, яс үндэс, газар зүйн байрлал, дэмжигч болон манлайллын хүрээнд 2008-2009 онд ямар түвшинд хүрэхийг тодорхойлжээ.

Бүх гишүүдийн уулзалт

Бүх гишүүдийн уулзалтыг улирал тутам үйл ажиллагаагаа үнэлэх, төлөвлөх, тайлагнах, шинэ бодлого, чиглэлийг таниулах зорилгоор сургалт, танилцуулга, сан арвижуулах үйл ажиллагаа, идэвхи санаачлагыг тусгасан ажил өрнүүлэх зэргээр явуулдаг юм.



“Ажлын дараах амралт”

нэртэй анхны уулзалтыг 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав. Уулзалтаар идэвхи санаачлагын шилдэг 10 төслийг танилцуулж Зэвсгийг хяная кампанит ажлын хүрээнд бага насны хүүхдүүдэд бууны хор уршгийг таниулж бууг өөр тоглоомоор солих ажлыг үлгэрлэн харуулав.

Мөн сан арвижуулах стратеги төлөвлөгөө танилцуулж гишүүд, бүлгээс санаачилсан дуудлага худалдаа, дэлгүүр, хүнсний бүтээгдэхүүн борлуулах зэрэг сан арвижуулах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн юм. Эрэгтэйчүүдийн бүлгээс “Гуантанамог хаая” уриан дор үзэл санааны хоригдлуудын байдлыг жүжигчлэн үзүүлж энэ тухай товхимолыг худалдан нийтдээ 50,000 төгрөгийн сан арвижуулалтыг хийжээ. Уулзалтанд 50 гаруй гишүүн оролцов.



“Эрүү шүүлтийн хохирогчдын төлөө 100 лаа”

асаах хоёрдугаар уулзалтыг 6 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Энэ үеэр эрүү шүүлтийн талаар шинээр хэвлэн гаргасан гарын авлагыг гишүүдэд танилцуулж хохирогчдын төлөө 100 лаа асааж хүндэтгэл үзүүлсний зэрэгцээ улс орнуудад эрүү шүүлтэнд өртөгсдийн төлөө уриалгад гарын үсэг зурцаалаа. Эмэгтэйчүүдийн бүлгээс лаа худалдах ажлыг санаачлан 16000 төгрөгийн сан арвижуулалт хийсэн юм. Үйл ажиллагаанд 40 гаруй гишүүд оролцов.



“Нэг Эмнести- Нэг үзэл баримтлал”

нэртэй гуравдугаар уулзалтыг 11 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулж гишүүдэд хөдөлгөөний шинэ үзэл баримтлалыг танилцуулахын зэрэгцээ өмнөх хугацаанд үйл ажиллагааг хэрхэн өрнүүлсэн тухай зохион байгуулсан гишүүдээр таницуулав. Энэ үеэр гишүүдэд зориулсан мэдээллийн багц болон санал хүсэлтийн хайрцгийг танилцууллаа.

Уулзалтанд 60 гаруй гишүүд оролцож Сая сая дүр төрх аян, сан арвижуулах номын худалдаанд оролцов.



“Эмнести Кафе”

дөрөвдүгээр бүх гишүүдийн уулзалтыг 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулав. Уулзалтаар гишүүдийн дунд ХЭТТ-ын 60 жилийн ойг хэрхэн зохион байгуулах, МЭИ-ийн ардчиллыг бэхжүүлэхийн тулд дүрэмд хэрхэн өөрчлөлт оруулах, таних тэмдэгийг хөдөлгөөнтэй хэрхэн ижилсүүлэх тухай хэлэлцүүлэв. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд эрэгтэйчүүдийн бүлгээс энэ үйл хэрэгт эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх уриалгад гишүүдээр гарын үсэг зуруулж, оксидын аюулгүй байдлын төлөө зурагт хуудсаар үзэсгэлэн гаргав.

Гишүүдээс ирсэн санал, санаачлагыг ЭИ-ийн захирлуудын хурал, Ерөнхий чуулганаар хэлэлцэх асуудалд уламжилж байна.

Эдгээр хурлууд гишүүдэд хөдөлгөөний болон салбарын хүрээнд үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, түүнд гишүүд хэрхэн хувь нэмэрээ оруулж,

санаачлагаа хэрэгжүүлэх вэ гэдэгт шинэ арга зам, бололцоог хангахын зэрэгцээ хариуцлагыг нэмэгдүүлж дотоод ардчиллыг бэхжүүлэхэд ач холбогдолтой байлаа.

Бүлгийн уулзалтууд

Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг гишүүд, бүлгүүд санаачлан зохион байгуулдаг билээ. Энэ санал санаачлага нь үр дүнтэй төлөвлөгдөж, иргэдийн дунд бодитой хэрэгжиж, гишүүд дэмжигчдийнхээ идэвхи санаачлага, ардчиллыг бэхжүүлснээр үр нөлөөтэй болдог юм.

Эмнести Интернэшнлийн бусад салбарын бүлгүүдтэй адил Монголын салбарын бүлгүүд ч өөрсдийн бүлгийн уулзалтаа зохион байгуулж гишүүдээ үйл ажиллагаанд хамруулж байв. Залуучуудын бүлэг, Багш нарын бүлэг, Үйлдвэрчний эвлэлийн бүлэг, Хуульчдын бүлэг, Эмэгтэйчүүдийн бүлэг, Сэтгүүлчдийн бүлэг, Урлагийн бүлэг, Эрэгтэйчүүдийн бүлэг, Чөлөөт бүлэг өөрсдийн хурлыг зохион байгуулж Дарфурын төлөөх өдөр, Цаазаар авах ялын талаархи хэлэлцүүлэг, Цаазаар авах ялын тухай зургийн үзэсгэлэн, жендэрийн тухай хууль болон хүний наймааны талаархи лобби үйл ажиллагаа, хүний эрхийн боловсролын сургалт, уралдаан, сан арвижуулах төлөвлөгөө, ОУЗХ-ын хэлэлцэх асуудлаархи хэлэлцүүлэг, Хорих байгууллагын боловсрол төсөл, Хүч ба галт зэвсэг гарын авлага боловсруулах, Бирмийн төлөө дэлхийн жагсаал, бүх гишүүдийн уулзалтууд, Бээжингийн олимп, ЭЗНСЭ-ийн талаархи сургалтууд, хүний эрхийн гэх мэт кампанит ажил хурал уулзалт, сургалтууд зэрэг олон ажил амжилттай хэрэгжсэн нь эдгээр хурлын үр дүн юм. Бүлгийн зохион байгуулалт, ардчиллыг бэхжүүлэх бүлгийн ахлагч нарын үүрэг хариуцлагын талаархи удирдамжтай болсон тул бүлгийн ахлагч нар маань цаашид мөрдөн ажиллаж бүлгийн үйл ажиллагаагаа тогтворжуулна гэж итгэж байна.

Гишүүдийн сургалт

Хүний эрхийн боловсрол, ур чадвар нь үр дүнтэй кампанит ажил явуулах үндэс болдог юм. Иймээс Эмнести Интернэшнлийн гишүүн бүр хүний эрхийн талаархи сургалтанд хамрагдах боломжтой байдаг.

Шинээр элссэн гишүүн бүрт Эмнести Интернэшнл болон хүний эрхийн талаар ерөнхий ойлголтыг өгөх сургалтанд хамрагддаг юм. 2007 онд шинээр элссэн гишүүдийнхээ 70 гаруй хувийг энэ сургалтанд хамруулснаас оролцогчдын ихэнхи нь үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна. 2007 онд манай гишүүд

- Хүний эрхийн талаархи ойлголт,
- Хүний эрхийг хамгаалах механизм,
- Бизнес ба хүний эрх,
- Цаазаар авах ял,
- Эрүү шүүлт,
- Манлайлал,

- Харилцааны соёл,
- Төсөл бичих,
- Кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах сургалтанд хамрагдсан юм.

Мөн Хорих байгууллагын боловсрол, ЕБС-ын багш нарт зориулсан хүний эрхийн боловсролын сургалт, Хүч ба галт зэвсэг хэрэглэх тухай гарын авлага бэлтгэх зэрэг төслийн хүрээнд сургагч багшаар бэлдэх сургалтанд хамарагдсан байна. Нийт идэвхитэн гишүүдийнхээ 60 гаруй хувь буюу 100 гаруй гишүүнийг сургалтанд хамрууллаа.

Гишүүнээр элсүүлэх

Хүний эрхийн талаар мэдлэгтэй больё, дэлхийн хүний эрхийн төлөө үйлсэд нэгдье гэсэн олон сая хүн Эмнести Интернэшнлийн гишүүнээр элсэх нь өсөн нэмэгдсээр байна. Бидний явуулсан сургалт, олон нийтэд таниулах үйл ажиллагаа, найз нөхдийн холбоо, кампанит ажил, интернэт үйл ажиллагаагаар биднийг дэмжигч гишүүд нэмэгдсээр байгаа нь 2007 онд шинээр 150 гаруй хүн гишүүнээр бүртгүүлснээс харагдана. Олон хүнд энэ боломжийг олгож, гишүүнээр элсэх үйл ажиллагааг нээлттэй болгохын үүднээс бид интернэтээр болон нүүр тулан уулзах аргаар элсүүлэх шинэ арга техникийг судалж байна.

Мөн өөрсдийн хүрээг хөдөө орон нутагт өргөжүүлэх төлөвлөгөөний дагуу Дархан, Эрдэнэт хотноо сургуулийн шинэ бүлэгтэй боллоо.

Орон нутагт хүрээгээ тэлсэн нь

Монголын Эмнести Интернэшнл, VSO олон улсын сайн дурынхны байгууллагатай хамтран 2007 оны 11 дүгээр сарын 12-16-ны хооронд “Идэвхитэн залуучуудын бүлэг” байгуулах сургалтыг Эрдэнэт, Дархан хотод зохион байгууллаа. Сургалтанд Эрдэнэт, Дархан хотын 50 сурагч оролцож Эмнести Интернэшнлийн тухай, хүний эрхийн талаар мэдээлэл авахын зэрэгцээ Сайн дурын үйл ажиллагааны ач холбогдол, бүлгээр ажиллах болон бүлгийн хурал уулзалтаа үр дүнтэй зохион байгуулах, кампанит ажлын төлөвлөгөөг боловсруулах, үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллээр сурталчилах тухай сургалтанд оролцон сургалтаар боловсруулсан төлөвлөгөөний дагуу хүний эрхийн төлөө сайн үйлсийн кампанит ажлыг зохион байгуулсан юм.



Эрдэнэт хотноо Баян Өндөр цогцолбор сургуулийн 25 сурагч оролцож

a. Насанд хүрээгүйчүүдэд тамхи согтууруулах ундаа худалдаалахыг зогсоох тухай уриалгад гарын үсэг цуглуулах

b. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн талаар хүнсний захад сурталчилгаа хийж, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн дунд зургийн уралдаан зохиох,

c. Зэвсгийн хяналт, худалдааны талаархи олон улсын гэрээг дэмжих Сая Сая дүр төрх аянд иргэдийн зургийг авах кампанит ажлыг амжилттай өрнүүлэв.

Эдгээр аяны хүрээнд баг тус бүр 300 гаруй иргэдийг хамруулж, Согтууруулах ундаа худалдаалж буй баримтыг орон нутгийн цагдаагийн газар, хэвлэл мэдээлэлд хүргэлээ.

Дархан хотод Математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 19 дүгээр сургуулийн 25 сурагч сургалтанд оролцож

d. Насанд хүрээгүйчүүдийг гэмт хэргээс сэргийлэх тухай уриалга

e. Насанд хүрээгүйчүүдийг согтууруулах ундаа хэрэглэхээс сэргийлэх, тэдэнд согтууруулах ундаа худалдаалахыг зогсоох аргыг иргэдээс цуглуулах

f. Чанартай хүнсээр хангагдах эрхээ эдэлж байгаа эсэх талаар санал асуулгыг авлаа.

Дархан хотод зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан 300 гаруй иргэдийн санал хүсэлт, гарын үсгийг Мэргэжлийн хяналтын алба болон хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх тухай сургалтанд оролцогч цагдаа нарт хүлээлгэн өглөө.

Ийнхүү оролцогчдод сургалтаар олж мэдсэн, сурсан зүйлсээ ашиглан кампанит ажил зохион явуулах боломж олдсон нь цаашид үйл ажиллагаа зохион явуулах дадлага туршлага болсон төдийгүй үйл ажиллагаа явуулах эхлэл болж өгсөн юм. Мөн кампанит ажлыг сургалтанд оролцогчид өөрсдөө удирдаж явуулсан нь сайн дурын үйл ажиллагааны ач холбогдлыг ойлгож мэдэхэд түлхэц болж өгсөн юм.

Сургалтыг Монголын Эмнести Интернэшнлийн өсөлт хөгжилт харилцаа хариуцсан зохицуулагч А.Отгончимэг, Залуучуудын бүлгийн гишүүн М.Гэрэлмаа, Н.Лхагвасүх болон VSO сайн дурынхны байгууллагын ажилтан Роберт Слинн нар удирдаж явууллаа. Эдгээр сургалт Эрдэнэт хотын Баян Өндөр цогцолбор сургуулийн гүйцэтгэх захирал Ихзаяа,

Дархан хот дахь Монгол-Германы хамтарсан 19 дүгээр сургуулийн багш Доржийн санаачлага, тусалцаагүйгээр амжилтанд хүрэхгүй байсан.

Сургалтанд оролцсон бүх хүүхдүүд эв санаагаа нэгтгэн Эмнести Интернэшлийн бүлгийг байгуулав. Байгуулагдсанаасаа хойш өөрсдийн үйл ажиллагааг сургуульдаа сурталчилахаас гадна, Олон Улсын Хүний эрхийн өдөр буюу 12 дугаар сарын 10-ны өдөр дэлхий даяар өрнөж байгаа захидал уриалга бичих марафоныг орон нутагтаа зохион байгуулж 600 гаруй гарын үсэг цуглуулав.

Багануурын бүлгийн үйл ажиллагаа

2007 онд Багануурын бүлэг 3 үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулсан юм. Дарфурын төлөө дэлхийн өдрөөр залуучуудын бүлгийн гишүүн Буянхишиг интернэт кафедр онлайн уриалгад гарын үсэг цуглуулах үйл ажиллагаа явуулж 50 гаруй хүнийг нэгдүүлэв. Мөн ХЭТТ-ын 60 жил бидний амьдралд зургийн болон зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулж 20 гаруй сурагчийг оролцуулжээ. Хүний эрхийн өдрөөр ч захидал уриалгад гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг явуулж 90 гаруй хүний гарын үсгийг цуглуулж өөрсдийн хүрээгээ өргөжүүлж 15 гаруй гишүүдтэй болоод байна.



ЗАЛУУЧУУД

Эмнести Интернэшнл залуучуудын стратеги төлөвлөгөөгөө 2005 онд боловсруулан залуучуудын байгууллага, хөдөлгөөн болохоор ажиллаж байгаа билээ. Стратегийн зорилго нь хүн бүр эрхээ эдэлж чаддаг тэр л ертөнцөд залуучууд айх аюулгүй урам зоригоор дүүрэн байхад оршино. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд залуучуудыг оролцуулах, тэдний төлөө ажиллах, үйл ажиллагааг нь холбох, орон нутгийн болон дэлхийн хэмжээний үйл ажиллагааг явуулах боломжийг олгон байгууллагынхаа бүх түвшин дэх залуучуудыг нэгтгэн нийлүүлэх зорилттой юм.

Монголын Эмнести Интернэшнлийн залуучуудын бүлэг ч өөрсдийн стратегийг 2006 оны Ерөнхий чуулганаар баталж амжилттай хэрэгжүүлж байна.

2007 онд Сурагч, Оюутан, Залуучуудын бүлэг олон сургалт, олон нийтэд таниулах ажил, кампанит ажлыг амжилттай хэрэгжүүлж, идэвхижилт, манлайллаараа тэргүүлж байна. Тэд 2007 онд залуучуудыг оролцуулан, тэдний төлөө үйл ажиллагаа холбон идэвхи санаачилга, манлайллыг нэмэгдүүлсэн дараах ажлыг гүйцэтгэжээ.

Залуучууд, оюутнуудын дунд Цаазаар авах ял, Хүүхдийн эрх, Бизнес ба хүний эрх, Залуучуудын кампанит ажлын талаар хэлэлцүүлгийг өргөнөөр явууллаа. Хэлэлцүүлгийг 6 их дээд сургууль, хотын төв номын санд нийт 250 гаруй залуучуудад явуулжээ.

Гишүүдийнхээ чадавхийг бэхжүүлэхийн тулд Хүний эрхийн англи хэлний ярианы курс, Эмнести Интернэшнлийн талаархи сургалт, хувийн танилцуулга анкет боловсруулах, Дарфур болон Гуантанамо дахь хүний эрхийн зөрчил, сайн дурын үйл ажиллагаа, мэтгэлцээн, сан арвижуулалт, манлайллын талаар сургалт зохион байгуулсан байна.

Эмнести Интернэшнлийн хөдөлгөөний болон байгууллагын шийдвэр гаргах түвшинд ч залуучууд оролцож байна. Удирдах зөвлөлийн залуучуудын зөвлөх Г. Гангамөрөн Хонгконгд 2007 оны 6 дугаар сард болсон Ази Номхон Далайн бүсийн Залуучуудын Симпозиумд оролцож өөрийн байгууллагын залуучуудын идэвхи санаачлага, үйл ажиллагааны талаар туршлага солилцов. Мөн залуучуудын бүлгийн гишүүн Э.Өлзийбат Мексик улсад Олон Улсын Зөвлөлийн Хуралд залуу төлөөлөгчөөр оролцлоо.

Оролцсон үйл ажиллагааныхаа талаар төлөөлөгчид залуучууд, гишүүддээ танилцуулж тайлагналаа.

Хамтын ажиллагаа

Хүүхэд залуучуудын байгууллагатай ч залуучуудын бүлэг хамтран ажиллаж байдаг. Сайн дурынхны байгууллагуудын үндэсний сүлжээний хурал, сургалт зохион байгуулахад оролцож сүлжээний гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож байна.

Олон улсын сайн дурынхны өдрөөр болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцлоо. Залуучуудын бүлгийн гишүүн Балдорж, Мөнхжавхлан нар сайн дурынхны талаархи сургалтанд оролцож ирээд өөрсдийн байгууллагын сайн дурынхандаа сургалт зохион байгуулж сайн дурынхны төлөвлөгөөг боловсруулсан юм. Монголын Эмнести Интернэшнлийн сайн дурынхан өргөжиж байгааг харж болно. Мөн 9 гишүүн Монголын Скаутын холбоотой хамтран олон улсын жемборид оролцож хүний эрхийн өртөө ажиллуулаа. Уг чуулга уулзалтанд 400 гаруй оролцогч хамрагджээ. Мөн Скаутын холбооны сайн дурынханд зориулсан сургалтанд туслах багшаар ажиллав.

Олон нийтийг хамруулсан ажиллагаа

Залуучуудынхаа дунд хүний эрхийн талаар таниулах сонирхолтой үйл ажиллагаа өрнүүлсэн нь “Эрхээ эдэлж чадвал шоколад шиг амтагдана” асуулт хариултын тэмцээн байлаа. Энэ үйл ажиллагааг хоёр дахь жилдээ зохион байгуулж байна. 2007 онд ХААИС, МУБИС, ШУТИС, ЭМШУИС, МУИС дээр зохион байгуулж 385 оюутныг хамруулжээ. Энэ үеэр Сая сая дүр төрх аяныг сурталчилан 85 гаруй хүний зургийг нэмж оруулсан байна. Үйл ажиллагааг зохион байгуулахдаа шинээр элссэн 10 гаруй гишүүдийг хамруулжээ.

Төлөвлөлт, шийдвэр гаргах болон хариуцлагатай байх

Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

2007 он бол Монголын Эмнести Интернэшнлийн Удирдах Зөвлөлийн манлайлал, ур чадвар улам сайжирсан жил болж өнгөрлөө. МЭИ-д бүтцийн эрх олгох Олон Улсын Үнэлгээний Багийн дүгнэлт, зөвлөмжинд УЗ анхаарлаа хандуулж, хэд хэдэн баримт бичиг боловсруулан гаргасан юм. Ингэхдээ зөвхөн баримт бичгийг батлаад зогсохгүй хэрэгжүүлэх талаар анхаарч ажилласан.

Удирдах зөвлөл 2007 онд ээлжит 6, ээлжит бус 4 удаа хуралдав. Ажилтнуудыг шалгаруулах, үнэлэх, УЗ-ийн гишүүдийн зан үйлийн дүрэм, Хүний нөөцийн бодлого, сан арвижуулах төлөвлөгөө, үнэлгээний багийн дүгнэлт, гишүүний татвар, санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, гадаадад оролцогчдыг томилох, олон улсын хурал чуулганд оролцогчдын тайлан сонсох, гишүүний үнэлгээний шалгуур, гишүүд, дэмжигчдийн хүрээг нэмэгдүүлэх төлөвлөгөө, эрсдлийн үнэлгээ зэрэг асуудлаар хэлэлцэж зохих шийдвэрүүдийг гаргаж байсан байна.

2007 оны 6 дугаар сарын 07-нд баталсан Монголын Эмнести Интернэшнл байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүний ажил үүргийн хуваарь, үнэлгээний шалгуур баримт бичгийг үндэслэн УЗ-ийн гишүүд өөрсдийн болон байгууллагын үнэлгээг хийлээ. Үнэлгээгээр УЗ-ийн гишүүд МЭИ –ийн

1. Үйл ажиллагаа дүрмийн дагуу системтэй явагддаг
2. Бүлгүүдийн идэвхи санаачлага өссөн
3. Олон улсын төвөөс ирсэн аудиторын үнэлгээгээр сайн гарсан
4. Үйл ажиллагаа тогтмолжсон
5. Хүний эрхийн салбарт тэргүүлэх чадвартай
6. Идэвхитнүүд, УЗ-ын хариуцлага өссөн гэсэн дүгнэлтийг өгч үйл ажиллагааг сайн явагдаж байна гэж үнэлсэн юм.

“Байгууллагын нууц”, “Сонирхолын зөрчил” гэх мэт ёс зүйтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх тодорхой бодлого, журам болон УЗ-д шаардлагатай байгаа ур чадвар бүхий хүмүүсийг судалж, хүний

нөөцийн стратеги боловсруулах, сан арвижуулах ажиллагааг сайтар төлөвлөн үнэлэн байршуулах асуудал хангалтгүй байна гэж УЗ-ийн гишүүд дүгнэжээ. Түүнчлэн цаашид хүний нөөц, гишүүн өргөжүүлэлт, үйл ажиллагаагаа сурталчлах ажиллагаагаа сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Олон Улсын Зөвлөлийн Хурал 2007

Олон Улсын Зөвлөлийн Хурал /ОУЗХ/ нь Эмнести Интернэшнлийн шийдвэр гаргах хамгийн том байгууллага юм. ОУЗХ-нь хоёр жил тутам хуралдаж хөдөлгөөний төлөвлөгөөг хэлэлцэн томоохон шийдвэрүүдийг гаргадаг байна. Олон улсын зөвлөлийн хуралд хөдөлгөөний салбарууд болон удирдах байгууллагуудаас нийт 450 гаруй зочид төлөөлөгч оролцдог юм.

Өмнөх болон ирэх ОУЗХ-ууд дараах онцлогтой байна.

ОУЗХ 2001: “Бүрэн эрхээс үзэл баримтал”-аа тодорхойлсон.

ОУЗХ 2003: “Үзэл баримтлалаас төлөвлөлт” – Шударга ёсыг даяарчлах Уялдаат стратеги төлөвлөгөөг баталсан.

ОУЗХ 2005: “Төлөвлөлтөөс үйл хэрэг рүү” – Залуучууд, хүний эрхийн боловсрол, өсөлт болон хэлний стратеги төлөвлөгөөнүүдийг баталсан байна. Мөн өөрсдийн үйл ажиллагааг тайлагнасан

ОУЗХ 2007: “Үйл хэргээс үр нөлөө, хариуцлагын үнэлгээ рүү” - Уялдаат стратеги төлөвлөгөөнийхөө үр нөлөө, хариуцлагыг хэлэлцэн, Эмнести даяарчлах “Нэг Эмнести” бодлого хэрэгжүүлэх

ОУЗХ 2009: “Үнэлгээнээс төлөвлөлт рүү” -2004-2010 оны Уялдаат стратеги төлөвлөгөөг үнэлэн 2010 – 2016 оны төлөвлөгөөгөө боловсруулах юм.

Өмнөх жилийн хурлуудад УЗ-ийн Дэд дарга С.Эрдэнэ оролцож байлаа. 2005 оноос залуучуудын төлөөлөл оролцож байна. Энэ жилийн хурал Мексикийн Морелос хотод зохиогдсон бөгөөд Монголоос Захирал Б.Алтантуяа, УЗ-ийн гишүүн Б.Оюунбадам, залуучуудын бүлгийн гишүүн Э.Өлзийбат нар оролцов. Мөн өсөлт хөгжлийн зохицуулагч А.Отгончимэг сайн дурын ажилтнаар ажиллав.

2007 оны энэ хуралд манай салбар идэвхитэй оролцож анх удаа хурлаар хэлэлцэх асуудлуудаар гишүүдийнхээ саналыг авч хэлэлцүүлэг явууллаа.

Ардчилал, харилцаа холбоо, идэвхижилт, хүнийг хүндэлж кампанит ажил, бэлгийн болон нөхөн үржихүйн бодлогыг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, залуучуудын стратеги төлөвлөгөө зэрэг асуудлаар хэлэлцэн саналаа өгсөн.

Төлөөлөгчид хурлын үеэр өөрийн байгууллагын туршлагын талаар илтгэл тавьж идэвхитэй оролцлоо.

Хурлаас ирээд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхээр нэлээн хэдэн уулзалтанд танилцуулга хийж хэрэгжүүлж эхлээд байна.

ОУНБДНГ-ын Аудиторын айлчлал

ОУНБДНГ-ын Үйл ажиллагааны аудитор Кишор Датани МЭИ байгууллага дээр 2007 оны 9 дүгээр сарын 24-өөс 10 дугаар сарын 3-ныг хүртэлх хугацаанд ажиллалаа.

Айлчлалын зорилго нь МЭИ-д ЭИ-ийн салбаруудад тавигдах наад захын үйл ажиллагааны хэм хэмжээнд хүрч ажиллахад туслах, сайжруулах байв.

Үүнд:

- МЭИ-ийн дотоод хяналт, санхүүгийн үйл ажиллагаа;

- МЭИ-ийн УЗ болон Ерөнхий чуулганы шийдвэрийн хэрэгжилт;

- МЭИ-ийн бүх санхүүжилт болон төслийн баримтжуулалт болон хариуцлагын талаархи шалгалт хийжээ.

Шалгалын ерөнхий үнэлгээгээр МЭИ бүтцийн хувьд эрүүл хяналт, процедуртай. Санхүүгийн болоод дотоод аливаа зөрчилгүй. Удирдах зөвлөл болон гүйцэтгэх товчооны харилцаа сайн. Удирдлага шударга, зүтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Хүний эрхийн боловсролын номын сан

МЭИ хүний эрхийн боловсролын номын санг 1998 оноос ажиллуулж байгаа билээ. Үүнд хүний эрх, хүний эрхийн боловсрол, цаазаар авах ял, эрүү шүүлт, олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрүүд, кампанит ажлын гарын авалага, төрийн бус байгууллагын удирдлага, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн талаарх ном хэвлэл, хүүхдийн эрх, эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн тэгш байдлын талаархи асуудал, дүрвэгчид, цагаачид, монголын хууль, эрх зүй, тогтоомжууд, ардчилал, цагдаа хорих байгууллагатай холбоотой 1000 гаруй ном товхимол байдаг. Номын сан их дээд сургуулиудын дунд байдаг бөгөөд уншигчиддаа үнэ төлбөргүй үйлчилдэг юм.

Номын сан маань хувь хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллагуудын хандив, тусламжаар улам өргөжсөөр байна. 2007 онд 100 гаруй ном хандиваар иржээ. Мөн 200 гаруй уншигчдад үйлчилсэн байна. Номын каталог хөтлөх, бүртгэх зэрэг үйл ажиллагааг сайн дурын ажилтнуудын тусламжаар гүйцэтгэж байна.

**Сан арвижуулалт**

а. Сан арвижуулах стратеги төлөвлөгөө

МЭИ-ийн шинэ стратеги төлөвлөгөөний нэг нь 2007-2010 онд сан арвижуулах стратеги төлөвлөгөө юм. Энэ төлөвлөгөөг сан арвижуулагч зохицуулагч Карл Уэтам удирдан гишүүд, УЗ, идэвхитнүүдийг оролцуулан олон удаагийн уулзалт хийж зорилго зорилтоо тодорхойлон, нөхцөл байдлыг шинжлэн, төлөвлөгөө боловсрууллаа.

Энэхүү стратеги төлөвлөгөө олон нийтэд байгууллагыг сурталчлах, бүлгүүдийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мэргэжлийн бүлгүүдийг байгуулах зорилтуудыг тавьжээ. Стратеги төлөвлөгөөг гүйцэтгэх товчоо, бүлэг, удирдах зөвлөл оролцсон Сан арвижуулах хороо удирдаж байна.

б. Сан арвижуулах

Сан арвижуулах стратеги төлөвлөгөөний зорилго зорилтын дагуу бүлэг, гишүүд сан арвижуулах олон ажлыг санаачлан хэрэгжүүллээ. Эдгээрээс залуучуудын бүлэг гишүүн бүртэй сан арвижуулах хайрцаг өгч хандив цуглуулах, ном худалдах, кампанит ажлын үеэр хандивийн хайрцаг ажиллуулах, хүнсний бүтээгдэхүүн хийж борлуулах зэргээр ажиллаж 230000 гаруй төгрөгийн сан арвижуулалт хийжээ. Чөлөөт бүлэг, Эмэгтэйчүүдийн бүлэг, багш нарын бүлэг, эрэгтэйчүүдийн бүлэг, хуульчдын бүлэг, сэтгүүлчдийн бүлэг, үйлдвэрчний эвлэлийн бүлэг дуудлага худалдаа зохион байгуулах, бараа бүтээгдэхүүн борлуулах, зардлыг хэмнэх зэргээр сан арвижуулалт хийлээ. 2007 онд бүлгүүдийн сан арвижуулах үйл ажиллагаанаас 875 ам долларын орлого орсон байна. Бүлгүүд сан арвижуулалтаар олсон орлогоо санхүүжилт дутуу үйл ажиллагаандаа зориулав.

Гүйцэтгэх товчоо мөн Зэвсгийг хяная, хүч ба галт зэвсэг, хорих байгууллагын боловсрол, Хүний эрхийн боловсролын томоохон төслүүдэд олон улсын хандивлагч нараас санхүүжилтийг олсон байна. 2007 онд гишүүд, хандивлагч нараас орж ирсэн орлого 6303.28 ам.доллар байна.

<p>Олон Улсын ажлаалуудын хурал 2007</p>	<p>Мехикоийн Морелос хот, 8-р сарын 12-16 Б.Алтантуяа, Р.Оюубадрам, Э.Өгөнбатыс, А.Огосончимог (сайн дурын ажилтнууд)</p>	<p>Эмнэлэг дөвөрчлөх - Хүний эрхийн үйл ажлалзаны 3р нөхцөл хэмээх, харуудлага, хэрэглээ хэлбэр, төлөвлөгт, дэлхий даяар хароохуулын компанийн ажлууд, төлөвлөгт, Олон улсын гүйцэтгэх ажиллагайн сонгууль Бүсийн уулзалтууд Хөдөлгөөний асуудлуудад амьдрал гаргах Компанит ажлын хүрээнд хийсэн ажлаа дүгнэх Хятадын хүний эрхийн нөөцөл байдал Хятадын ашигтүүрийн байр суурь Бразилийн олонхийн компанит ажилд харгалзах ЭН-ийн гол үрэл Салбаруудын ажлын ажиллагаа</p>
<p>Бразил-Олон компанит ажлын ажлаалуудын нарын хурал</p>	<p>Колонгтон 1-р сарын 27-28 П.Жаргал</p>	<p>Зөвлөгүүдийн хурал "Нэг Эмнэлэг - Нэг тэрг"- ийн болгож ажил зорсон ажилдаа байгаа, ХЭТТ - ын 60 жил, ЭЗНС-ийн компанит ажлын ажилтайг зорон тандатгах, нэгдсэн төлөвлөгөөнд зорсон үйл ажиллагаагаа уялдуулах, үйл ажиллагааны 3 дугаар төлөвлөгөөг хийх талаар ярихдаг, хүний эрхийн үйл ажиллагааны 3р нөхцөл зорсон уналзах, шалгуур бий болгох зорил асуудал</p>
<p>Зөвлөгүүдийн хурал</p>	<p>Мадрид, Барселон 12-р сарын 3-5 Б.Алтантуяа</p>	<p>Зөвлөгүүдийн хурал "Нэг Эмнэлэг - Нэг тэрг"- ийн болгож ажил зорсон ажилдаа байгаа, ХЭТТ - ын 60 жил, ЭЗНС-ийн компанит ажлын ажилтайг зорон тандатгах, нэгдсэн төлөвлөгөөнд зорсон үйл ажиллагаагаа уялдуулах, үйл ажиллагааны 3 дугаар төлөвлөгөөг хийх талаар ярихдаг, хүний эрхийн үйл ажиллагааны 3р нөхцөл зорсон уналзах, шалгуур бий болгох зорил асуудал</p>
<p>Хүний эрхийг амгалангчдын сургалт</p>	<p>Шинэ Зеланд Веллингтон С.Огосончимог Nov 19- Dec 4</p>	<ul style="list-style-type: none"> • Хүний эрхийг хамгаалах төлөвлөгөө • Соёлын өмч, хэрэглэн байгаа эрхэн, ажиллагаа ажлаалууд болон компанийн нийгмийн харуудлага зорил асуудал олон улсын гарцаа хэлэлцэхийн хэрэгжлэгэнд харсан нөхцөлөө • Хүний эрх ажиллагаа асуудал <ul style="list-style-type: none"> • Хүний эрхийг амгалангч • Хүний эрх, ажилга, хүрээлэн буй эрхэн хэлэлцэл • ХЭБ сургуулиудад

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

“Хүний эрх – Сургалтын хөтөлбөрт” төсөл

Хүний эрх, эрх чөлөөг эн тэргүүнд тавьж, хөгжлийн шинэ бодлого хүн рүүгээ илүү анхаарлаа хандуулж байгаа өнөө үед хүн бүр хувийн эрх, эрх чөлөө ба аюулгүй байдлаа хангах, бие бялдар, оюун ухааны хувьд бололцоотой хамгийн дээд түвшинд хүрч хөгжих эрхтэй юм. Тэгвэл хүнийг хөгжилд хүргэж амьдралын чанарыг сайжруулахад гарцаагүй шаардлагатай хэрэглэгдэхүүн нь боловсрол юм. Иймээс Хүний Эрхийн Боловсрол нь Чанартай Боловсролын нэг салшгүй хэсэг бөгөөд Дакарын Хурал болон Мянганы Тунхаглалд: “Бүх нийтийн чанартай боловсролд хүрэх, ингэснээр бие хүнийг хөгжилд хүргэх боловсролыг эзэмшүүлэх ба улмаар ядуурлыг бууруулан, хүмүүсийн амьдрах чадварыг дээшлүүлж чадсанаар тогтвортой хөгжилд хүрнэ” гэж тунхагласан байдаг. Монголын Эмнести Интернэшнл байгууллага ч энэ зорилгыг дэмжин 2007 онд үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгож, Монгол-Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Нийслэлийн Боловсролын Газар болон орон нутгийн Боловсрол Соёлын Газрын ажилтнуудтай хамтран ажиллав.

Үйл ажиллагааны гол зорилго нь Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүний эрхийн талаархи мэдлэг боловсрол болон эрхэд суурилсан боловсролын талаархи мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн эрхэд суурилсан чанартай боловсролыг дэмжих, хүний эрхийг бүхий л боловсролын тогтолцоогоор, ЕБС-ийн хичээлүүдээр нэгтгэх замаар суралцагчдад суралцах таатай орчинг бүрдүүлэн чанартай боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахад оршиж байлаа.

Сургалт

Энэхүү төслийн хүрээнд “Хүний эрх- Сургалтын хөтөлбөрт” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Улаанбаатар, Говьсүмбэр, Дорнод аймаг, Налайх дүүргийн нийт 763 багш, сургуулийн удирдлага, Боловсрол Соёлын Газрын арга зүйчид, Хүүхэд хамгаалал Төвийн ажилтнууд хамрагдлаа. Өнгөрсөн жил болон энэ жил сургалтанд оролцогсдын бүтцийг авч үзвэл нийт 763 оролцогчдоос орон нутгийн БСГ-ын арга зүйч 18, сургуулийн захирал 11, сургалтын менежер 120, нийгмийн ажилтан 89, ЕБС-ийн багш 509, цэцэрлэгийн арга зүйч 8, цэцэрлэгийн эрхлэгч 3, Хүүхэд Хамгаалал Төвийн ажилтан 5 байлаа.

Энэ сургалтын нэг үндсэн санаа нь ЕБС-ийн хичээл бүрээр хүний эрхийг нэгтгэж заах тухай ойлголтыг өгөх явдал байсан ба энэ чиглэлийн дадлага, бүлгийн ажил нь байгаль, нийгмийн болон хүмүүнлэгийн хичээлүүдийн нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн ба

хүн ирээдүйдээ байгаль, нийгмийн аюулгүй орчинд амьдрах арга ухаан, иргэншлийн өндөр соёлыг эзэмшсэн байхын чухлыг шавь нартаа мэдрүүлэхэд багш нарт туслах явдал байлаа.



Сургалтанд оролцогчдод сертификат олгосон бөгөөд сургалтыг багш нарын мэргэжлийн заах арга зүйг шинэ агуулгаар баяжуулж, хичээлийг амьд хичээл болгох, хүүхдэд эрхийн мэдрэмжийг хөгжүүлж, чанартай боловсрол эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болж байна гэж үзэж аймаг, нийслэлийн боловсролын газраас сургалтанд оролцсон бүх багш нарт 1 кредит цаг олгож дэмжиж ажиллалаа. Энэ нь багшид багшлах ажлын ур чадвараа дээшлүүлж, мэргэжлийн зэргээ ахиулахад нь багшид бас нэг чухал хувь нэмэр болсноороо төслийн нэг гол ач холбогдол боллоо.

Дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт иргэншлийн хичээлийн эзлэх байр суурь өсөн нэмэгдэж байгаа энэ үед энэхүү төслийн хүрээнд хийгдэж байгаа сургалтууд болон сургалтын гарын авлага материалууд нь ЕБС-ийн багш нарт чухал хувь нэмэр боллоо гэж сургалтад оролцогчид болон орон нутгийн Боловсрол, Соёлын Газрын ажилтнууд өндрөөр үнэллээ.

Орон нутагт өөрийн байгууллагыг сурталчлан таниулах, гишүүд дэмжигчдийн эгнээг өргөтгөхөд уг сургалт зохих хувь нэмрээ оруулсан юм. Сургалтанд оролцогчдоос манай байгууллагын гишүүн болохоор нийт Дархан хотоос 5, Улаанбаатар хотоос 6, Эрдэнэт хотоос 3, Дорнод аймгаас 2, Багануур дүүргээс 3 багш санал хүсэлтээ ирүүллээ.

Хүний эрхийг хичээл бүрээр нэгтгэж заах нь

Сургалтуудыг оролцооны аргаар зохион байгуулсан бөгөөд дунд сургуулийн хичээлүүдээр хүний эрхийн тухай ойлголтыг хэрхэн нэгтгэж зааж болох талаар булангийн аргаар ажилласны эцэст багш нар бүлгээр ажиллаж өөр өөрсдийн мэргэжил дээр нийт 94 сэдвээр нэгж хичээлийн төлөвлөгөөг хамтран боловсруулж бүлгээр ажиллан олон сайхан



санааг дэвшүүлэн гаргаж түүнийгээ хэлэлцүүлсэн нь сургалтын нэг чухал үр дүн болсон юм.

Үүнийг хичээл бүрээр авч үзвэл:

Хичээлийн нэр	Сэдвийн тоо
Бага ангийн хичээлээр	11
Дуу хөгжмийн хичээлээр	5
Биеийн тамирын хичээлээр	2
Дүрслэх урлагийн хичээлээр	3
Математикийн хичээлээр	16
Монгол хэл-Уран зохиолын хичээлээр	15
Түүх-Нийгмийн ухааны хичээлээр	20
Байгалийн ухааны хичээлээр	19
Англи хэлний хичээлээр	2
Экологийн хичээлээр	1
Нийт	94

Багш нар шинжлэх ухааны суурь ойлголтуудыг хүний эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтүүд, бодит байдалтай холбон заах боломжтой төдийгүй энэ нь амьдралд ойр, суралцагчдын эрэлт хэрэгцээг хангасан бүтээлч арга зүй болдгийг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрч дэмжиж байлаа. Багш энэ арга зүйг эзэмшиж хэрэгжүүлсэнээр суралцагчид нь түүх, нийгэм, байгалийн ухаан, математикийн хичээлээр өөрийн орны инфляцийн түвшинг тодорхойлж, улс орныхоо хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийг тооцон ядуурлын түвшин, ажилгүйдлийн коэффициентийг бодож энэ нь хүний эрх, үүргийн заалтуудтай хэрхэн холбогдож байгааг дүгнэн эрх үүргийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж сурах чадваруудыг бодитоор эзэмших боломжтой болгоход зохих үр дүнгээ өгөх юм байна гэдэгт санал нэгдэж байсан юм.

Ийнхүү сургалтанд оролцогсод манай сургалтыг цаг үеэ олсон чухал сургалт боллоо гэж өндрөөр үнэлж, багш нар шинжлэх ухааны суурь ойлголтуудыг хүний эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтүүд, бодит байдалтай холбон заах боломжтой төдийгүй энэ нь амьдралд ойр, суралцагчдын эрэлт хэрэгцээг хангасан бүтээлч арга зүй болдгийг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрч дэмжиж байлаа. Багш энэ арга зүйг эзэмшиж хэрэгжүүлсэнээр суралцагчид нь түүх,

нийгэм, байгалийн ухаан, математикийн хичээлээр өөрийн орны инфляцийн түвшинг тодорхойлж, улс орныхоо хөгжлийн нэгдсэн үзүүлэлтийг тооцон ядуурлын түвшин, ажилгүйдлийн коэффициентийг бодож энэ нь хүний эрх, үүргийн заалтуудтай хэрхэн холбогдож байгааг дүгнэн эрх үүргийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж сурах чадваруудыг бодитоор эзэмших боломжтой болгоход зохих үр дүнгээ өгнө гэж сургалтыг өндрөөр үнэлж байлаа.

Сургалтыг юу гэж үнэлэв?

Сургалтанд оролцогсдоос өгсөн үнэлгээг нэгтгэж үзвэл:

Сургалт семинарын зорилго ямар түвшинд хангагдав? гэсэн асуултанд маш сайн гэж 91.2% нь хариулсан байлаа.

Сургалтын гарын авлага материал хэр түвшинд хангагдав? гэсэн асуултанд маш сайн гэж 98.2% нь хариулсан байна.

Сургагч багшийн заах арга барил хэр ойлгомжтой байв? гэсэн асуултанд маш сайн гэж 95.2% нь хариулсан байна.

Сургалт таны цаашдын ажилд хэр тустай болов? гэсэн асуултанд маш тустай гэж 93.3% нь хариулсан байна.

Та сургалтанд оролцсоныхоо дараа ямар шинэ зүйлс, үйл ажиллагаа явуулахыг хүсч байна вэ гэсэн асуултанд сургуулийнхаа бусад багш нарт энэ чиглэлээрээ сургалт явуулах болно гэж 277 хүн хариулсан байхад Хүний эрхийн тухай ойлголтыг хичээлдээ нэгтгэж заана гэж 421 хүн хариулсан байв.

Сургалтын үр дүнг сайжруулахын тулд цаашид юу хийх нь зүйтэй гэж бодож байна вэ гэсэн асуултанд 491 хүн сургалтыг цааш нь бүх багш нарт хүргэх нь зүйтэй гэж хариулсан байна.

Мөн сургалтыг зохион байгуулсан аймаг, нийслэлийн БСГ-аас ирүүлсэн албан тоотод бидний сургалтыг чухлаар үнэлж, Боловсролын Шинэчлэлийн тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд чухал алхам болох энэхүү сургалтын үзэл санааг бусад багш нарт хүргэж ажиллахыг биднээс хүссэн байлаа.

Мөн Дорнод аймгийн БСГ-ын цахим хуудсанд "...Сургалтанд оролцсон багш нар хичээл бүхэн хүний эрхийн шударга ёсны зарчмуудтай холбогдож



байвал бидний ирээдүй жинхэнэ хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулах туйлын зорилгодоо хүрэх боломжтой юм байна гэсэн дүгнэлтэнд хүрч цаашид их зүйлийг хийх, өөр олон багшид энэ сургалтыг хүргэх нь зүйтэй гэсэн хүсэлтэй байгаагаа Эмнести Интернэшнл байгууллагын сургагч багш нарт хэлж байлаа ..." гэж бичсэн байна. <http://www.dornod.mn/bsg/> хаягаар орж үзнэ үү.

Төслийн үзэл санааг олон хүнд хүргэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг орон нутгийн боловсролын байгууллага, ҮЭ-ийн байгууллага, ЕБС, хамт олноос хүлээж аваад байна.

Монголын Багш нарын Гэгээрэл Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны хүсэлтээр манай сургагч багш нар ЕБС-дын үйлдвэрчний хороон дарга нарын дунд нэмэлт 1 удаагийн сургалтыг 34 хүнд явууллаа.

"Боловсролын Шинэчлэл-Иргэний Нийгмийн Байгууллагуудын Оролцоо" сэдэвт уулзалт ярилцлагад оролцогчид болон БСШУЯ-аас зохион байгуулсан "12 жилийн ЕБС-ийн сургалтын тогтолцоонд шилжих төлөвлөгөө" сэдэвт семинарт оролцогч мэргэжлийн судлаачид, бодлого боловсруулагчдад төслийн үзэл санаа, үр дүнг танилцуулан нийт 58 хүнд төслийн хүрээнд хэвлэгдсэн ном гарын авлагыг хүргэж ажиллалаа.

Мөн 2007 оны 4 дүгээр сард БСШУЯ-аас зохион байгуулах сурах бичиг зохиогчдод зориулсан сургалтанд сургагч багшаар ажиллах саналыг хүлээж аваад байна.

Үр дүн:

- Сургалтанд хамрагдсан нийт 763 оролцогчид хүний эрхийн боловсролын гарын авлага, материалаар хангагдлаа.

- Сургалтанд хамрагдагсад ХЭБ-ын талаархи мэдлэг чадвараа дээшлүүлж, тэдний эрхэд суурилсан боловсролын талаархи мэдлэг, чадварыг нь нэмэгдүүлснээр хүүхдийг хөгжилд хүргэх боловсролын таатай орчин бүрдүүлэхэд хувь нэмэр боллоо.

- Байгууллагын сургагч багш нарын чадавхи дээшилж, ЕБС-ийн багш нарт зориулсан ХЭБ-ын сургалтын хөтөлбөр боловсрогдлоо.

Манай төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь суралцагчдад хувь хүнийх нь хувьд болон нийгмийн эрэлт хэрэгцээнд нь тулгуурласан Чанартай боловсрол эзэмшүүлэхэд нэн тулгамдаад байгаа багш нарын арга зүйг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн бүх хичээлүүдийн хэрэглээний агуулга, цогц чадамжид суурилсан мэдээллийг хүний эрхийн суурь зарчмуудтай холбон авч үзсэнээр сурагчид бусдыг хүндэтгэж, хариуцлага мэдэрч, өөрийн эрхээ хэрэгжүүлэх чадвартай болгоход оршиж байлаа. Энэ ч утгаараа манай төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь багшийг хөгжүүлэх, тэдний сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, хүүхдэд эрхийн мэдрэмжийг хөгжүүлэх, хүний эрхэд тулгуурласан сургалтын таатай орчин бүрдүүлэхэд

зохих хувь нэмэр боллоо гэж Монголын Эмнести Интернэшнл үнэлж байна.

Мөн түүнчлэн Боловсролын стандарт, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого, 12 жилийн ЕБС-ийн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр боловсруулах, 12 жилийн сургалтанд хэрэглэх сурах бичгийн талаар хэлэлцэгдэж байгаа өнөө үед манай сургалтын үзэл санаа зохих хувь нэмрээ оруулсан гэж үзэж байна.



"Хорих байгууллагын боловсрол" төсөл

Монголын Эмнести Интернэшнл нь бие даан болон бусад байгууллагатай хамтран хорих байгууллагуудад тодорхой үйл ажиллагаа, сургалтуудыг зохион байгуулж ирсэн билээ. Бидэнд хорих ангид ял эдлэж буй хүмүүсийн дунд явагдах сургалт, мэдээллүүд зөвхөн тодорхой нэг хүрээнд баригдсан хязгаарлагдмал, номын сан болон бусад мэдээллүүд дутмаг байдаг нь ажиглагдаж байсан юм.

Тиймээс 2006 онд Канад сангаас санхүүжигдсэн "Хорих байгууллагын боловсрол" төслийг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлж дуусгалаа.

Төслөөр "Амьдрал ба эх дэлхийн мэдээлэл" хэмээх BBC World сувгийн цуврал 156 баримтат киног хувилан цахим номын санг бүрдүүлж, тоног төхөөрөмжийн хамт хорих байгууллагуудад бэлэглэн, хорих ангид номын сан байгуулагдах эхлэлийг тавих, тодорхой нэр бүхий киног ашиглан сургалт хэлэлцүүлгийг хэрхэн явуулах талаархи гарын авлагыг боловсруулж гаргах, хорих байгууллагын нийгмийн ажилтны ур чадварыг





дээшлүүлэх зорилгыг тавьсан юм. Монголчуудын ахуй амьдралд ойр дөхөмийг харгалзан үзэж шинээр Монголын тухай 2 киног орчуулан хувилсан юм.

Сургалтын гарын авлага бэлтгэх багийг 5 хүнтэйгээр байгуулж ажилласан бөгөөд гарын авлагыг бэлтгэх шатандаа дахин сайжруулах үүднээс Тоосгон буюу ШШГЕГ-ын харьяа 409-р хорих ангид туршилт сургалт явуулж, цаашдын үйл ажиллагаандаа үр дүнг хэрэгжүүлэв. Мөн гарын авлагыг Англи хэлнээ хөрвүүлэн төслийн зөвлөх Луис Ламберт, Английн сайн дурын ажилтан Карл нарт уншуулан зөвлөгөө авч, санал сэтгэгдлийг нь сонсов.

Ийнхүү гарын авлагыг чанартай хэвлэн гаргах гэж нилээд цаг хугацааг алдсан юм.

Хэдийгээр товлосон хугацаанаас 4 сараар хоцорсон боловч төсөл өөрийн тавьсан зорилгодоо хүрсэн бөгөөд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад цаашид хийх ажлын олон санааг өгч, зарим зүйлд анхаарч ажиллахыг сургаж, туршлагажуулснаараа үр дүнтэй боллоо.

Сургалт ярилцлагыг зохион байгуулсан хэлбэр нь оролцогчдыг бүрэн хамруулж, сонирхолтой болгож чадсанаас гадна ял эдлэж буй хүмүүсийн итгэлийг сэргээж, тэдний асуудалд хандах хандлагад тодорхой хэмжээгээр өөрчлөлт хийж, хорих байгууллагын сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, ажилтнууд, тэр дундаа нийгмийн ажилтнуудыг чадавхижуулсан нь төслийн нэг томоохон амжилт байлаа. Хорих ял эдлэгсдийн нас харьцангуй залуужиж, бичиг үсэг тайлагдсан байгаа нөхцөлд цахим байдлаар мэдээлэл хүргэх, кино хэлэлцүүлэг хийж байх нь ач холбогдол, нөлөөлөл, хүртээмж ихтэй нь хүмүүсийн үнэлгээний хуудаснаа ихээр тэмдэглэгдсэн байлаа.

Тиймээс бидний ажил зорилтот бүлэгтэй хүрч чадсаныг илтгэн харуулж байна.

Сургалтанд оролцогчид киноны агуулга, үзэгдлээс санаа авч өөрсдийн сэтгэгдлээ илэрхийлж, тухайн орон нутаг, өөрийн хорих ангидаа тулгарч буй бэрхшээлийг яаж шийдвэрлэх, амьдралд хэрэгжүүлж болох олон санааг дэвшүүлэн тавьж байсан нь төслийн үр дүнд хүрээд зогсохгүй цаашид ихээхэн

Үр нөлөөтэй болохыг харуулж байна.

Тус төслийн үйл ажиллагаа санал санаачилгыг дэмжиж НҮБХХөтөлбөрөөс дэмжлэг үзүүлж 21 хорих ангид олгох 158 киног үнэгүй хувилж өгсөн тул бид

төслөөс хэмнэгдсэн 4744 ам долларыг Канад санд эргүүлэн шилжүүлж, төслийн тайланг хүргүүлэв.

“Хүч ба гал зэвсэг хэрэглэх нь” төсөл



Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь төслийн 2 дугаар үе шатыг Монголын Эмнести Интернэшнл байгууллага амжилттай хэрэгжүүллээ. Энэ шатанд өмнө нь бэлтгэн гаргасан “Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь” цагдаагийн гарын авлагыг цагдаагийн байгууллага, цагдаагийн алба хаагчдын хүсэлтээр дахин 5000 хувь хэвлүүлж орон даяарх цагдаагийн алба хаагчдад тараах, нийслэлийн хэлтэс, дүүргийн цагдаагийн газрын дэд дарга, сургалт хариуцсан менежер зэрэг 50 гаруй хүнд сургалт явуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх явдал байсан юм. Монголын Интернэшнл гарын авлагыг дахин хянаж, 2 дахь хэвлэлийг 5000 хувь хэвлэн Цагдаагийн байгууллагын дарга нарын нэгдсэн цугларалтын үеэр тараалгахаар Цагдаагийн байгууллагын Ерөнхий газрын дарга хурандаа М.Ганболдод гардуулан өгөв.

Ном гардуулах ёслолд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол улсад суугаа элчин сайд Кристофер Осборн өөрийн биеэр байлцлаа. Тэрээр Монгол улсын цагдаагийн байгууллагын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хүний эрхийг хангаж ажиллахад нь хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, уг гарын авлага тодорхой хэмжээнд ач холбогдлоо өгнө гэдэгт итгэж байгаагаа хэлсэн юм. Гарын авлагын 3500 гаруй хувийг хөдөөгийн орон нутгийн цагдаа нарт тараасан болно.

Мөн гүйцэтгэх захирал Б.Алтантуяа Монголын Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын сүлжээний төлөөлөгч нартай хамтран цагдаагийн байгууллагын даргатай уулзалт хийж аюулгүй байлын талаар асуулга тавьж хариуг авав.



Сургалтанд оролцсон цагдаагийн сургалтын менежерүүд сургалтын арга барил, хэлэлцүүлгийн ач холбогдлыг өндөрөөр үнэлж



байсан ба цаашид Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас уг гарын авлага үнэхээр хэрэгтэй бөгөөд цагдаагийн алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанарыг сайжруулахад тус болно гэдэгт итгэж байгаагаа өгүүлсэн юм. Мөн сургалтанд Цагдаагийн Академийн захирал асан Батаев оролцож энэ гарын авлага нь цагдаагийн алба хаагчдын хэрэгцээ шаардлаганд хэрхэн нийцэж байгаа талаар ярьсан юм. Сургалтанд оролцогч олон нийтийн үймээн самууны үеэр цагдаагийн алба хаагчид хэрхэн ажиллах талаар ихээхэн үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Мөн цаашид ганц цагдаагийн байгууллагын ажилтнуудад бус иргэдэд зориулсан гарын авлага гаргавал, цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний мэргэжлийн ур чадварыг сайжруулахад чухал түлхэц болно гэдгийг онцолж байсан юм. Энэ нь биднийг цаашид Хүч ба галт зэвсгийн 3 дахь шатыг хэрэгжүүлэхэд хүргэсэн билээ.

Хүч ба галт зэвсгийн 3 дахь шатанд бид Иргэн тантай цагдаа яаж харьцах вэ гарын авлагыг бэлтгэж, 10 мянган хувь хэвлэн хот хөдөөгийн иргэдэд тараахыг зорьсон юм. Цагдаагийн алба хаагчдад ганц хоёр удаа сургалт явуулах нь тийм ч үр дүнтэй тактик биш бөгөөд цагдаагийн үйл ажиллагаанд ч иргэний нийгмийн хяналтыг бий болгох нь ихээхэн үр дүнтэй байдаг билээ.

Иргэн тантай гарын авлага нь Цагдаа иргэн хүнтэй харилцах үйлчилгээний стандарт ямар байдаг вэ, иргэн та юу анхаарах вэ, зөрчил гарсан үед хамгийн түрүүнд хэнд хандах вэ гэдгийг багтаасан цогц нарын авлага бөгөөд иргэдэд зориулсан маш энгийн үг хэллэгээр бичигдэж, зургаар илэрхийлснээрээ хүнд хүрсэн гарын авлага болсон юм.

Гарын авлагыг цагдаагийн хэлтэс дүүргийн ойролцоо явж буй иргэд, хүн олонтой газар болон хөдөө



орон нутгийн иргэдэд тараасан болно. Гарын авлагыг тараахад хүний эрхийн ТББ-ууд ихээхэн идэвхи чармайлттай оролцсон бөгөөд өөрсдийн үйл ажиллагааныхаа үеэр иргэдэд тараах хүсэлтээ манай байгууллагад тавьж байсан юм.

Гарын авлагад орсон мэдээлэл нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан мэдээллүүд орсон болохыг иргэдийн санал хүсэлтээс дүгнэж болохоор байлаа.

Залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын зуны сургалт



Хүний эрхийн боловсрол нь залуучуудад эрхээ мэдэх, эрхийнхээ төлөө тэмцэхэд нь гол хэрэгсэл болдог. Үүний нэг үлгэр нь залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын зуны сургалт боллоо.

Энэхүү сургалт нь Монголд анх удаа залуучуудад зориулсан Хүний эрхийн зуны сургалт боллоо. 2007 оны 7 дугаар сарын 16-31 –ний өдөр Улаанбаатар хотоос холгүй орших Нарс зусланд хөтөлбөрийг хэрэгжүүлэв. Оролцогчдыг Монголын Эмнести Интернэшнлээс 40 оюутан сурагчдыг сонгон орлуулав. Тэд 10-23 насны хот, хөдөө орон нутгаас ирсэн байлаа.

Сургалтын гол зорилго нь залуу удирдагч нарт хүний эрхийн талаар ойлголт, түүх болоод философийн талаар өргөн хүрээний боловсрол олгоход байлаа. Үүний зэрэгцээ өөрийн орны болоод гадаадын хүний эрхийн асуудлын талаар сурч мэдэх боломжийг олгож олсон мэдлэгээрээ нөлөөллийн төсөл хийх зорилт байсан юм.

Сургалтанд семинар хийх, зочин төлөөлөгчтэй уулзах, төсөл бичих, кино болон урлагаар суралцах арга барилыг хэрэглэв. Хөтөлбөрийн турш Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)-д заасан бүр эрхүүд хүн төрөлхтөнд бодитойгоор түгээмэл хүрч байгаа эсэх сэдвээр хэлэлцэв.

Сургалтын эхний долоо хоногт оролцогчид Их дээд сургуулийн болон Ерөнхий боловсролын сургуулийн анги болон хоёр хуваагдаж ажиллав. Анги бүр өдөрт хоёр цагийн адилхан сэдвээр хичээл хийж байсан ч их дээд сургуулийн оюутнуудад илүү их унших даалгавар өгч хэлэлцүүлэх замаар хичээллэж байлаа. Харин сурагчдын хичээлээр илүү дасгал ажиллаа. Оюутнуудын хичээл өглөө орж үдээс

хойш нь сурагчиддаа туслаж, зааварлан хэлэлцүүлгийг явуулж байлаа. Эхний долоо хоног нь хүний эрхийн салшгүй, харилцан хамааралтай болон хуваагдашгүй шинжийн талаар хэлэлцлээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас гадна Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт болон Эдийн засаг нийгэм соёлын эрхийн пактын тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн конвенцийг тухайлан судлаж ярилцав. Эрх бүр хувь хүнд хамраалтай ч Хүний эрхий түгээмэл тунхаглалын хүчээр бүх эрх эдлэгдэж байж өөрчлөлтийн авчирдаг гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Хүний эрхийн түүх, НҮБ, Төрийн бус буюу иргэний нийгмийн үүрэг, хувь хүмүүсийн үүрэг хариуцлагын талаар үзэж судлав. Чухал хичээлүүдийг монгол хэлээр орчуулан оров.

Хоёрдахь долоо хоногт сурсан мэдсэнээ бататган бие даасан даалгавар хийж, бүлгээр ажиллах замаар ажиллаа. Энэ үл ажиллагаанаас сурсан ур чадвар нь асуудал болон түүний үндсэн шалтгааныг тодорхойлох, тухайлсан нөхцөл байдалд хувь хүний үүднээс үүнтэй хэрхэн тэмцэх вэ, юмыг олон талаас нь олж харах, зөрчлийг шийдвэрлэхдээ хэрхэн үнэлж, хэрэгжүүлэх вэ гэсэн ур чадварыг эзэмшлээ. Эцсийн төслийг бичихдээ их дээд сургуулийн оюутан бүр нэг сурагчтай хамтран өөрийн нийгэмдээ хэрэгжихгүй байгаа нэг эрхийг сонгон танилцуулж шийдвэрлэх арга замыг тодорхойллоо. Энэ үйл ажиллагааны зорилго нь хүний эрхийг өдөр тутмын үйл хэрэг болон өөрийн мэдэх түүх, мэдээлэлтэй холбож сурахад байлаа. Оюутнуудын илтгэл энэхүү номын гол бүлэг болно.

Сургалтын хөтөлбөр нь оролцогчид хүний эрхийн асуудлыг өөрийн мэдлэг туршлагатайгаа холбож өөрсдийн нь зан хандлага тухайн нөхцөл байдлыг өөрчлөх чадалтайг таньж, ингэснээр төгс нийгмийг цогцлоон бүрдүүлэхийн төлөө хүсэл эрмэлзэлтэй ажиллаж, амьдарч чадахыг ойлголоо.

Энэхүү зуны сургалтыг АНУ-ын Тринити коллежийн дэмжлэгтэй явууллаа. Төрөл бүрийн салбар, орон нутгаас ирсэн энэ 40 оролцогчийг Эмнести Интернэшнл одоо хүний эрхийн зүтгэлтэн гэж үзэж байгаа юм. Учир нь тэдний өрнүүлж байгаа үйл ажиллагаа бүхэн амжилтыг дагуулж байгаа билээ. Сургалтанд оролцсон даруйд хүртэл Скаутын

холбооны олон улсын Жемборид оролцож хүний эрхийн өртөөг ажиллуулсан юм.

Хичээлийн жил эхэлснээс хойш Дарфур, Хятадын хүний эрхийн хамгаалагч Гао Зишен, Азербайжаны эрүүдэн шүүгдсэн залуучууд төлөө болон Бирмийн төлөө дэлхий даяар өрнөсөн хоёр ч удаагийн жагсаалыг зохион байгуулж 1500 гаруй гарын үсгийг тус улсын эрх баригч нарт илгээсэн байна. Үүнээс гадна хүүхэд залуусын дунд хүний эрхийн талаар хэлэлцүүлэг, яриаг хийжээ.

Хүний эрхийн боловсролын онлайн сургалт

11 дүгээр сарын 15 -12 дугаар сарын 10-ны өдрийг хамарсан нийт 8 долоо хоногийн залуучуудад зориулсан хүний эрхийн боловсролын олон улсын онлайн сургалтанд Эмнести Интернэшнлийн гишүүд, ЕБС-ын сурагчид бүхий 15 залуус оролцлоо. Тус сургалтанд АНУ, Герман, Морокко, Монгол улсаас 15-25 насны залуучууд оролцож байна. Тус сургалт нь интернэтийн эх үүсвэрийг ашиглан оролцогчид өөрсдөө судалгаа, шинжилгээ хийн хүний эрхийн боловсролыг олж байгаагаараа онцлог юм. Энэ сургалтын үр дүнд 10 шинэ гишүүн нэмэгдлээ.

Хүүхэд залуучуудад зориулсан зургийн болон зохион бичлэгийн уралдаан

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ)-ын 60 жилийн ойг тохиолдуулан Багш нарын бүлгээс Ерөнхий боловсролын сурагчдын дунд “ ХЭТТ –ийн 60 жил-Бидний амьдралд” сэдэвт зургийн болон зохион бичлэгийн уралдааныг 11 дүгээр сарын 16-аас 12 дугаар сарын 10-ны хугацаанд явууллаа.

Уралдаанд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Зуунмод хотын сургуулийн 70 гаруй сурагч оролцсон байна.



ХЭВЛЭСЭН МАТЕРИАЛ

Цахим хуудас

МЭИ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллүүдийг багтаасан Англи, Монгол хэлээр бэлтгэсэн цахим хуудас www.amnesty.mn хаяг дээр байрлаж байна. 2007 онд Англи вэб хуудсыг мэдээллээр баяжуулан, Монгол хэл дээрх цахим хуудсанд шинэ мэдээ мэдээллийг байнга оруулан шинэчиллээ.

Олон улсын төвөөс олон жилийн судалгааны үр дүнд тод шар өнгө нь итгэл найдвар, шударга явдлыг илэрхийлдэг болохыг тодорхойлон гаргаж ирснээр энэхүү өнгийг бэлэг тэмдэг болгон хэрэглэж байхаар тогтсон билээ. Тиймээс Нэг-Эмнести нэг төрхийг илтгэх уг шар өнгийг бүх хэвлэл мэдээл, цахим хуудсандаа хүртэл тусган хэрэгжүүлж байна.

Мөн Азийн хэлний чиглэлээр болон бусад төслийн хүрээнд орчуулан бэлтгэсэн The Wire сар тутмын сонин, Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь, Хүний эрхийн боловсрол сонин, 2006 оны үйл ажиллагааны тайлан, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 14 зүйлт хөтөлбөр, Хүний эрх сургалтын хөтөлбөрт зэрэг ном сонингуудыг PDF файлын буланд нэмж орууллаа. Бирмийн жагсагчдын төлөө ном хурав, Монголын Эмнести Интернэшнл байгууллагын шинэ дүрэм, Эмнести Интернэшнлийн тайлан 2007, Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчдэд, цаг болон мэдлэгээ хандивлагч сайн дурын ажилтнууд, Цаазаар авах ялын эсрэг өдөр Монголд, Цаазаар авах ялыг зогсооё: Дэлхий нийтээр халсан байдал, Хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулагч байгууллагууд, Цаазаар авах ялын судалгааны тайлан, Гуантанамог хаах аялалд нэгдэцгээе, Хүний Эрхийн Боловсрол - Чанартай Боловсролын нэг үндсэн бүрэлдэхвэн хэсэг, Шинэ жилийн мэндчилгээ худалдаалж байна, Руанда улс цаазаар авах ялыг халлаа, Эрхийнхээ төлөө шуугицгаая, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 62 дахь Чуулган: Дэлхий нийтээр цаазаар авах ялын гүйцэтгэлийг хойшлуулах нь, Яаралтай Үйл Ажиллагааны Сүлжээ, Бирм улсад олон зуун лам нар, жагсагчдыг баривчиллаа, Түүхэн амжилт - Цаазаар авах ялын гүйцэтгэлийг дэлхий нийтээр хойшлуулах тухай НҮБ-ын тогтоол, Хүний эрх ба интернэтийн асуудлаарх олон талт санаачилгад Эмнести Интернэшнл нэгдлээ, Цаазаар авах ялын талаарх тоо баримт, Цаазаар авах ялын эсрэг дэлхий нийтийн тэмцэл, Эмнести Интернэшнл Монгол улсад зэрэг хэвлэлийн олон мэдээ мэдээллүүдээр цахим хуудсаа баяжууллаа.

“Хүнийг Хүндэтгэе” танилцуулга

Хүний нийгмийн аливаа салбарт шинэ хаалга, шинэ үүрэг хариуцлага, шинэ бодлогыг бий болгохыг шаардаж буй энэ даяарчлалын үед хүний эрхийн асуудал ямарваа сөрөг байдлаар хөндөгдөх ёсгүй юм.

Эмнести Интернэшнл хүний эрхийг эдлэхэд амин чухал шаардлагатай үйлчилгээг хүн амд хүргэх асуудлыг туйлын чухал зүйл хэмээн үздэг.

Харин өнөөдөр дэлхийн өнцөг булан бүрт сая сая хүмүүс хүний эрхийн асар олон төрлийн зөрчлийн үүднээс зовж амьдарч байна. Баян ядуу аль ч оронд хүмүүс зохистой орон байраар хангагдахгүй, шаардлагатай эмнэлэгийн тусламж авч чадахгүй, сурч боловсрох зэрэг наад захын эрхээ эдэлж чадахгүй байгаа байдал байсаар байна. Үүнд нөөц бололцоо дутмаг хэмээн байнга шалтагладаг засгийн газруудын бодлого, үйл ажиллагаа ч мөн буруутай билээ.

Хүн бүрт дээр өгүүлсэнчлэн эдийн засаг, нийгэм, соёлын болон иргэний, улс төрийн эрхтэй байдаг. Иймээс Эмнести Интернэшнл энэхүү эрхийн төлөө тэмцэж буй хүний эрхийн байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллаж эдгээр эрхүүдийг нь хүмүүст танилцуулах зорилгоор тус гарын авлагыг хэвлүүлээ.

“Хүний эрхийг хамгаалагчид”

“Хүний эрхийг хамгаалах эрхийг баталгаажуулах нь” цуврал гарын авлага

Хүний эрхийг хамгаална гэдэг бол нэр төртэй ариун үйлс гэдгийг хэн боловч хүлээн зөвшөөрнө биз ээ. Гэвч хүний эрхийн зөрчлийн дийлэнх хэсэг нь хүний эрхийг хамгаалагчдын эсрэг чиглэгдэж байгаа нь тэдний үүрэг, үйл ажиллагааны ач холбогдлыг нь дэмжих, мөн эрсдлээс хамгаалах талаар олон зүйл шаардлагатай байгааг харуулж байна.

Иймээс энэхүү гарын авлага нь хүний эрхийг хамгаалагчдын үнэлж баршгүй үйл хэргийг нь дэмжих зорилгоор төр захиргааны байгууллага, үндэсний болон олон улсын байгууллагууд, хувийн хэвшил төдийгүй хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал, гүйцэтгэж буй үүргийн талаархи мэдээллийг түгээж байдаг сэтгүүлчид болон бусад хүмүүст зориулагдсан юм.

Тус гарын авлагад “Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих талаар хувь хүн болон нийгмийн бүлэг, байгууллагын эрх үүргийн тухай тунхаглалын тухай товч дүгнэлтийг багтааснаас гадна НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгчийн үйл ажиллагаа, ажлын арга хэлбэрийн талаар танилцуулсан юм.

Хүний эрхийг хамгаалагчдын тухай тунхаглалд хүн бүр хүний эрхийг хамгаалах хөхиүлэн дэмжинэ



хэмээн заасан. Тийм ч учраас энэхүү гарын авлага нь хүний эрхийн төлөө тэмцэгч хамгаалагчдад ихээхэн дэмжлэг болно гэдэгт итгэл төгс байна.

Хүний эрхийн боловсрол- сонин бичгийн тусгай дугаар



Эмнести Интернэшнлээс Хүний эрхийн боловсролд зориулж зохион байгуулсан үйл ажиллагааны талаар дурдсан тусгай дугаарыг эрхлэн гаргалаа.

Хүний эрхийн боловсрол нь бие хүн, нийгмийн бүлэглэлд олон улсын хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн зарчимд нийцсэн мэдлэг чадвар болон хандлагыг бий болгох замаар тэднийг

хүчтэй болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

Энэ үзэл санааны үүднээс Эмнести Интернэшнл нийгмийн олон салбарт хүрч хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор явуулсан сургалтуудын талаархи мэдээллүүд энд багтсан юм. Тухайлбал хүний эрхийг уран зохиол, хөгжим урлагийн хичээл, бага ангийн хичээл, байгалийн ухаан, биеийн тамирын зэрэг хичээлүүдийг сургагч багш нар хэрхэн зохион явуулсан тухай мэдээлэлтэй танилцаж болох юм.

Хүний эрхийн боловсрол-Залуучуудын идэвхи санаачлага



Монголд анх удаа зохион байгуулж хэрэгжүүлсэн Залуучуудад зориулсан Хүний Эрхийн Боловсролын зуны сургалтын үр дүнд түшиглэн энэхүү гарын авлагыг Монголын Эмнести И н т е р н э ш н л э э с боловсруулан гаргасан юм.


Хүн болгон тэр бүр өөрсдөө ямар эрхтэйгээ мэддэггүй, энэ талаар бага

мэдлэгтэй нь эрхийнхээ төлөө тэмцэхдээ зоримог биш байдаг. Харин энэхүү номонд Хүний эрхийн түүх, НҮБ, Төрийн бус буюу иргэний нийгмийн үүрэг, хувь хүмүүсийн үүрэг хариуцлагын талаар залуустай ярилцаж тэдэнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пактын тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн тухай жишээ баримтаар тайлбарлан өөрсдөөр нь дүгнэлт гаргуулах замаар хүний эрхийн тухай ойлголтыг өгсөн тухай өгүүлсэн юм.

Ийнхүү эрхээ мэдсэнээр хэрхэн өөрийн нийгэмд хэрэгжихгүй байгаа эрхийн талаархи зөрчлийг арилгах, өөрсдийн зан хандлагыг мэдэж нөхцөл байдлаа өөрчлөх зорилго үзэл санааг залууст

төлөвшүүлэх зорилготой энэ ном таныг хүний эрхийн талаархи бодитой хийгээд сонирхолтой аянд хөтлөх байхаа.

“Эрүүдэн шүүж, зүй бус харьцахын эсрэг” танилцуулга



Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж ш и й т г э х и й г

хориглоно” гэж заасан байдаг.

Гэтэл хүний энэ эрхийг нь хөндсөн зүй бус явдал дэлхийн өнцөг булан бүрт байгаа нь сэтгэлд зовнил төрүүлсэн асуудал болж байна. Иймээс энэхүү гарын авлагаар эрүү шүүлт гэж юу болох, эрүүдэн шүүгчид гэж хэн болох тухай тайлбар болон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколыг танилцуулж байна.

Тэрчлэн эрүү шүүлтэд өртөж хохирогсдыг баримтаар өгүүлж энэ зүй бус байдалд Эмнести Интернэшнл ямар байр суурь баримталдагийг эндээс харж болно.

Кино хэлэлцүүлгээр амьдрах чадвар олгож, хандлагыг өөрчлөх нь



Эмнести Интернэшнл байгууллага нь Хорих байгууллагуудад ял эдэлж буй хvmvvсийн мэдлэг чадварыг дээшлүүлэх тэдний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхийн тулд Амьдрал ба Эх дэлхийн мэдээлэл хэмээх BBC Word сувгийн цуврал баримтат киногоор электрон номын сан бүрдүүлэх, энэхүү энгийн мэдээлэл дээрээ тулгуурлан

ашиглаж болох зарим чадварыг олгох сургалтыг зохион явуулах зорилготойгоор Хорих байгууллагын боловсрол төслийн хэрэгжүүлж байгаа билээ.

Тус төслийн хүрээнд хорих байгууллагын нийгмийн ажилтан, эмч хэн боловч ашиглан өөрсдийн зан үйл, хандлагыг хэрхэн өөрчлөх талаар баримтат кинонуудад түшиглэн сургалт явуулах боломжийг нээсэн гарын авлагаас олон сонирхолтой жишээ тайлбарыг уншиж үзээрэй.

Хорих байгууллагуудын боловсрол – Багшийн дэвтэр



ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН БОЛОВСРОЛ (Багшийн дэвтэр)



Монголын Эмнести Интернэшнл 2007 он

Энэхүү дэвтэр нь хорих байгууллагад сургалт явуулж буй нийгмийн ажилтан, албан хаагчид өөрсдийн үйл ажиллагааг хянах, сургалтын үйл ажиллагаагаа сайжруулахад зориулагдсан юм. Энэ дэвтэр нь хорих байгууллагын нийгмийн ажлыг ихээхэн хөнгөвчилсөн гарын авлага болсон гэдэгт бид итгэл төгс байна.


Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь Цагдаагийн алба хаагчдад зориулсан Үйл ажиллагааны гарын авлага 2 дахь хэвлэлт Иргэн тантай яаж харьцах ёстой вэ гарын авлага



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэний хяналт тавих, цагдаагийн алба хаагчдын үйлчилгээний чанарыг сайжруулах,

мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор уг танилцуулгыг хийсэн болно. Танилцуулгад Цагдаагийн үйлчилгээний жишиг хэмжээ, цагдаагийн үйлчилгээнд тавих хяналт тавих практик зөвлөмж, зүй бус үйлдэл хийсэн, хүч хэтрүүлэн хэрэглэсэн цагдаагийн ажилтны эсрэг гомдол гаргах арга зам, шаардлагатай үед холбоо барих утас, хаягийн жагсаалтыг багтаасан гарын авлага юм. Уг авлагыг 10000 хувь хэвлэж хот хөдөө, орон нутгуудаар тараасан болно.

Олимпын өмнөх үе: Хүний эрхийн амлалтаа биелүүлээгүй байна Тайлан



Бээжинд Олимпын тоглолт болоход 1 жил хүрэхгүй хугацаа үлдээд байгаа боловч Хятадын эрх баригчид 2001 оны 4 дүгээр сард Олимпын эрх авахдаа хэлсэн хүний эрхийн талаарх амлалтаа биелүүлээгүй байна. Тус орон даяар хүний эрхийн ноцтой зөрчлүүд гарсаар байгаа нь тогтворгүй байдлыг бий болгож, олны

дургүйцлийг төрүүлж байна. Орон нутгийн хүний эрхийн тэмцэгчид баривчлагдан хоригдож, хэвлэл мэдээлэл, интернэтийг албан ёсоор хянах нь улам

чангарч байна. Цаазаар авах ялыг хэрэглэхтэй холбоотой хууль, шүүхийн асуудалд нааштай өөрчлөлт орж байгаа боловч “хөдөлмөрөөр дахин хүмүүжүүлэх” болон бусад захиргааны шугамаар хорьж цагдах зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд байсаар байна.

Энэхүү тайлан нь Олимп болохоос өмнө Хятадад хүний эрхийн чиглэлээр яаралтай шинэчлэлт хийх талаар Эмнести Интернэшнл байгууллагын санаа зовниж буй хэд хэдэн асуудлыг хөндсөн юм. Үүнд цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа, захиргааны шугамаар баривчлан хорьж буй хүчирхийллийн хэлбэр, хууль бусаар баривчлан хорих, сэтгүүлч, өмгөөлөгч зэрэг хүний эрхийн төлөө тэмцэгчдийг эрүүдэн шүүх, заналхийлэх, интернэт хэрэглээг хянах зэрэг явдал юм. Хэрвээ Хятад улс хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулах амлалтаа хэрэгжүүлж гэвэл дээр дурдсан хүрээнд нааштай өөрчлөлт хийх нь чухал гэж Эмнести Интернэшнл үзэж байна.

Олимпын тоглолт болохоос өмнө яаравчлан хийх ёстой асуудал бүрээр тайлан гаргаж, тус бүрт нь зөвлөмж дагалдуулсан болно.

Луу, самбарууд Бүтээлч кампанит ажлын бүрэн заавар

Энэхүү ном нь кампанит ажлыг үр дүнтэй зохиоход өөрсдийн нөөц боломжоороо олонд танигдахаар хийх арга замуудыг зааж өгдөг юм. Тус номонд заасан аргууд нь амьдрал дээр Эмнести Интернэшнлийн гишүүд, дэмжигчдийн амжилттай хэрэгжүүлсэн шалгарсан туршлагауд юм. Номын зохиогч Дэн Жонс ч Того улсаас Монгол орон хүртэл дэлхийн олон оронд аялж туршлага судалсан уран бүтээлч, тэмцэгч билээ.

Олны анхаарлыг татаж тухайн хүний эрхийн нөхцөл байдлыг ойлгуулах 9 аргыг заасан нь нисдэг хөөрдөг зүйл бүтээх, самбар, уриа лоозонг бэлдэх, өмссөн хувцас, нүүх засал, чимэглэлээр, баг хүүхэлдэйгээр, жүжиг үзүүлбэрээр, дүрс сүүдрээр, хоол хүнсээр, яриа таниулгаар, интернэтээр, үзэсгэлэнгээр, дуу хөгжмөөр, киногоор сурталчилах арга техникийг үзүүлжээ.

Тус номыг Эмнести Интернэшнлийн цахим хуудсанд байршуулах төдийгүй сайн дурынханд зориулсан CD гарын авлагад багтаан хэвлэж хүний эрхийн төлөө тэмцэгчид, сайн дурынханд хүргэх гэж байна.

Хүний эрхийг иргэний боловсролоор сурах нь Багшийн гарын авлага

Хүний эрх, үнэт зүйл, түүнд хандах хандлагыг залууст заахад тэд өөрийнхөө төдийгүй бусдын эрхийг хамгаалах чадалтай болдог. Энэ бага зүйл биш билээ.

Эмнести Интернэшнл энэ гарын авлагыг багш нартаа зориулан, хүний эрхийн тухай ойлголтыг төлөвшүүлэхэд нь туслан хэвлэлээ. Та Дасгал гэх эхний хэсэгт хүний эрхийн цогц зургаан хичээл үзнэ. Дасгал бүрийг оюутнуудад тодорхой жишээ буюу



“ахуйд дөхөм” нөхцөл дээр тулгуурлан үндсэн ойлголтыг өгөх, цаашид хөгжүүлж болохуйцаар бэлдсэн юм. Тиймээс оюутан, сурагчид үүнийгээ орон нутагтаа, улсдаа, цаашлаад олон улсын хэмжээнд дэвжээн сэтгэж мэдлэгээ өргөжүүлнэ биз ээ. Дараагийн Түлхүү оролцох хэсэгт залуус ЭИ-ийн бүлгийг сургууль дээрээ

байгуулан, илүү идэвхтэй байж болохыг оюутнуудад тайлбарласан байгаа.

Ийм бүлэгтэй байх нь оюутнууд чөлөөт цагаараа хүний эрхийн асуудлаар ажиллах илүү боломжтой болно. Төгсгөл хэсэгт ЭИ-ээс гаргасан сурах бичиг, гарын авлага, тэдгээрийг хэрхэн захиж авах тухай нарийвчлан бичив.

Цаазаар авах ялын талаархи танилцуулга



Хүний хамгийн эрхэм эрх бол амьд явах эрх байдаг. Харин цаазаар авах ял бол энэ эрхэм эрхийг шууд үгүйсгэсэн хэрэг билээ. Иймээс дэлхий дээрх зарим орнуудад үйлчилсээр байгаа хүний эрхийг туйлаар зөрчсөн энэ ялын талаархи баримтуудыг болон Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас Монгол улсын цаазаар авах

ялыг хэрэглэж ирсэн байдалд хийсэн судалгааны үр дүнг уг танилцуулгаар илэрхийлсэн юм.

Цаазаар авах ял ба Хүний эрх судалгааны тайлан



Эл товхимолд Монгол улс дахь хүний амьд явах эрх ба түүний эрх зүйн баталгаа; Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэсэн байдлын судалгаа (Монгол улсын

хууль тогтоомж дахь цаазаар авах ял (түүхэн тойм); цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл; Монгол улсын дагаж мөрдөж буй 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял; цаазаар авах ял ба Монголын шүүхийн практик; цаазаар авах ялын дэлхий дахины нийтлэг чиг хандлага); цаазаар авах ялтай хэргийн Монгол улс дахь шүүн таслах ажиллагаа (цаазаар авах ялтай хэргийн мөрдөн байцаалт; цаазаар авах ялтай хэргийн шүүх хуралдаан; цаазаар авах ялыг давж заалдах эрх; цаазаар авах ялын талаархи уучлалт; цаазаар авах ялын хүлээлт; цаазаар авах ялын гүйцэтгэл) зэрэг асуудлыг хөндсөн болно.

Тэрчлэн цаазаар авах ялын талаар тандалтын судалгаа (социологийн судалгаа)-г мэргэжлийн хуульчид ба иргэдийн дунд явуулав. Энэхүү социологийн судалгааг Монгол улсын 21 аймаг ба нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 558 хуульч ба 4344 иргэд буюу өөрөөр хэлбэл, 5 мянга шахам хүний дунд явуулсан бөгөөд ийм томоохон хэмжээний судалгаа эрх зүйн салбарт урьд нь бараг хийгдэж байгаагүй болно. Эл судалгааны дүгнэлт болон бусад материал цаашдаа ч их хэрэг болно гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Орчин үеийн боолчлол ба хүний наймаа танилцуулга



Далай дамнасан боолын худалдааг устгаж, боолчлох ёсыг халсан тухай дунд сургуулийн түүхийн хичээлээр заадаг. Хэдий тийм боловч боолчлол шинэ

хэлбэрт орж өнөөг хүртэл оршин байгаа нь нууц биш юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон НҮБ-ын ажлын хэсгийнхний хийсэн судалгаагаар өнөөдөр дэлхий дээр 12 сая хүн боолчлогдож байгаа бөгөөд 2.4 сая хүн худалдаалагдсан байна. Энэ бол бага тоо биш.

Хүний наймаа бол орчин үеийн боолын худалдаа юм. Хүний наймаачид бусдыг хууран мэхлэж, эсхүл албадан тухайн хүнийг гэр орон, найз нөхдөөс нь хол газар аваачин албадан хөдөлмөр хийлгэж, хөдөлмөрийг нь мөлжөөд зогсохгүй, эрхшээлдээ байлгаж зүй бус харьцдаг.

The Wire сонин бичиг



Э м н е с т и
И н т е р н э ш н л
байгууллагаас сартулам Англи, Араб, Франц, Испани дөрвөн хэл дээр гардаг уг сонин бичгийг 1994 оноос эхлэн Монголын Эмнести Интернэшнл эх хэл дээрээ орчуулан гаргаж олны хүртээл болгож байгаа билээ. 2006 оноос эхлэн нэгдсэн хэвлэл

захиалгад орсон тул хувь хүн, албан байгууллага захиалан авч унших боломжтой. Жилийн захиалгын үнэ нь 12 фунтстерлинг, 18 ам.доллар, 21 евро байдаг уг сонинг эх хэлээрээ, бас тэгээд ердөө 1600 төгрөгөөр захиалж болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА АУДИТЫН ДҮГНЭЛТ

2007 оны санхүүгийн тайлан

Жилээс жилд Монголын Эмнести Интернэшнл байгууллагын үйл ажиллагаа, цар хүрээ өсөн нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй уялдан санхүүжилт ч өсч байна. Эмнести Интернэшнлийн Олон улсын Хөгжлийн багаас (ОУХБ) 2007 оны үйл ажиллагаанд зориулж 54747 \$-ийн санхүүжилтийг баталсан нь өмнөх оны баталсан төсвөөс 20 хувиар өссөн.


Мөн онд гадаад хэл дээр хэвлэгдсэн хүний эрхийн талаарх гарын авлага болон тараах материалуудыг эх хэлнээ хөрвүүлэн гаргах зорилго бүхий Азийн хэлний хөтөлбөрийн хүрээнд 9626 ам.долларын санхүүжилтийг олгосон.

2007 онд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжигч байгууллагууд болох Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Эмнести Интернэшнлийн “Зэвсгийг хянах” баг, НҮБ, АНУ-ын Тринити коллеж зэрэг байгууллагуудаас Хүний эрхийн боловсрол, зэвсгийг хянах кампанит ажилд зориулж нийт 19702 ам.долларын санхүүжилт олгосон.

Мөн хүний эрхийг хамгаалагчид, хандивлагчид, гишүүд, дэмжигчдийн хандив, тэдний зохион байгуулсан сан арвижуулах үйл ажиллагааны үр дүнд нийт 6603.28 ам. долларын хандивын болоод сан арвижуулсан орлого олсон билээ.


2007 онд шинээр шийдвэрлэсэн сан арвижуулалтын төлөвлөгөөний дагуу Монголын Эмнести Интернэшнл байгууллагын бүлгүүдээс нийт 875 ам.долларын сан арвижуулалт хийсэн бөгөөд энэ ажилд идэвхи, санаачлагатай ажилласан Залуучууд, Чөлөөт, Урлагын, Багш нарын бүлгийн нийт гишүүд болон бусад гишүүддээ талархсанаа илэрхийлэе.

Тус онд гишүүдийн татвар төлөлтөөс нийт 830 гаруй ам.долларын санхүүжилтийг бүрдүүлсэн байна.



2007 оны хувьд Монголын Эмнести Интернэшнл нь нийт санхүүжилтийн 7 орчим хувийг дотоодын хандивлагч, гишүүд, бүлгүүдийн хандив, хандивын хайрцаг, сан арвижуулах үйл ажиллагаагаар, 18 гаруй хувийг бусад санхүүжүүлэгч байгууллагын санхүүжилтээс бүрдүүлсэн байна.

2007 онд нийт 120639 ам.долларыг төлөвлөсөн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт зориулан зарцуулсан. Үүний 65.79 хувийг гол үйл ажиллагаа болох кампанит ажил, хүний эрхийн сургалт, түүнтэй холбоотой төсөл хөтөлбөрүүдэд, үлдсэн 30 гаруй хувийг цалин хөлс, хурал уулзалт, офиссын болон санхүүгийн зардлуудад тус тус зарцуулсан байна.



Нийт санхүүжилтийг 2006 онтой харьцуулахад буурсан мэт харагдаж байгаа нь өмнөх онд олон төслүүдэд санхүүжилт авсан бөгөөд тэдгээр төслүүдийн зарим нь энэ онд хэрэгжсэнтэй холбоотой юм. Харин түүнээс өмнөх онуудтай харьцуулахад санхүүжилт ерөнхийдөө өссөн үзүүлэлттэй байна.



2006 оны хөндлөнгийн аудитын тайлан

ЭГ-ЭМ-АУДИТ ХХК

Бүртгэл хяналтын итгэмжлэгдсэн байгууллага

2007 оны 1 сарын 4 10/0/08 Улаанбаатар 107

Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн Байгууллагын удирдлагад

Аудитын дэлгэц

Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн Байгууллагын 2006 оны 12 сарын 31-нээр төгсгөл бүртгэл нь хяналтгааны эрхэл, эрхэлтэй тайлан мэт, хэргийн баримттай баруулагчтай үйл ажиллагаагаар зүйт байна.

Аудит тайлангаарын мэдээлэл үнэн зөвөт тэр байгууллагын удирдлага эрхэлтэй. Өнөөх эрхэлтэй бол хэргийн баримттай үнэн зөвөт тайлангаартай тайлан дүгнэлт өгөх мэтэй юм.

Энэ дүгнэлт Шинэ үзэл санаагаар агуу болно. Санхүүгийн мэдээ, тайлангууд нэвтрүүлэг эрхэлтэй баруулагчтайгүй гүйц үнэн зөвөтэй мэдээлэл өгөх мэтэй тухай хуулийн талаарх баруулагч.

Аудит тайлангаар санхүүгийн тайлангийн ажил ажиллагаагаар хэргийн баримттай санхүүгийн мэдээ агуу зөвөт мэтэй, шийтэй гүйцэтгэл эрхэл мэтэй. Аудит ойлгох мэдээ хэргийн баримттай үнэн зөвөт тэр байгууллага дүгнэлт эрхэл мэтэй үнэн зөвөт болон бусад дүгнэлтэй эрхэлтэй байлаар нэвтрүүлэг байна.

Энэ Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн Байгууллагын 2006 оны 12 сарын 31-нээр эрхэлтэй санхүүгийн мэдээ үнэн зөвөтэй гүйц тэр дүгнэлт байна.



Брэвэлтэй эрхэлтэй

(Signature)

Ш.Сүхбат

2006 оны санхүүгийн хураангуй тайлан

САХЛАГ, ХӨНДЛӨНГИЙН ӨМӨГДӨМ НЭВТРҮҮЛЭГ	2006 оны 1 сарын 1 - 12 сарын 31	
	Төвөг	Бүтэц
Санхүүгийн		
Сэтгэл зүтгэлтэй үйл ажиллагааны эрхэлтэй	11,700.00	64,000.00
Өмчлөлтийн эрхэлтэй үйл ажиллагааны эрхэлтэй	41,700.00	4,000.00
Өмчлөлтийн эрхэлтэй үйл ажиллагааны эрхэлтэй - Бүтэц		
Бүтэц	8,000.00	80,000.00
ЭНГЭЛТ ХӨНДЛӨНГИЙНХЭНН ГҮЙЦ	11,700.00	11,000.00
Эрхэлтэй		
Сэтгэл зүтгэлтэй үйл ажиллагааны эрхэлтэй	1,000.00	1,000.00
Агуу түүхийн эрхэлтэй	1,700.00	1,700.00
Хүргэлт, өмч	20,000.00	20,000.00
Сэргээлийн санхүү	10,000.00	11,000.00
Бүтэцтэй өмч, тээвэр хэрэгсэл, баруулагч	24,000.00	20,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны эрхэлтэй	700.00	500.00
ЭНГЭЛТ ХӨНДЛӨНГИЙНХЭНН	11,000.00	64,000.00
Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн Байгууллагын	80,000.00	
Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн	10,000.00	
Өмчлөлтийн эрхэлтэй үйл ажиллагааны эрхэлтэй	8,000.00	
Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн		4,000.00
Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн		100.00
Мөнхтөл Шинэтэ Негерийнхэн		8,000.00



Брэвэлтэй эрхэлтэй

(Signature)

Т.Батбаяр



Брэвэлтэй эрхэлтэй

(Signature)

О.Мунуу-Батбаяр "ЭГ-ЭМ-АУДИТ" ХХК